

# "ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ХҮҮХДИЙН ОРОЛЦОО"

## Суурь судалгааны тайлан

Улаанбаатар хот  
2012 оны 12 сарын 21

Энэхүү суурь судалгааны ажлыг Японы Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар ХАРААТ БУС СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН (IRIM хүрээлэн) 2012 онд гүйцэтгэв. Тус тайлан нь зөвхөн судалгааны багийн гишүүдийн байр суурийг илэрхийлж буй болно.

**Судалгааны үндсэн баг:**

|                     |                              |
|---------------------|------------------------------|
| Төрбат ЭРХЭМБАЯР    | Төслийн зохицуулагч, судлаач |
| Түмэнжаргал ЭЛБЭРЭЛ | Төслийн судлаач              |
| Наранцацралт ЗОЛ    | Төслийн судлаач              |

**Зөвлөх:**

|                   |                |
|-------------------|----------------|
| Чүлтэмсүрэн ТАМИР | Төслийн зөвлөх |
|-------------------|----------------|

**Редактор:**

|            |  |
|------------|--|
| Ц. Золзаяа | “IRIM” судалгааны хүрээлэнгийн судлаач |
|------------|--|

**Мэдээлэл цуглуулсан судлаачид:**

|               |  |
|---------------|--|
| А. Мөрөн      | “IRIM” судалгааны хүрээлэнгийн судлаач |
| Т. Гоомарал   | “IRIM” судалгааны хүрээлэнгийн судлаач |
| Б. Батдаваа   | “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ судлаач    |
| Т. Амаржаргал | “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ судлаач    |

## АГУУЛГА

|  |           |
|--|-----------|
| <b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b> .....   | <b>5</b>  |
| <b>ДҮРСИЙН ЖАГСААЛТ</b> .....  | <b>6</b>  |
| <b>ТАЛАРХАЛ</b> .....  | <b>8</b>  |
| <b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР</b> .....   | <b>9</b>  |
| <b>НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР</b> .....  | <b>10</b> |
| <b>БҮЛЭГ 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....  | <b>13</b> |
| 1.1 Төслийн талаарх үндсэн мэдээлэл .....  | 13        |
| 1.2 Зорилго, зорилт .....  | 13        |
| 1.3 Зорилтот бүлэг .....   | 14        |
| 1.4 Судалгааны хамрах хүрээ .....  | 15        |
| 1.5 Судалгааны арга .....  | 15        |
| 1.6 Судалгааны түүвэр .....  | 17        |
| 1.7 Судалгаанд баримталсан зарчим .....  | 18        |
| 1.8 Судалгааны хязгаарлагдмал тал .....  | 18        |
| 1.9 Судалгааны боловсруулалт .....   | 18        |
| 1.10 Судалгааны хязгаарлагдмал тал .....   | 19        |
| 1.11 Судалгааны явцад гарсан бэрхшээл .....  | 19        |
| <b>БҮЛЭГ 2. ХҮҮХДҮҮДИЙН ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ОЙЛГОЛТ, ОРОЛЦООНЫ ТҮВШИН</b> ..... | <b>21</b> |
| 2.1 Судалгаанд оролцогсодын ерөнхий шинж байдал .....  | 21        |
| 2.2 Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин .....                                      | 23        |
| 2.2.1. Мэдээлэлгүй бүлэг .....   | 24        |
| 2.2.2. Бага зэрэг мэдээлэлтэй бүлэг .....  | 27        |
| 2.2.3. Мэдээлэл сайн бүлэг .....   | 30        |
| 2.3 Хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт .....  | 32        |
| 2.3.1. Буруу ойлголттой бүлэг .....  | 34        |
| 2.3.2. Бага ойлголттой бүлэг .....   | 35        |
| 2.3.3. Маш сайн ойлголттой бүлэг .....   | 36        |
| 2.4 Хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин .....   | 38        |
| 2.4.1. Хүүхдийн оролцоонд тулгардаг бэрхшээл, түүний шалтгаан .....                              | 41        |
| <b>БҮЛЭГ 3. ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....                             | <b>43</b> |
| 3.1 Хүүхдийн оролцооны түвшин .....  | 43        |
| 3.2 Гэр бүл дэх хүүхдийн оролцоонд тулгардаг бэрхшээл, түүний шалтгаан .....                     | 47        |
| 3.2.1 Тулгардаг бэрхшээл .....   | 47        |
| 3.3 Гэр бүл дэх хүүхдийн оролцоог сайжруулах арга зам .....                                      | 49        |
| <b>БҮЛЭГ 4. СУРГУУЛЬ ДАХ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....                            | <b>53</b> |
| 4.1 Хүүхдийн оролцооны түвшин .....  | 53        |
| 4.2 Сургууль дах хүүхдийн оролцооны арга, хэлбэр .....   | 57        |
| 4.3 Сургууль дах хүүхдийн оролцоонд тулгардаг бэрхшээл .....                                     | 58        |
| 4.4 Сургуулийн түвшинд хүүхдийн оролцоог сайжруулах арга зам .....                               | 60        |

|  |           |
|--|-----------|
| <b>БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛ ДАХ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> ..... | <b>61</b> |
| 5.1 Хорооны түвшинд хүүхдийн оролцоо .....   | 61        |
| 5.1.1 Хороонд хүүхдийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудлууд .....             | 63        |
| 5.1.2 Төлөвлөлт дэх хүүхдийн оролцоо .....   | 68        |
| 5.1.3 Хэрэгжилтийн хяналт дах хүүхдийн оролцоо.....                                | 70        |
| 5.2 Дүүргийн түвшин дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал .....                   | 72        |
| 5.2.1 Төлөвлөлт дэх хүүхдийн оролцоо .....   | 72        |
| 5.2.2 Төсөвлөлт дэх хүүхдийн оролцоо .....   | 73        |
| 5.2.3 Хэрэгжилтийн хяналт дах хүүхдийн оролцоо .....                               | 74        |
| 5.3 Нийслэлийн түвшин дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал .....                 | 76        |
| 5.3.1 Төлөвлөлт дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал .....                       | 78        |
| 5.3.2. Төсөвлөлт дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал .....                      | 80        |
| 5.3.3. Хэрэгжилтийн хяналт дах хүүхдийн оролцооны өнөөгийн байдал .....            | 82        |
| <br>   |           |
| <b>ДҮГНЭЛТ</b>   |           |
| <b>САНАЛ ЗӨВЛӨМЖ</b> .....   | <b>88</b> |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|  |    |
|--|----|
| Хүснэгт1: Судалгааны зорилтот бүлэг .....  | 14 |
| Хүснэгт 2: Судалгааны арга .....   | 15 |
| Хүснэгт3: Судалгааны арга ба түүвэр .....  | 17 |
| Хүснэгт 4: Судалгаанд оролцогсодын ерөнхий шинж байдал .....                                   | 21 |
| Хүснэгт 5. Мэдээлэлгүй бүлгийн ерөнхий шинж .....  | 25 |
| Хүснэгт 6. Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн ерөнхий шинж байдал.....                           | 27 |
| Хүснэгт 7: Мэдээлэл сайн бүлгийн ерөнхий шинж байдал .....                                     | 30 |
| Хүснэгт 8: Буруу ойлголттой хэсгийн ерөнхий шинж байдал .....                                  | 34 |
| Хүснэгт 9: Бага ойлголттой хэсгийн ерөнхий шинж .....  | 35 |
| Хүснэгт 10: Маш сайн ойлголттой хэсгийн ерөнхий шинж .....                                     | 36 |
| Хүснэгт 11: Хүүхдийн чуулга, уулзалтад хамрагдалтын хувь .....                                 | 40 |
| Хүснэгт 12: Рожер Хартын шатлалаар хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин.....                     | 40 |
| Хүснэгт 13: Зорилтот бүлгийн хүүхдүүдийн хорооны түвшин дэх оролцоо .....                      | 62 |
| Хүснэгт 14: Хорооны түвшинд хүүхдийн оролцоог дэмжих субъект .....                             | 64 |
| Хүснэгт 15: Хорооны төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээ .....                                    | 69 |
| Хүснэгт 16: Хорооны тайланд хийсэн дүн шинжилгээ.....  | 70 |
| Хүснэгт 17: Нийслэлийн түвшний төлөвлөлтийн үзүүлэлт, хувиар .....                             | 78 |
| Хүснэгт 18: Нийслэлийн түвшний төсөвлөлтийн үзүүлэлт, хувиар.....                              | 81 |
| Хүснэгт 19: Үйл ажиллагааны биелэлт, тайланг үнэлэх шалгуур үзүүлэлт, хувиар .....             | 83 |
| Хүснэгт 20: Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны төлөвлөлт ба биелэлт, хувиар..... | 83 |

## ДҮРСИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Дүрс 1: Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин .....                               | 23 |
| Дүрс 2: Хүүхдийн оролцох эрхийн мэдээлэл болон насны хамаарал.....                            | 23 |
| Дүрс 3: Зорилтот бүлгүүдийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин .....           | 24 |
| Дүрс 4: Мэдээлэлгүй бүлгээс дэвшүүлсэн хүүхдийн оролцоог бий болгох санал.....                | 26 |
| Дүрс 5: Мэдээлэлгүй бүлгийн хүүхдийн оролцооны түвшин .....                                   | 27 |
| Дүрс 6: Бага зэргийн мэдээлэлтэй бүлгээс дэвшүүлсэн хүүхдийн оролцоог бий болгох санал .....  | 28 |
| Дүрс 7: Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн оролцооны түвшин.....                                | 29 |
| Дүрс 8: Мэдээлэл сайн бүлгийн хүүхдийн оролцоог бий болгох талаарх санал .....                | 31 |
| Дүрс 9: Мэдээлэл сайн бүлгийн оролцооны түвшин .....  | 31 |
| Дүрс 10: Хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтын түвшин .....                               | 33 |
| Дүрс 11: Зорилтот бүлгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт .....                       | 34 |
| Дүрс 12: Буруу ойлголттой хэсгийн хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээллийн хүртээмж.....     | 35 |
| Дүрс 13: Бага ойлголттой хэсгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн хүртээмж .....    | 36 |
| Дүрс 14: Маш сайн ойлголттой хэсгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн хүртээмж..... | 37 |
| Дүрс 15: Хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин.....  | 39 |
| Дүрс 16: Хүүхдийн оролцооны байгууллагад хамрагдалтын хувь .....                              | 39 |
| Дүрс 17: Хүүхдийн оролцооны өнөөгийн ерөнхий түвшин .....                                     | 40 |
| Дүрс 18: Гэр бүл дэх хүүхдийн оролцооны түвшин /Рожер Хартын оролцооны шат /.....             | 43 |
| Дүрс 19 Зорилтот бүлгийн хүүхдүүдийн гэр бүлийн оролцооны түвшин.....                         | 45 |
| Дүрс 20 Гэр бүл дэх хүүхдийн оролцоог дэмждэг субъект.....                                    | 47 |
| Дүрс 21 Хүүхдийн байгууллагын талаарх эцэг эхийн мэдлэг.....                                  | 49 |
| Дүрс 22 Хүүхдийн гэр бүл дэх оролцоог сайжруулах арга зам /Хүүхдүүдийн тодорхойлсноор/.....   | 50 |
| Дүрс 23 Хүүхдийн оролцоонд тулгарч буй бэрхшээл /Эцэг эхийн тодорхойлсноор/.....              | 51 |
| Дүрс 24 Хүүхдийн оролцоог сайжруулах арга зам .....   | 51 |
| Дүрс 25 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоо .....  | 53 |
| Дүрс 26 Сургууль дахь хүүхдийн оролцооны түвшин / насны ангиллаар / .....                     | 54 |
| Дүрс 27 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоо / сургуулийн удирдлагын тодорхойлсоноор /..... | 55 |
| Дүрс 28 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцооны түвшин.....                                  | 57 |
| Дүрс 29 Сургуулийн орчинд дэмждэг субъект.....  | 58 |
| Дүрс 30 Сургуулийн түвшинд хүүхдийн оролцоог хангахад тулгарч буй бэрхшээл .....              | 59 |
| Дүрс 31 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоог сайжруулах арга зам.....                      | 60 |

|   |    |
|---|----|
| Дүрс 32: Рожер Хартын шатлалаар болон ерөний үзүүлэлтээр хүүхдийн оролцооны өнөөгийн байдал /12 – 18 насны хүүхдүүд/.....                     | 62 |
| Дүрс 33: Хүүхдийн санал бодлыг сонсох субъект.....  | 64 |
| Дүрс 34: Хүүхдийг хорооны төсөв, төлөвлөгөө, хяналтад оролцуулдаг эсэх /хорооны мэргэжилтэн/.....   | 66 |
| Дүрс 35: Хүүхдийг хорооны төсөв, төлөвлөгөө, хяналтад оролцуулдаг эсэх /фокус бүлгийн ярилцлагаас/.....                                       | 67 |
| Дүрс 36: Хорооны төлөвлөгөөнд хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төрлүүд /баримт бичгийн судалгаанаас/.....                                     | 69 |
| Дүрс 37: Хорооны 2011 оны хорооны үйл ажиллагааны тайланд тусгагдсан хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төрөл/баримт бичгийн судалгаанаас/..... | 70 |
| Дүрс 38: Нийслэлийн шийдвэр гаргагчдын хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтын түвшин, хувиар.....  | 76 |
| Дүрс 39: Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны төрлүүд, хувиар.....  | 79 |
| Дүрс 40: НИТХ-ын тогтоол, шийдвэрт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх шийдвэр гарсан хувь.....   | 84 |

## ТАЛАРХАЛ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар Нийслэлийн Чингэлтэй, Сонгино хайрхан, Налайх дүүргийн зургаан хороонд “Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоо” төслийн суурь судалгаа амжилттай хэрэгжлээ.

Судалгааны бүхий л үе шатанд идэвхтэй хамтран ажилласан зорилтот дүүрэг, орон нутгийн удирдлага, судалгааны орон нутгийн зохицуулагчид, хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллагуудад талархал илэрхийлье.

Мөн судалгааг амжилттай зохион байгуулж, хэрэгжүүлэхэд тал бүрийн туслалцаа үзүүлсэн Японы Хүүхдийг Ивээх Сангийн хүүхэд хамгаалах хөтөлбөрийн ерөнхий менежер Б.Дарьханд, хөтөлбөрийн мэргэжилтэн Э.Оюунмаа, зөвлөх Ч.Мөнгөнтуяа, З.Уянга нарын оруулсан хувь нэмрийг онцгойлон дурьдаж байна.

Суурь судалгааны арга зүй болон судалгааны хэрэглэгдэхүүнийг олон улсын жишгийн дагуу боловсруулахад үнэтэй санал зөвлөмжөө өгч, хамтран ажилласан бодлогын судлаач Ч.Тамирт талархсанаа илэрхийлж байна. Мөн орон нутагт судалгааг амжилттай зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн дараах байгууллага, хувь хүнд талархал илэрхийлье.



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|        |  |
|--------|--|
| ЕБС    | Ерөнхий боловсролын сургууль                 |
| БХАН   | Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг     |
| ЗДТГ   | Засаг даргын тамгын газар                    |
| ИНХ    | Иргэдийн нийтийн хурал                       |
| ИХТ    | Иргэдийн хурлын тэргүүлэгч                   |
| МУ     | Монгол улс                                   |
| НЗДТГ  | Нийслэлийн засаг даргын тамгын газар         |
| НД     | Налайх дүүрэг                                |
| НХТГ   | Нийслэлийн хүүхдийн төлөө газар              |
| НИТХ   | Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал      |
| НХГБХГ | Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар |
| НҮБ    | Нэгдсэн үндэсний байгууллага                 |
| ОУБ    | Олон улсын байгууллага                       |
| СХД    | Сонгинохайрхан дүүрэг                        |
| ТББ    | Төрийн бус байгууллага                       |
| ҮСГ    | Үндэсний статистикийн газар                  |
| ХТҮГ   | Хүүхдийн төлөө үндэсний газар                |
| ЧД     | Чингэлтэй дүүрэг                             |
| ЯХИС   | Японы хүүхдийг ивээх сан                     |

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

| Нэр томъёо                          | Тайлбар   | Эх сурвалж                                    |
|-------------------------------------|---|---|
| <b>Албан бус боловсрол</b>          | Боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа   | Боловсролын тухай хууль<br>3.1.7              |
| <b>Бага зэрэг мэдээлэлтэй бүлэг</b> | Нийт судалгаанд оролцогсдын “Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээлэл” бага зэрэг авч байсан хүүхдүүд   | Судалгааны тодорхойлолт                       |
| <b>Бага ойлголттой бүлэг</b>        | Нийт судалгаанд оролцогсдын “Хүүхдийн санал бодлыг сонсдог байх, шийдвэртээ тусгадаг байх ёстой” гэж үзэж буй хүүхдүүд  | Судалгааны тодорхойлолт                       |
| <b>Буруу ойлголттой бүлэг</b>       | Нийт судалгаанд оролцогсдын “Хүүхэд томчуудын асуудалд оролцох ёсгүй” гэж үзэж буй хүүхдүүд   | Судалгааны тодорхойлолт                       |
| <b>Бүртгэлгүй хүүхэд</b>            | Аймгаас нийслэлд шилжихдээ нийслэлийн бүртгэлийн газар бүртгүүлээгүй, Нийслэл дотор шилжих хөдөлгөөнийг дүүргийн бүртгэлийн мэргэжилтэнд бүртгүүлээгүй 18 нас хүртэлх иргэн | Иргэний бүртгэлийн тухай хууль 3.26.1, 3.26.2 |
| <b>Мэдлэг</b>                       | Мэдлэг бол боловсрол дадлага туршлагаар ур чадварыг олж авах тодорхой мэдээллийг сайтар мэдэж байх.   | Судалгааны тодорхойлолт                       |
| <b>Мэдээлэл</b>                     | Тодорхой санааг агуулсан дараалал бүхий, утгын нийлбэр.   | Судалгааны тодорхойлолт                       |
| <b>Мэдээлэлгүй бүлэг</b>            | Нийт судалгаанд оролцогсдын “Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээлэл” сонсож байгаагүй хүүхдүүд  | Судалгааны тодорхойлолт                       |
| <b>Мэдээлэл сайн бүлэг</b>          | Нийт судалгаанд оролцогсдын “Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээлэл” байнгын мэдээлэлтэй байдаг   | Судалгааны тодорхойлолт                       |

|                                       |  |   |
|---------------------------------------|--|---|
|                                       | ХҮҮХДҮҮД   |   |
| <b>Маш сайн ойлголттой бүлэг</b>      | Нийт судалгаанд оролцогсдын “Хүүхдийн санал бодлыг томчууд хамтран зөвшилцөж шийдвэр гаргадаг байх, хүүхэд өөрт тулгарсан асуудлыг өөрөө томчуудад илэрхийлж, хамтран шийдвэр гаргах ёстой” гэж үзэж буй хүүхдүүд    | Судалгааны тодорхойлолт   |
| <b>Ойлголт</b>                        | Тодорхой зүйлсийн талаарх төсөөлөлд тулгуурласан бодомж.   | Судалгааны тодорхойлолт   |
| <b>Рожер Хаартын оролцооны шатлал</b> | Социологич Рожер Хаартын “оролцооны 8 шатлал” - ын загвар, 1992 он.  | <a href="http://www.unicef.org/mongolia/Final_TUNS_6_2_04_no_lo_gos_.pdf">http://www.unicef.org/mongolia/Final_TUNS_6_2_04_no_lo_gos_.pdf</a> |
| <b>Сургууль завсардсан хүүхэд</b>     | <i>БСШУЯ-ны нэр томъёогоор суурь боловсролыг (1-9 анги хүртэл) заавал эзэмших тухай Боловсролын тухай хуулийн заалтыг үндэслэн тухайн боловсролыг эзэмших насны (7-16 насны) сургуульд суралцахгүй байгаа хүүхэд</i> | Албан бус эх сурвалжаас авсан тодорхойлолт  |
| <b>Төсвийн баримт бичиг</b>           | Тухайн байгууллагын 2011, 2012 оны үйл ажиллагааны төсвийн зарлагын хуваарь  | Судалгааны ойлголт  |
| <b>Төлөвлөлтийн баримт бичиг</b>      | Тухайн байгууллагын 2011,2012 оны үндсэн төлөвлөгөө, түүнтэй адилтгах бичиг баримт <sup>1</sup>  | Судалгааны ойлголт  |
| <b>Тайлан</b>                         | Тухайн байгууллагын 2011 оны үйл ажиллагааны үндсэн тайлан   | Судалгааны ойлголт  |
| <b>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд</b>    | Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүн  | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль<br>1.3.1   |

<sup>1</sup> Налайх дүүргийн ЗДТГ –аас 2011 онд нийлүүлэх бүтээгдэхүүний жагсаалт

|                                   |  |   |
|-----------------------------------|--|---|
| <b>Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд</b>   | Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 3 сард өдөрт 2 цагаас дээш хөдөлмөр эрхэлсэн 18 хүртэлх насны иргэн.   | ҮСГазар 2010 оны эмхтгэлийн “ажиллагч” гэсэн тодорхойлолтыг үндэслэж судалгааны шалгуур ашиглан тодорхойлов.    |
| <b>Хүүхэд</b>                     | 18 – аас доош насны бүх хүн  | Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 1- р зүйл  |
| <b>Хүүхдийн оролцоо</b>           | Хүүхдүүд, тэр дундаа хамгийн ихээр нийгмээс гадуурхагдсан, янз бүрийн нас болон чадвартай хүүхдүүд өөрсдийн тухай үйл хэрэгт шууд эсвэл шууд бусаар, мэдээлэлтэйгээр бөгөөд өөрсдөө хүссэний үндсэн дээр оролцох   | ЯХИС “Хүүхдийн оролцоо”. Х6 УБ2010 он.  |
| <b>Хүүхдийн оролцох эрх</b>       | Хүүхэд өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх. энэ эрх нь төрөл бүрийн мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, хэвлэмэл буюу урлагийн бүтээлийн хэлбэрээр, хүүхдийн сонгосон мэдээллийн бусад арга хэрэгслээр эрэх, олж авах, дамжуулах эрх чөлөөг багтаана. | Хүүхдийн эрхийн тухай хууль 2.8<br><br>Хүүхдийн эрхийн тухай конвенц 4 – р зүйл, 12, 13, 14, 15, 16, 17 -р зүйл |
| <b>Хүчирхийлэлд өртсөн хүүхэд</b> | Аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйд өртсөн 18 нас хүртэлх иргэн.  | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль<br><br>5.1.1   |

## **БҮЛЭГ 1: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

Энэхүү бүлэгт суурь судалгааны хөтөлбөр, түүвэрлэлт, мэдээлэл цуглуулсан аргууд ба зохион байгуулалт, мэдээлэл боловсруулсан үйл явцг тайлбарлав. Судалгааг “Хараат бус судалгааны хүрээлэн” хийж гүйцэтгэв.

### **1.1 Төслийн талаарх үндсэн мэдээлэл**

Японы Хүүхдийг Ивээх сан нь 2012 оны 7 сараас 2015 оны 6 сар хүртэл “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн эхний үе шат 2012 оны 7 сараас 2013 оны 3 сарыг дуустал хэрэгжих юм. Цаашид ахин хоёр үе шаттай үргэлжлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Эхний үе шатанд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, түүний 2 хороог сонгож, засаглалын түвшин бүрийн шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн оролцоог хангаж амжилттай ажилласан олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэхүү туршлагад суурилан ирэх жилд хөдөө орон нутагт тодорхой аймаг, сум багийг сонгож үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ үндэсний түвшинд нөлөөлөх ажлыг гүйцэтгэх болно. Энэ хүрээнд тухайн орон нутгийн хүүхдийн оролцооны бүтцүүдийг татан оролцуулж, эсвэл бий болж чадаагүй газар нь шинээр бүтэц үүсгэж, орон нутгийн хүүхдүүдэд өөрсдөд нь хамааралтай асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх чадвар олгох, орон нутгийн удирдлагын зүгээс үзэл бодлыг нь албан ёсны шийдвэр гаргахдаа тусгадаг болоход чиглэсэн цуврал үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна. Ингэж бий болсон загвар, практикийг төрийн механизмын түвшинд албажуулах асуудлаар хүүхдүүд, ТББ-тай хамтран нөлөөллийн ажлыг хийнэ.

Ингэснээр тус төслийн хүрээнд эхний жилд нийслэл хотын нийт 360 000 хүүхэд, гурван жилийн дараа Монгол улсын нийт 1200 000 хүүхэд засаглалд оролцох боломжийг нээж өгөх юм.

### **1.2 Судалгааны зорилго, зорилт**

Суурь судалгааны зорилго нь орон нутгийн засаглалын бүхий л түвшин дэх хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодруулж, хүүхдийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, өнөөгийн байдлаар хүүхдийн оролцооны цар хүрээ, арга хэлбэрийг өргөжүүлэх боломжийг тодорхойлоход оршино.

Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдлыг гэр бүл, сургууль, орон нутгийн түвшинд судалж тодорхойлох,
2. Хороо, дүүрэг, нийслэлийн түвшинд төсөвлөлт, төлөвлөлт, хэрэгжилтийн хяналтад хүүхдийн оролцооны байдал ямар түвшинд байгааг дүрслэх
3. Хүүхдийн оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох
4. Орон нутгийн түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын агуулга, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломжуудыг нээх, зөвлөмж боловсруулах

5. Засаглалд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд оролцогч байгууллагуудын үүрэг, чиглэл, хамтын ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэх нөлөөллийн ажлын арга замуудыг боловсруулах зэрэг болно.

### 1.3 Судалгааны зорилтот бүлэг

Судалгааны зорилтот бүлэг нь хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүн тус бүрээс хамааран харилцан адилгүй байсан болно.

#### Хүснэгт1: Судалгааны зорилтот бүлэг

| Төслийн зорилтот бүлэг                       | Төслийн нарийвчилсан бүлэг  |
|--|---|
| Нийслэлийн хэмжээнд                          | НИТХ-ын төлөөлөгчид <ul style="list-style-type: none"> <li>• НИТХ-ын ажлын хорооны дарга, ажилтан</li> <li>• НИТХ-ын гишүүд</li> </ul>  |
|  | Нийслэлийн Засаг Даргын ажлын алба <ul style="list-style-type: none"> <li>• Нийслэлийн Засаг даргын орлогч (хүүхэд ба нийгмийн асуудал хариуцсан)</li> </ul>  |
|  | Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхдийн оролцооны асуудал эрхэлсэн мэргэжилтэн</li> </ul>  |
|  | Нийслэлийн Боловсролын газар <ul style="list-style-type: none"> <li>• Нийслэлийн Боловсролын Газрын Албан бус боловсрол, сурагчдын хөгжил боловсрол хариуцсан мэргэжилтэн</li> </ul>  |
| Дүүрэг, хорооны түвшинд                      | Дүүргийн түвшинд: <ul style="list-style-type: none"> <li>• Чингэлтэй, Сонгинохайрхан,Налайх дүүргийн Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн</li> <li>• Чингэлтэй, Сонгинохайрхан, Налайх дүүргийн Боловсролын хэлтсийн мэргэжилтэн</li> </ul> |
|  | Хорооны түвшинд: <ul style="list-style-type: none"> <li>• Хорооны Засаг Дарга</li> <li>• Нийгмийн ажилтан</li> <li>• Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид</li> </ul>  |
|  | ЕБС-ийн түвшинд: <ul style="list-style-type: none"> <li>• Захирал</li> <li>• Нийгмийн ажилтан</li> </ul>  |
| Олон нийт                                    | Эцэг эхийн бүлэг  |
|  | 8-18 насны хүүхдүүд   |
|  | 19-21 насны залуус  |
| Иргэний нийгмийн байгууллага, бүлэг, холбоод | ОУБ: Дэлхийн Зөн, НҮБ-ын Хүүхдийн сан   |
|  | Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээний ТББ-ууд: МУЗН, Монголын сурагчдын холбоо, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг, Залгамжлагч Холбоо  |

Хүснэгтэд судалгаанд оролцогч зорилтот бүлгийг түвшин бүрээр нь харуулсан бөгөөд нийт 4 түвшний 16 төлөөллийг оролцуулсан.

Суурь судалгааг 2012 оны 10 сарын 23-аас 12 сарын 21 хүртэл хийлээ. Судалгааны ажлыг зөвлөх 1, зохицуулагч 1, үндсэн судлаач 4, туслах судлаачдын бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэлээ. Судалгааны мэдээлэл цуглуулах буюу талбарт ажилласан нийт хугацаа 21 өдөр болсон бөгөөд зорилтот 3 дүүрэг тус бүрт 1 ахлах судлаач, туслах судлаачийн хамт анкетын судалгаа, баримт бичгийн шалгах хуудас болон фокус бүлгийн ярилцлага, ганцаарчилсан ярилцлагын аргуудаар судалгааны мэдээллийг цуглуулав. Нийслэлийн түвшний мэдээллийг багийн 1 ахлах судлаач цуглуулж ажиллалаа. Судалгааны талбарын мэдээллийг ЯХИС-д долоо хоногт 1-2 удаа цахим захидлаар болон утсаар мэдээлж, холбоотой ажилласан. Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулахаас эхлээд судалгааны бүхий л үйл явцад ЯХИС болон судалгааны баг байнгын мэдээлэл солилцож, шийдвэрлэх асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэж байсан.

#### **1.4 Судалгааны хамрах хүрээ**

Суурь судалгаа нь зөвхөн нийслэлийн хэмжээнд хийгдэхээр төлөвлөгдсөн бөгөөд Улаанбаатар хотын ЗДТГ, хотын төвийн дүүргийг төлөөлүүлж Чингэлтэй, хотын захын, хүн ам их суурьшсан дүүргийг төлөөлүүлж Сонгинохайрхан, хотоос алслагдсан дүүргийг төлөөлүүлж Налайх дүүргийг тус тус сонгон авсан. Үүнээс төслийн зорилтот 3 дүүрэг тус бүрээс санамсаргүй түүврийн аргаар 2 хороог судалгаанд сонгон авч нийт 6 хороог оролцуулсан.

Судалгаанд нийслэлийн засаг, захиргааны үндсэн нэгж, түвшин бүрээс төлөөлүүлэн удирдах ажилтнууд, салбар байгууллагын хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдийг хамруулан оролцуулсан. Төр захиргааны байгууллагуудаас гадна хүүхдийн чиглэлээр ажилладаг, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг Олон Улсын болон ТББ-ыг ч хамруулсан. Олон нийтийн төлөөлөл болгож 8-18 насны хүүхдүүд болон 19-21 насны залуусыг хамруулахдаа тэдгээрийн нас хүйс, сургуульд хамрагдалт, нийгмийн бусад үзүүлэлтийг харгалзлаа.

#### **1.5 Судалгааны арга**

Суурь судалгаанд үндсэн зорилт болон дээрх 6 түвшний онцлогоос хамаарсан судалгааны аргуудыг ашигласан болно.

#### **Хүснэгт 2: Судалгааны арга**

| <b>Бүрэлдэхүүн хэсгүүд</b> |                      | <b>Ашигласан аргууд</b>  |
|----------------------------|----------------------|--|
| 1                          | Нийслэл              | Ярилцлага, баримт бичгийн шалгах хуудас                                |
| 2                          | Дүүрэг/Хороо         | Ярилцлага, баримт бичгийн шалгах хуудас                                |
| 3                          | Сургуулийн удирдлага | Ярилцлага, баримт бичгийн шалгах хуудас                                |
| 4                          | Эцэг эхийн төлөөлөл  | Ярилцлага  |
| 5                          | ОУБ болон ТББ        | Ярилцлага  |
| 6                          | Олон нийт            | Кейс судалгаа, стандартчилсан анкетын асуулга, Фокус бүлгийн ярилцлага |

Нийслэлийн түвшинд 2 төрлийн ярилцлага хийсэн. Эхний ярилцлагын хуудсаар НЗДТ, НИТХ-ын удирдлага, мэргэжилтнүүдээс мэдээлэл авсан бөгөөд дараагийн ярилцлагын хуудсаар нийслэлийн ЗДТГ-ын хэрэгжүүлэгч газруудын хүүхдийн асуудал эрхэлсэн мэргэжилтнүүдээс судалгаа авсан. Ярилцлагын аргаар дээрх судалгаанд оролцогч хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт, мэдлэг, хандлагыг тодорхойлж, үйл ажиллагааны төсөвлөлт, төлөвлөлт, хэрэгжилтийн хяналтад хүүхдийг оролцуулж байгаа эсэхийг үнэлэх зорилготой байв.

Дүүрэг, хороо, сургуулийн түвшинд: 2 төрлийн ярилцлага хийсэн. Эхний ярилцлагын хуудсаар дүүрэг, хорооны түвшний удирдлагууд болон мэргэжилтнүүдээс мэдээлэл авсан бол дараагийн ярилцлагын хуудсаар зорилтот сургуулийн захирал, нийгмийн ажилтнаас судалгаа авсан. Ярилцлагын аргын давуу тал нь судалгаанд оролцогчийн өгсөн мэдээллийг нэмж дэлгэрүүлэх, ахин нягтлах, аливаа асуудлын учир шалтгааныг тодорхойлох байсан бөгөөд засаглалд хүүхдийн оролцоо ямар байх талаар мэдээлэл дутмагаас ярилцах хугацаа, агуулгын хувьд ярилцлагыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болж байв. Энэ хэсэг дэх баримт бичигт тавих шалгуур нийслэлийн түвшний баримт бичигтэй ижил байв.

Эцэг эхийн төлөөлөл: Энэ хэсгийн хүрээнд сонгогдсон сургуулийн хүүхдүүдийн эцэг эхийн төлөөлөлтэй тэдэнд зориулсан тодорхой аргачлалын дагуу ганцаарчилсан ярилцлага хийв.

ОУБ ба ТББ-ын түвшинд: Энэ хүрээнд ярилцлагын аргаар мэдээлэл авсан. Ярилцлагаар “Хүүхдийн оролцох эрхийг хангах” чиглэлээр ажиллаж буй өнөөгийн дүр зургийг тодорхойлж, цаашид засаглал дахь хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд санал, зөвлөмж аргачлалыг боловсруулах мэдээлэл цуглуулах зорилготой байлаа. Энэ ярилцлагаар мэдээллээ харьцангуй амжилттай бүрэн цуглуулж чадсан. Учир нь ОУБ ба ТББ-ын мэдээллээ хуваалцах хандлага эерэг байсан бөгөөд судалгааны ач холбогдлыг өндрөөр үнэлж байв.

Олон нийт: Энэ хүрээнд 8-18 насны бүлгийнхнээс стандартчилсан анкетын асуулга авч, фокус бүлгийн ярилцлага хийж мэдээлэл цуглуулсан. Хүүхдийн оролцооны талаарх энэ насныхны ойлголт, мэдлэг, мэдээллийн түвшин, оролцооны түвшин, нөхцөл байдлыг нь тодорхойлсон. Харин 19-21 насныхны хувьд кейс ярилцлагын арга ашиглаж хүүхэд байх үеийнх нь туршлагад тулгуурлаж мөн адил агуулгаар мэдээллийг тодруулав.



## 1.6 Судалгааны түүвэр

Доорхи хүснэгтэд суурь судалгааны арга ба түүвэрлэлтийг дэлгэрэнгүй харуулав.

### Хүснэгт3: Судалгааны арга ба түүвэр

| Судалгаанд хамрагдагсад  | Судалгааны аргууд   |                 |  |               | Зорилтот бүлэг                                 |
|--|---------------------|-----------------|--|---------------|--|
|  | Баримт бичиг судлал | Фокус ярилцлага | Стандарчилсан асуулга /Экспертийн ярилцлага/ | Анкет асуулга |  |
| НИТХ-ын төлөөлөгчид  | 1                   |                 | 5  |               | Нийслэлийнтүвшинд                              |
| НЗД-ын орлогч  | 5                   |                 | 1  |               |  |
| Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, ХТҮГ   | 5                   |                 | 2  |               |  |
| Нийслэлийн Боловсролын газар   | 5                   |                 | 1  |               |  |
| Чингэлтэй, Сонгино хайрхан, Налайх дүүрэг:<br>- Нийгмийн хөгжлийн хэлтэс<br>- Боловсролын хэлтэс   | -                   |                 | 7  |               | Дүүргийнтүвшинд                                |
| Чингэлтэй дүүргийн 6, 13-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 14, 8-р хороо, Налайх дүүргийн 1, 3-р хороодын<br>- Засаг дарга<br>- Нийгмийн ажилтан<br>- ИНХ-ын тэргүүлэгчид |                     |                 | 17   |               |  |
| Сургуулийн захиргаа<br>- Захирал<br>- Нийгмийн ажилтан   |                     |                 | 11   |               |  |
| Эцэг эхийн бүлэг   |                     |                 | 22   |               | Олон нийтийн түвшинд                           |
| 8-18 насны хүүхдүүд  |                     | 6               | 422  |               |  |
| 19-21 насны залуус   |                     |                 | 15   |               |  |
| ОУБ  |                     |                 | 2  |               | Иргэний нийгмийн байгууллагууд                 |
| ТББ  |                     |                 | 4  |               |  |
| <b>Нийт</b>  | 59                  |                 |  |               | Баримт бичгийн судалгаа                        |
|  | 6                   |                 |  |               | Фокус бүлгийн ярилцлага                        |
|  | 71                  |                 |  |               | Стандарчилсан ярилцлага /Экспертийн ярилцлага/ |
|  | 324                 | ЕБС             |  |               | Анкет асуулга                                  |
|  | 98                  | Зорилтот бүлэг  |  |               |  |

Олон нийтийн түвшний судалгаанд давхаргат санамсаргүй түүвэрлэлтийн аргыг хэрэглэсэн. Энэ нь хүн амыг тодорхой шинж чанараар нь хэд хэдэн бүлэг буюу давхаргад хуваан үзэж, дараа нь энэхүү давхарга дотроо санамсаргүй түүвэрлэлт хийдэг арга юм. Давхарга тус бүрээс түүвэрлэх түүврийн тоог нийт хүн амд эзлэх хувийн жинтэй пропорциональ байх аргыг түүвэр судалгаанд түгээмэл хэрэглэдэг боловч бид судалгаандаа орон нутгийн нийт хүн амыг хамруулалгүй зөвхөн зорилтот бүлэг дээрээ төвлөрч, пропорциональ бус түүвэрлэлтийн аргыг хэрэглэх нь оновчтой гэж үзсэн.

### **1.7 Судалгааны явцад баримталсан зарчмууд**

Суурь судалгааны явцад Монгол улсын “Статистикийн тухай хууль”, “Хувь хүний нууцын тухай хууль”, мөн Японы Хүүхдийг Ивээх сангийн хүүхэд хамгааллын протокол, ажилтны ёс зүйн дүрэм, хүүхдийн оролцоог хангах үйл ажиллагааны стандарт, Рожер Хартын хүүхдийн оролцооны шатлалын тодорхойлолт, судалгааны зарчмуудыг баримталсан болно. Мөн судалгааг гүйцэтгэгч байгууллагын дотоод ёс зүйн зарчмууд ба “Эрсдлийн удирдлагын баримт бичиг”-ийн суурь зарчмыг баримталсан. Түүнээс гадна судалгааны бүрэлдэхүүн хэсгүүдийн онцлогоос хамааран нэмэлт зарчмуудыг тодорхойлов.

### **1.8 Судалгааны бэлтгэл ба туршилт**

Судалгааны мэдээлэл цуглуулах туслах багийг бэлтгэх, судалгааны багийн гишүүдийг судалгааны бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар нэгдсэн мэдээллээр хангахын тулд бэлтгэл сургалт болон туршилтын судалгааг зохион байгуулсан.

Бэлтгэл сургалтыг ЯХИС болон “Хараат бус судалгааны хүрээлэн” хамтран зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулах баг туршилт судалгаа хийсний дараа нэгдсэн “Бэлтгэл сургалт”-ыг хийлээ. “Бэлтгэл сургалт”-ыг хоёр үндсэн агуулгын хүрээнд хийсэн болно. Нэгдүгээрт, ЯХИС-ийн мэргэжилтнүүд хүүхдээс мэдээлэл авах арга, хүүхэдтэй ажиллахад анхаарах ёс зүйн зарчмуудыг танилцуулсан. Хоёрдугаарт, судалгааны мэдээлэл цуглуулахтай холбоотой судалгааны арга зүйг танилцуулсан. Энэ хоёр хэсгийг нэгтгээд судлаачдад зориулсан дэлгэрэнгүй мэдээлэл бүхий “Гарын авлага” –ыг боловсруулж өгсөн.

Судалгааны хэрэглэгдэхүүн болон судлаачдын бэлтгэлийг шалгахын тулд туршилт судалгааг 2012 оны 11-р сарын 1-нээс 11-р сарын 5-ны өдөр Чингэлтэй дүүрэг болон “Хүүхдийн хаяг тогтоох төв”-ийн хүүхдүүдийн дунд хийв.

Судалгааны цуглуулсан мэдээлэл болоод, хэрэглэгдэхүүний оновчтой, ойлгомжтой байгаа эсэхийг тодруулан ЯХИС-тай зөвшилцсөний эцэст нэмэлт засварыг оруулж, баталгаажуулсан болно.

### **1.9 Судалгааны боловсруулалт**

Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг тус хүрээлэнгийн албан ёсны лицензтэй “SPSS 17.0” програм болон чанарын мэдээллийг боловсруулах “QDA” програмыг ашиглаж боловсрууллаа.

Судалгааны боловсруулалт анкетын голлох ба туслах асуултын дагуу хийгдсэн. Анкетын судалгааны ихэнх асуулт хаалттай хариулттай байсан бөгөөд нээлттэй асуултаар бид респондентоос нэмэлт мэдээлэл авч агуулгын хувьд бүлэглэж ахин боловсруулалт хийсэн.

Асуудлын учир шалтгааныг тодруулахдаа чанарын мэдээллийг түлхүү ашиглав.

Тайлан нь зөвхөн судалгааны үр дүнгээр тодорхойлогдоогүй бөгөөд ЯХИС-ын санал зөвлөмжийг тусгасан. Судалгааны үр дүн, ойлголтыг нэгтгэж сайжруулахын тулд төслийн оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг хийж олон нийтэд танилцуулах болно.

## **1. 10 Судалгааны хязгаарлагдмал тал**

Суурь судалгаа нь зөвхөн судалгаанд хамрагдсан дүүрэг, хороогоор төлөөлүүлэн нийслэлийн шинж байдлыг харуулахыг зорьж байгаа. Мөн суурь судалгааны мэдээлэл цуглуулах үе шат нь цаг хугацааны хувьд орон нутгийн сонгуультай давхцаж байсан нь судлаачдын ажиллах хугацаа сунгах, респондентыг хүлээх, зарим шаардлагатай баримт бичгийг энэ хугацаанд авах боломжгүй болох, байгууллагын дотоод баримт бичиг, нууцлалтай гэх мэт шалтгаанаар төлөвлөсөн хугацаа тодорхойгүй хоногоор хойшлоход хүргэсэн.

Судалгаанд насанд хүрээгүй хүүхэд оролцуулах нь тэдний гэр бүл, асран хамгаалагчийн зөвшөөрөл авах, судалгаанд оролцогч хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх зэрэг тусгай ур чадварыг судлаачдаас шаардаж байсан. Судалгааны явцад хүүхдэд судалгааны ач холбогдол, хэрхэн оролцох зааврыг дутуу мэдээлсний улмаас 100 гаруй хүүхдийн судалгаа дутуу авагдаж, хүчингүй болсон бөгөөд судалгааны баг энэ алдааг нягталж судалгааны мэдээллийг зорилтот түүврээс ахин бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан.

Мөн бүртгэлгүй, хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, сургууль завсардсан, хүчирхийлэлд өртсөн гэх мэт зорилтот бүлгийн 100 хүүхэд манай судалгаанд хамрагдсан бөгөөд эдгээр хүүхдийн нэгдсэн мэдээлэл, байршил тодруулахад цаг хугацаа төлөвлөснөөс их зарцуулж байв.

## **1.11 Судалгааны явцад гарсан бэхшээл**

Хүүхдүүдээс мэдээлэл авах үе шатанд, тэд асуултыг хэрхэн ойлгож байгааг нягтлах, ахин лавлах хэрэгтэй болж байв. Тухайлбал хүүхдийн оролцооны түвшинг тодорхойлохдоо үндсэн орчныг нь (гэр бүл, сургууль, хороо) үнэлүүлэх асуулт бидний гол даалгавар байсан ч ялангуяа бага насны хүүхдүүд асуултын тайлбарыг сайн ойлгоогүйн улмаас дутуу, хүчингүй анкет цөөнгүй гарсан. Мөн судалгааны мэдээллийг авахдаа хүүхдийг бие биедээ нөлөөлөхүйц орчин нөхцөл, ойрхон зайд байлгах нь нэгийгээ даган дуурайх, нэгнийхээ өмнөөс бөглөх, хариултад нь нөлөөлөх жижиг бэрхшээл үүсч байсан юм.

Бичиг баримтын судалгааны мэдээлэл цуглуулах үе шатанд судалгааны мэдээлэл цуглуулах ихэнх хугацаа зарцуулагдсан бөгөөд нэг байгууллагын баримт бичгийг авахын

тулд хамгийн багадаа 3, түүнээс дээш 8 удаа ч хандалт хийсэн тохиолдол гарсан. Учир нь байгууллагын тухайн баримт бичиг хариуцсан ажилтан орон нутгийн сонгуулийн ажилтай байх, эзэнгүй байх, баримт бичгийг сонгуулийн хугацаанд гадагш гаргадаггүй журам үйлчилж байх, тухайн баримт бичгийг авах зөвшөөрлийг авах, хувь хүний ажил хэрэгч бус хувийн хандлага гэх мэт бэрхшээлүүд тохиолдож байв. Мөн баримт бичгийн судалгааны цугларсан баримт бичгийг харахад байгууллага бүр өөрийн гэсэн стандарт, форматаар баримт бичгээ хөтөлсөн байсан бөгөөд ихэнх нь хүүхдийн холбогдолтой аливаа ажлыг ялгаж харахад бэрхшээлтэйгээр тэмдэглэсэн байсан.

*Орон нутгийн сонгуультай холбоотойгоор* аль аль түвшний удирдлага, мэргэжилтнүүд эзэнгүй байх, судалгаанд оролцох цаг завгүй байх, товлосон уулзалтууд хойшлогдох, хэдэн цагаар хүлээлгэх зэрэг бэрхшээл гарч байлаа. Судалгааны зорилго, нэрийг танилцуулахад судалгааны зорилгыг буруу ташаа ойлгох, ахин дахин лавлах, нягтлах оролдлогууд судалгаанд оролцогчдын зүгээс гарч байсан.

*Экспертийн ярилцлага хийхэд, оролцогчдын* судалгааны талаарх ойлголт мэдээлэл, судалгааны сэдэвтэй холбоотой хандлага харилцан адилгүй байсан нь ярилцлагыг үргэлжлүүлэхэд төрөл бүрийн нөхцөл байдлыг бий болгож байлаа. Зарим оролцогч ярилцлагын хугацааг сунгаж өөр олон сэдвээр ярих хүсэлтэй байсан бол зарим нь “Хурдан асуучихаад яв, ажил ихтэй зав байхгүй байна” гэсэн хариулт өгч байлаа. Гэвч судалгааны баг захиалагч талын болон бусад хүмүүсийн дэмжлэгээр энэ судалгааны үндсэн мэдээллийг цуглуулж чадсан.

## БҮЛЭГ 2. НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН ТҮВШИН, ОЙЛГОЛТ

### 2.1 Судалгаанд оролцогсодын ерөнхий шинж байдал

Судалгааны хүрээнд нийт 422 хүүхэд хамрагдсанаас 76.5 хувь нь ЕБС-д сурдаг 3 – с 11-р ангийн сурагчид байсан бол үлдсэн 23.5 хувь нь зорилтот бүлгийн хүүхдүүд байсан. Зорилтот бүлгийн хүүхдүүд гэдэгт бид хөгжлийн бэрхшээлтэй /3.8 хувь/, бүртгэлгүй /3.3 хувь/, хүчирхийлэлд өртсөн /3.8 хувь/, хөдөлмөр эрхэлдэг/4.3 хувь/, сургууль завсардсан /4.5 хувь/, хараа хяналтгүй хүүхдүүд /3.8 хувь/ - ийг хамруулан судалгааг авсан болно.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 26.3 хувь нь Сонгино хайрхан дүүрэгт, 26.3 хувь нь Чингэлтэй дүүрэгт, 24.2 хувь нь Налайх дүүрэгт оршин суудаг бол үлдсэн 23.2 хувь нь өөр харъяалалтай байна.

Насны ангилалаар авч үзвэл 8-11 насны хүүхэд 31.3 хувийг, 12-15 насны хүүхэд 37.9 хувийг, 16-аас 18 насны хүүхэд 30.8 хувийг эзэлж байна. Хүйсийн ангилалаар авч үзвэл 55.7 хувь нь эрэгтэй, 44.3 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Сургуульд хамрагдалтын хувьд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн ихэнхи нь ЕБС –д суралцдаг болох нь доорх хүснэгтээс харагдаж байна.

#### Хүснэгт 4: Судалгаанд оролцогсодын ерөнхий шинж байдал

|  | Тоо | Хувь |
|--|-----|------|
| <b>Суралцдаг байдал</b>  |     |      |
| Суралцдаггүй   | 40  | 9.5  |
| Албан бус боловсрол  | 6   | 1.4  |
| Бага анги  | 124 | 29.4 |
| Бүрэн бус дунд   | 60  | 14.2 |
| Бүрэн дунд   | 188 | 44.5 |
| Тусгай мэргэжлийн коллеж   | 4   | 0.9  |
| <b>Өрхийн амьжиргаа</b>  |     |      |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэггүй                            | 43  | 10.2 |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэг                               | 123 | 29.1 |
| Өдөр тутмын хоол хүнснээс гадна хувцас, хэрэглэл авч чаддаг        | 110 | 26.0 |
| Хувцас хэрэглэлээс гадна хүссэн зүйлээ авч чаддаг                  | 85  | 20.1 |
| Би хувьдаа хадгаламж нээсэн, манай гэрийн орлого хангалттай хүрдэг | 61  | 14.5 |
| <b>Хөдөлмөр эрхлэлтийн байдал</b>                                  |     |      |
| Сургуульд явдаггүй, хөдөлмөр эрхэлдэггүй гэртээ байдаг             | 31  | 7.3  |
| Сургуульд явдаггүй хөдөлмөр эрхэлдэг                               | 29  | 6.9  |
| Сургуульдаа ч явдаг хөдөлмөр эрхэлдэг                              | 50  | 11.8 |
| Сургуульдаа л явдаг хөдөлмөр эрхэлдэггүй                           | 309 | 73.7 |
| <b>Амьдарч буй сууны төрөл</b>                                     |     |      |
| Орон гэргүй  | 12  | 2.8  |
| Сууцны бус   | 3   | .7   |
| Гэр  | 112 | 26.5 |

|                          |     |      |
|--------------------------|-----|------|
| Хашаа байшин             | 182 | 43.1 |
| Орон сууц                | 102 | 24.2 |
| Нийтийн байр             | 6   | 1.4  |
| Тохилог хаус             | 4   | .9   |
| Бусад                    | 1   | .2   |
| <b>Гэр бүлийн байдал</b> |     |      |
| Эцэг эх                  | 283 | 67.0 |
| Эх                       | 69  | 16.4 |
| Эцэг                     | 15  | 3.6  |
| Эмээ, өвөө               | 30  | 7.1  |
| Бусад хүмүүс             | 25  | 5.9  |


Сургууль завсардсан хүүхдүүдийн хувьд сургуульд суралцдаггүй шалтгаанаа тэдний 30.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй холбон үзсэн бол ар гэрийн шалтгаантай байсан гэж 14 хувь нь үзсэн байна. Мөн тэдний дийлэнх нь эцэг эхтэйгээ амьдардаг байсан бол зөвхөн ээжтэйгээ хамт байдаг гэж 16.4 хувь нь хариулсан байна. Сууцны төрлийн хувьд 43.1 хувь нь хашаа байшинд амьдардаг. 26.5 хувь нь гэрт амьдардаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд нийт судалгаанд оролцогсодын 18.7 хувь нь хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд байна.

Эдгээр ерөнхий шинж байдлыг харвал бид нийслэлийн хүүхдүүдийн нийт олонлогийг сайн төлөөлж чадахуйц түүврээс судалгааг авсан нь харагдаж байна. Иймээс нийслэлийн хэмжээнд хүнд нөхцөлд байгаа болон жирийн ЕБС–д сурдаг хүүхдийн засаглал дахь оролцооны талаарх ойлголт, хүүхдийн оролцох эрхийн мэдээллийн хүртээмжийг бүрэн хэмжээгээр зурагласан гэж үзэж байна. Хүүхдүүд өөрсдөө хүүхдийн оролцоог юу гэж ойлгож байгааг судлах, хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн хүртээмжийн түвшинг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Судалгааны энэ хэсэгт бид нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшнээр нь “мэдээлэлгүй хэсэг”, “бага зэргийн мэдээлэлтэй хэсэг”, “мэдээлэл сайн бүлэг” гэж гурав ангилж үзнэ. Харин хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтоор нь “буруу ойлголттой хэсэг”, “бага зэрэг ойлголттой хэсэг”, “сайн ойлголттой хэсэг” гэсэн гурван хэсэгт хуваан үзнэ.


## 2.2 Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин

Дүрс 1: Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин



Нийт судалгаанд оролцогсдын 56.9 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг бага зэрэг авч байсан гэдэг хариулт өгчээ. Фокус бүлгийн ярилцлагад хүүхдүүд ихэвчлэн хүүхдийн оролцоо гэдэг ойлголтыг өөрсдийнхөөрөө тодорхойлж байсан бол “Хүүхдийн оролцох эрх гэдэг ойлголтыг сонсож байсан уу?” гэсэн асуултад бага ангийн сурагчид ихэвчлэн “Үгүй” гэж хариулж байсан бол арванхоёроос дээш насны хүүхдүүд “иргэний нийгэм, нийгмийн ухааны хичээл дээр сонсож байсан” гэж хариулсан бөгөөд үүнийг сайн санахгүй байгаа тухай дурдаж байсан. Үүнээс үзэхэд хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг хичээл дээр дурдаад өнгөрдөг, хүүхдүүдэд хэрхэн яаж оролцох талаар, оролцооны ач холбогдлын талаар ямар нэгэн мэдээлэл өгдөггүй нь харагдаж байна.

Дүрс 2: Хүүхдийн оролцох эрхийн мэдээлэл болон насны хамаарал



Хүүхдийн оролцох эрхийн мэдээллийн түвшинг авч үзвэл, бага насны хүүхдүүд оролцох эрхийн талаарх мэдээллийг сонсож байгаагүй гэж олонхи нь үзсэн байна.

Судалгааны анхаарвал зохих хэсэг нь хүүхдийн оролцох эрхийн мэдээлэлгүй болон байнгын мэдээлэлтэй байдаг хэсгүүдийн ерөнхий шинж байдал мөн оролцооны түвшний хамаарлыг тогтоох явдал юм. Энэхүү хамаарлыг тогтоох үүднээс судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг “мэдээлэлгүй”, “бага зэрэг мэдээлэлтэй”, “мэдээлэл сайтай” гэсэн гурван үндсэн бүлэгт хуваасан.

“Хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэл хэр авдаг вэ?” гэсэн асуултад “сонсож байгаагүй” гэж хариулсан хэсгийг “мэдээлэлгүй бүлэг” гэж ойлгоно. 8-11 насны хүүхдүүдийн асуулгад “сонсож байсан, гэхдээ сайн санахгүй байна”, 12-оос дээш насны хүүхдүүдийн асуулгад “бага зэргийн мэдээлэл авч байсан” гэж хариулсан бүлгийг “бага зэргийн мэдээлэлтэй бүлэг”-т хамруулна. Харин 8-11 насны хүүхдийн асуулгад “хүүхдийн оролцох эрх гэж мэддэг”, 12-оос дээш насны хүүхдүүдийн асуулгад “байнгын мэдээлэлтэй байдаг” гэж хариулсан бүлгийг хамруулан ойлгох болно.


### 2.2.1 Мэдээлэлгүй бүлэг

Нийт судалгаанд оролцогсдын 28 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй гэж хариулсан. Мэдээлэлгүй бүлгийн 44.9 хувийг бага насныхан эзэлж байгаа нь бага насны сурагчдад иргэншил болон нийгмийн хичээл орж эхлээгүйтэй холбоотой. Хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй байх нэг нөхцөл нь хүүхдийн нас болохыг Дүрс 2 харуулж байна.

Мөн судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн хүүхдүүд оролцооны мэдээллээр тун хомс байсан юм. Дүнг дүрс 3 - аас харна уу.

### Дүрс 3: Зорилтот бүлгүүдийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин





Хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээллийг бүртгэлгүй хүүхдүүдийн 85.7 хувь нь, сургууль завсардсан хүүхдүүдийн 73.7 хувь нь тус тус сонсож байгаагүй гэж хариулсан нь зорилтот бүлгүүдийн хувьд ерөнхийдөө хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээлэл хомс байгааг харуулж байна. Хүчирхийлэлд өртсөн зорилтот бүлгээс хүүхдийн оролцох эрхийн талаарх байнгын мэдээлэлтэй хүүхэд байхгүй байгаа нь эдгээр зорилтот бүлэгт хүүхдийн оролцох эрхийн байнгын мэдээллийн эх сурвалж байхгүй, нөгөө талаар тийм боломж, нөхцөл байдаггүйтэй холбоотой. Хүүхдийн оролцооны эрхийн талаар мэдээлэл байхгүй бүлгийн 55.9 хувийг зорилтот бүлгийн хүүхдүүд эзэлж байсныг энэ дашрамд тэмдэглэе.


#### Хүснэгт 5. Мэдээлэлгүй бүлгийн ерөнхий шинж

|   | Тоо | Хувь |
|---|-----|------|
| <b>Хүйс</b>                             |     |      |
| Эрэгтэй                                 | 73  | 61.9 |
| Эмэгтэй                                 | 45  | 38.1 |
| <b>Суралцдаг байдал</b>                 |     |      |
| Суралцдаггүй                            | 30  | 25.4 |
| Албан бус боловсрол                     | 4   | 3.4  |
| Бага анги                               | 49  | 41.5 |
| Бүрэн бус дунд                          | 5   | 4.2  |
| Бүрэн дунд                              | 28  | 23.7 |
| Тусгай мэргэжлийн коллеж                | 2   | 1.7  |
| <b>Өрхийн амьжиргаа</b>                 |     |      |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэггүй | 31  | 26.3 |

|  |    |      |
|--|----|------|
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэг                               | 34 | 28.0 |
| Өдөр тутмын хоол хүнснээс гадна хувцас, хэрэглэл авч чаддаг        | 26 | 22.0 |
| Хувцас хэрэглэлээс гадна хүссэн зүйлээ авч чаддаг                  | 20 | 16.9 |
| Би хувьдаа хадгаламж нээсэн, манай гэрийн орлого хангалттай хүрдэг | 7  | 5.9  |

Хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй бүлгийн 61.9 хувь нь эрэгтэй. 28.8 хувь сургууль завсардсан, 54.3 хувь нь дундаас доогуур орлоготой зэрэг ерөнхий үзүүлэлтүүдтэй байна. Эдгээр үзүүлэлтээс харахад хүүхэд оролцох эрхийн талаарх мэдээлэл авахад нь түүний амьдарч буй орчин, сургуульд хамрагдаж буй эсэх нь нөлөөлж байна.


#### Дүрс 4: Мэдээлэлгүй бүлгээс дэвшүүлсэн хүүхдийн оролцоог бий болгох санал



Хүүхдийн оролцоог сайжруулах арга замыг хүүхдүүдээс асуухад тал хувь нь “мэдэхгүй байна” гэсэн хариулт өгсөн нь хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй байдал оролцох санаачлагагүй болгож байгааг харуулж байна.

Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин хүүхдийн оролцооны түвшинтэй шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй 118 хүүхдийн 93.2 хувь нь хорооны түвшинд огт оролцдоггүй, 44.1 хувь нь гэр бүлийн асуудалдаа оролцооны түвшин муу гэж хариулсан нь хүүхдийн оролцох эрхийг хангахад мэдээлэлтэй байх нь хэр чухал болохыг харуулж байна.

## Дүрс 5: Мэдээлэлгүй бүлгийн хүүхдийн оролцооны түвшин



Дээрх дүрсээс харахад хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй бүлгийн хувьд бүх түвшний оролцоо ихэнхдээ муу байгаа нь харагдаж байна.

Хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй бүлгийн шинж байдлыг нэгтгэж авч үзвэл, оролцох сэдэл бага, оролцооны түвшин муу, мөн мэдээлэлгүй байгаа шалтгаан нь мэдээлэл авах боломжгүй /зорилтот бүлгийн хүүхдүүд/, мөн насны ангилал зэрэгтэй холбогдож байна.

### 2.2.2 Бага зэрэг мэдээлэлтэй бүлэг

Судалгааны энэ хэсэгт нийт судалгаанд оролцогсдын 56.9 хувь буюу “хүүхдийн оролцох эрхийн талаар бага зэргийн мэдээлэл авдаг” гэж хариулсан бүлгийг хамруулан ойлгох юм. Энэ бүлгийн насны хувьд 40.4 хувь нь 12 -15 насны хүүхдүүд, 37.1 хувь нь 16 – 18 насны хүүхдүүд байна.

### Хүснэгт 6. Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн ерөнхий шинж байдал


|   | Тоо | Хувь |
|---|-----|------|
| <b>Суралцдаг байдал</b>                 |     |      |
| Суралцдаггүй                            | 7   | 2.9  |
| Албан бус боловсрол                     | 1   | .4   |
| Бага анги                               | 52  | 21.7 |
| Бүрэн бус дунд                          | 42  | 17.5 |
| Бүрэн дунд                              | 137 | 57.1 |
| Тусгай мэргэжлийн коллеж                | 1   | .4   |
| <b>Өрхийн амьжиргаа</b>                 |     |      |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэггүй | 8   | 3.3  |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэг    | 76  | 31.7 |

|  |    |      |
|--|----|------|
| Өдөр тутмын хоол хүнснээс гадна хувцас, хэрэглэл авч чаддаг        | 65 | 27.1 |
| Хувцас хэрэглэлээс гадна хүссэн зүйлээ авч чаддаг                  | 51 | 21.3 |
| Би хувьдаа хадгаламж нээсэн, манай гэрийн орлого хангалттай хүрдэг | 37 | 15.4 |

Энэ бүлгийн өрхийн амьжиргааны түвшинг харвал 35 хувь нь амьжиргааны түвшин дундаас доогуур, 27.1 хувь нь дунд түвшний амьжиргаатай үлдсэн 36.7 хувь нь дундаас дээгүүр түвшний орлоготой байгаа нь харагдаж байна.

Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн хүүхдүүдээс хүүхдийн оролцоог бий болгоход цаашид ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатайг асуухад 37.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Энэ бүлгийн хүүхдүүдийн 36.7 хувь нь хүүхдэд чиглэсэн ямар нэгэн ажил хийх шаардлагатай гэсэн санал гаргасан байна. Энэ нь тэд мэдээлэлгүй бүлгийг бодвол оролцох идэвх илүү байгааг харуулж байна.

#### Дүрс 6: Бага зэргийн мэдээлэлтэй бүлгээс дэвшүүлсэн хүүхдийн оролцоог бий болгох санал




Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийнхэн хүүхдийн оролцоог нэмэгдүүлэхэд эцэг эх, гэр бүлд зориулсан ямар нэгэн ажил хийх шаардлагатай гэж 13.3 хувь нь үзсэн бол 5.4 хувь нь хороотой хамтарч ажиллах шаардлагатай гэж үзсэн байна. Энэ нь хүүхдийн хувьд Орон нутгийн засаг захиргааны анхан шатны нэгж буюу хороо хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд ямар нэгэн хамааралтай гэсэн ойлголт бага түвшинд ч гэсэн байгааг дээрх зургаас харж болно.

Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн хүүхдүүдийн гэр бүл, сургууль, хорооны шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нь үзвэл мэдээлэлгүй бүлгийн хүүхдүүдээс харьцангуй идэвхтэй байна. Доорх дүрсээс /дүрс 6/ харахад бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн хорооны үйл ажиллагаан дахь оролцоо мэдээлэлгүй бүлэгтэй харьцуулахад 4

хувиар илүү үзүүлэлттэй байна. Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн хүүхдүүдийн хувьд 4.2 хувь нь хорооны шийдвэр гаргах түвшинд сайн оролцдог гэж хариулсан байгаа бөгөөд энэ нь өмнөх бүлгийн үзүүлэлтээс 2 хувиар илүү үзүүлэлттэй байна. Харин сургуулийн түвшин дэх оролцоо нь энэ бүлгийн хувьд мэдээлэлгүй бүлгээс 23.6 хувиар илүү, огт оролцдоггүй хүүхдийн тоо харьцангуй бага байна.

#### Дүрс 7: Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн оролцооны түвшин



Бага зэргийн мэдээлэлтэй бүлгийн гэр бүлийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо мэдээлэлгүй бүлгийнхнээс илүү идэвхтэй буюу 12.6 хувиар илүү оролцоотой байдаг нь харагдаж байна.

#### Шигтгээ 1

*Хүүхдийн оролцох эрхийн талаар сонсож байсан бол хаанаас сонсож байсан бэ?*

*... Нийгмийн хичээл дээр зааж байсан. Тэхэд л сонсож байсан юм байна ...*

*... Оролцох эрхтэй гэж сонсож байгаагүй. Миний бодлоор оролцох эрх гэж хүүхэд өөрийнхөө хүслээр дуу хоолойгоо хүргэж байгааг хэлэх байх. Хүүхдийг хүсэхгүй байхад заавал хүүхдийг оролцуулах гэж хүчлэх ёсгүй гэж бодож байна. ...*

*2012.11.06 / 14–17 насны сурагчид. f 5. Сонгино хайрхан дүүрэг /*

Мэдээллийн эх сурвалжийн хувьд хүүхдүүд мэдээллийн өргөн, хурдтай сүлжээ нэвтэрсэн өнөө үед хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг зөвхөн хичээлээс сонсдог гэсэн дүгнэлт фокус бүлгийн ярилцлагаас гарч ирж байна.

### 2.2.3 Мэдээлэл сайн бүлэг

Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээлэл сайн бүлэг гэдэгт асуулга судалгаанд “оролцох эрхийн талаар байнгын мэдээлэлтэй байдаг” гэж хариулсан буюу нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 15.2 хувийг хамруулж ойлгоно.

#### Хүснэгт 7: Мэдээлэл сайн бүлгийн ерөнхий шинж байдал

|  | Тоо | Хувь |
|--|-----|------|
| <b>Хүйс</b>  |     |      |
| Эрэгтэй  | 28  | 43.8 |
| Эмэгтэй  | 36  | 56.3 |
| <b>Суралцдаг байдал</b>  |     |      |
| Суралцдаггүй   | 4   | 6.3  |
| Албан бус боловсрол  | 14  | 21.9 |
| Бага анги  | 15  | 23.4 |
| Бүрэн бус дунд   | 14  | 21.9 |
| Бүрэн дунд   | 17  | 26.6 |
| Тусгай мэргэжлийн коллеж   | 1   | .4   |
| <b>Өрхийн амьжиргаа</b>  |     |      |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэггүй                            | 4   | 6.3  |
| Өдөр тутмын хоол хүнсэндээ хүрэлцдэг                               | 14  | 21.9 |
| Өдөр тутмын хоол хүнснээс гадна хувцас, хэрэглэл авч чаддаг        | 15  | 23.4 |
| Хувцас хэрэглэлээс гадна хүссэн зүйлээ авч чаддаг                  | 14  | 21.9 |
| Би хувьдаа хадгаламж нээсэн, манай гэрийн орлого хангалттай хүрдэг | 17  | 26.6 |

Мэдээлэл сайтай бүлгийн хүйсийн хувьд 56.3 хувь нь эмэгтэй, 43.8 хувь нь эрэгтэй хүүхдүүд байгаа бол сургуульд хамрагдалтын хувьд байдлын хувьд 28.2 хувь нь суралцдаггүй, үлдсэн 72.8 хувь нь ямар нэгэн байдлаар суралцдаг ажээ. Тэдний өрхийн 28.2 хувь нь дундаас доогуур орлоготой, 23.4 хувь нь дунд орлоготой, 48.5 хувь нь дундаас дээгүүр орлоготой байна. Өмнөх хоёр бүлгийг бодвол энэ бүлгийн өрхийн амьжиргааны түвшин харьцангуй өндөр байна.


Энэ бүлгийн хүүхдүүд оролцооны хувьд харьцангуй идэвхтэй байгааг доорх дүрсээс харж болно. Хүүхдийн оролцоог бий болгоход ямар үйл ажиллагаа зохион байгуулахыг мэдэхгүй гэж хариулсан хүүхдийн хувь бусад бүлгээс эрс бага байна.

**Дүрс 8: Мэдээлэл сайн бүлгийн хүүхдийн оролцоог бий болгох талаарх санал**



Мэдээлэл сайн бүлгийн хувьд хорооны түвшинд оролцоо байхгүй гэж уг бүлгийн 84.4 хувь нь үзсэн нь бусад хоёр бүлгийг бодвол харьцангуй дээгүүр үзүүлэлттэй буюу бага зэргийн мэдээлэлтэй бүлгээс 4.8 хувиар бага дүнтэй байгаа нь харагдаж байна. Харин сургуулийн түвшинд энэ бүлгийн тал хувь нь оролцдоггүй ажээ.

**Дүрс 9: Мэдээлэл сайн бүлгийн оролцооны түвшин**



Гэр бүлийн түвшинд тэдний оролцоо 25 хувьтай байгаа бол сургуулийн түвшинд 17.2 хувь нь оролцож байгаа бол 7.8 хувь нь хороонд оролцож байгаа нь мэдээлэлгүй болон бага зэргийн мэдээлэлтэй бүлгийг бодвол харьцангуй өндөр үзүүлэлт юм.

### **2.3 Хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт**

Хүүхдийн оролцох эрхийн талаар ойлголт гэдэгт Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн үндсэн зарчмуудын нэг болох 12-р зүйлд заасан тодорхойлолтыг ойлгоно. Энд хүүхэд өөрт хамааралтай аливаа асуудлаар саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхтэй бөгөөд тэдний нас болон хөгжлийн байдлаас хамаарч тэдний үзэл бодолд ач холбогдол өгөх ёстойг онцолжээ. Бид судалгааны түүвэртээ хүүхдийн нас болон хөгжлийг харгалзан ерөнхий боловсролын сургуулийн 3–р ангиас дээш буюу 8 наснаас дээшхи хүүхдийг сонгон авсан бөгөөд, энэ насанд хүүхдүүд санал бодлоо илэрхийлж, оролцох зохих чадвартай гэж үзсэн.

Мөн ойлголтыг тодорхойлохдоо хүүхдийн оролцох эрхийг юу гэж үзэж байгааг асуусан 5 бодомжийг жагсаан хүүхдүүдийн дунд асуулга хэлбэрээр судалсан. 5 бодомжоо үнэлэхэд тохиромжтой болгохын тулд огт ойлголтгүйгээс маш сайн ойлголттой гэсэн эрэмбэлсэн үнэлгээ өгч болохуйц асуусан. Энэ хэсэгт бид хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтын хувьд “буруу ойлголттой”, “бага ойлголттой”, “маш сайн ойлголттой” гэсэн хэсгүүдэд хувааж үзэх болно.

- “Хүүхдийн оролцох эрхийн талаар буруу ойлголттой хэсэг” –Өгсөн бодомжуудаас, хүүхэд томчуудын асуудалд оролцох ёсгүй гэж үзсэн хүүхдүүдийг энэ хэсэгт хамруулна.
- “Хүүхдийн оролцох эрхийн талаар бага ойлголттой хэсэг” – Өгөгдсөн бодомжуудаас, хүүхдийн санал бодлыг сонсдог байх, хүүхдийн санал бодлыг томчууд сонсоод шийдвэртээ тусгадаг байх гэж хариулсан хэсгийг хамруулна.
- “Хүүхдийн оролцох эрхийн талаар сайн ойлголттой хэсэг” – Өгөгдсөн бодомжуудаас, хүүхдийн санал бодлыг томчууд хамтран зөвшилцөж шийдвэр гаргадаг байх, хүүхэд өөрт тулгарсан асуудлыг өөрөө томчуудад илэрхийлж, хамтран шийдвэр гаргадаг байх гэж хариулсан хүүхдүүдийг ойлгох болно.

Хүүхдүүд шийдвэр гаргах түвшинд өөрсдийн оролцоог дараах байдлаар ойлгож байна.




**Дүрс 10: Хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтын түвшин**



Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дийлэнх нь томчуудад үзэл бодлоо илэрхийлэх, тэдэнтэй хамтран шийдвэр гаргах хүсэлтэй байдаг нь харагдаж байна.

Зорилтот бүлгийн хүүхдүүдийн ихэнх нь хүүхдийн оролцох эрхийн ойлголт энгийн ЕБС-д суралцдаг хүүхдүүдтэй ойролцоо түвшинд байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 62.5 хувь нь бага зэргийн ойлголттой байгаа нь бусад зорилтот бүлгээс харьцангуй доогуур үзүүлэлт юм. Хараа хяналтгүй хүүхдүүдийн 68.8 хувь нь, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн 62.5 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт сайн байгаа нь доорх дүрсээс /дүрс 10/ харагдаж байна.

## Дүрс 11: Зорилтот бүлгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт



### 2.3.1 Буруу ойлголттой хэсэг


Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 7.5 хувь буюу 32 нь “хүүхдүүд томчуудын асуудалд оролцох ёсгүй” гэж үзсэн байна. Энэ хэсгийн дийлэнх нь бага насны хүүхдүүд байна. Мөн хүүхдийн оролцох эрхийн талаар буруу ойлголттой хэсгийн хувьд 15.6 хувь нь хөдөлмөр эрхэлдэг гэсэн үзүүлэлттэй байна. Эдгээр үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

### Хүснэгт 8: Буруу ойлголттой хэсгийн ерөнхий шинж байдал

| Ерөнхий мэдээлэл                                       |     |      |
|--|-----|------|
|  | Тоо | Хувь |
| <b>Нас</b>   |     |      |
| 8-11   | 18  | 56.3 |
| 12-15  | 10  | 31.3 |
| 16-18  | 4   | 12.5 |
| <b>Хөдөлмөр эрхлэлтийн байдал</b>                      |     |      |
| Сургуульд явдаггүй, хөдөлмөр эрхэлдэггүй гэртээ байдаг | 5   | 15.6 |
| Сургуульд явдаггүй хөдөлмөр эрхэлдэг                   | 4   | 12.5 |
| Сургуульдаа ч явдаг хөдөлмөр эрхэлдэг                  | 1   | 3.1  |
| Сургуульдаа л явдаг хөдөлмөр эрхэлдэггүй               | 22  | 68.8 |

Буруу ойлголттой хүүхдүүдийн ихэнх нь хүүхдийн оролцох эрхийн талаар сонсож байгаагүй, 34.4 хувь нь бага зэргийн мэдээлэл авч байсан гэж хариулсан бол 9.4 хувь нь байнгын мэдээлэлтэй байдаг гэсэн үзүүлэлттэй байна. Энэ нь хүүхдийн оролцох эрхийн талаар буруу ойлголттой хэсгийн хувьд хүүхдийн оролцох эрхийн мэдээллийн хүртээмж хомс байна гэдгийг харуулж байна.

**Дүрс 12: Буруу ойлголттой хэсгийн хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээллийн хүртээмж**



Эндээс харахад хүүхдийн оролцох эрхийн талаар зөв ойлголттой байх нь мэдээллийн хүртээмжтэй шууд хамааралтай байна. Мөн бага насны хүүхдүүдийн дунд томчуудад үзэл бодлоо илэрхийлэх тэдэнтэй хамтран шийдвэр гаргах тухай ойлголт хараахан төлөвшөөгүй байна. Энэ нь буруу ойлголттой хэсгийн 56.3 хувь нь бага насны хүүхдүүд байгаагаас харагдаж байна.

### 2.3.2 Бага ойлголттой хэсэг

Хүүхдийн оролцох эрхийн талаар бага ойлголттой хэсэг нь нийт судалгаанд оролцогсдын 30.8 хувийг эзэлж байна. Энэ хэсгийн насны ангилал харьцангуй жигд байна. Мөн бага ойлголттой хэсгийн 19.2 хувийг хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүд эзэлж байна. Эдгээр үзүүлэлтийг хүснэгтээр харуулвал:

**Хүснэгт 9: Бага ойлголттой хэсгийн ерөнхий шинж**

| Ерөнхий мэдээлэл                                       |     |      |
|--|-----|------|
|  | Тоо | Хувь |
| <b>Нас</b>   |     |      |
| 8-11   | 42  | 32.3 |
| 12-15  | 49  | 37.7 |
| 16-18  | 39  | 30.0 |
| <b>Ажил эрхлэлтийн байдал</b>                          |     |      |
| Сургуульд явдаггүй, хөдөлмөр эрхэлдэггүй гэртээ байдаг | 14  | 10.8 |

|  |    |      |
|--|----|------|
| Сургуульд явдаггүй хөдөлмөр эрхэлдэг     | 9  | 6.9  |
| Сургуульдаа ч явдаг хөдөлмөр эрхэлдэг    | 16 | 12.3 |
| Сургуульдаа л явдаг хөдөлмөр эрхэлдэггүй | 91 | 70.0 |

Бага ойлголттой хэсгийн 83.8 хувь нь их бага ямар нэг хэмжээний мэдээлэлтэй байдаг ажээ.

### Дүрс 13: Бага ойлголттой хэсгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн хүртээмж



### 2.3.3 Маш сайн ойлголттой хэсэг

Нийт судалгаанд оролцогсдын 61.6 хувь нь “томчуудтай хамтран шийдвэр гаргах түвшинг хүүхдийн оролцох эрх гэж ойлгоно” гэж хариулсан нь хүүхэд бүр томчуудтай эрх тэгш хамтран шийдвэр гаргахыг хүсдэг, үүнийгээ зөв гэдгийг ухамсарласан байдгийг харуулж байна. Насны хувьд маш сайн ойлголттой хэсэг нь 27.7 хувь бага насны буюу 8 – 11 насны хүүхдүүд, 12 -15 насны хүүхэд 38.8 хувь эзэлж байгаа бол үлдсэн 33.5 хувийг 16 – 18 насны хүүхдүүд эзэлж байна.

### Хүснэгт 10: Маш сайн ойлголттой хэсгийн ерөнхий шинж

| Ерөнхий мэдээлэл |     |      |
|------------------|-----|------|
|                  | тоо | хувь |
| Нас              |     |      |
| 8-11             | 72  | 27.7 |
| 12-15            | 101 | 38.8 |

|  |     |      |
|--|-----|------|
| 16-18  | 87  | 33.5 |
| Хөдөлмөр эрхлэлтийн байдал                             |     |      |
| Сургуульд явдаггүй, хөдөлмөр эрхэлдэггүй гэртээ байдаг | 12  | 4.6  |
| Сургуульд явдаггүй хөдөлмөр эрхэлдэг                   | 16  | 6.2  |
| Сургуульдаа ч явдаг хөдөлмөр эрхэлдэг                  | 33  | 12.7 |
| Сургуульдаа л явдаг хөдөлмөр эрхэлдэггүй               | 198 | 76.2 |

Хөдөлмөр эрхлэлтийн байдлын хувьд авч үзвэл маш сайн ойлголттой хэсгийн 18.9 хувийг хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд эзэлж байна.

Энэ хэсгийн хүүхдүүд хүүхдийн оролцох эрхийн талаар тодорхой мэдээлэлтэй гэж хариулсан нь буруу ойлголттой болон бага зэрэг ойлголттой хэсгээс илүү байна.

#### Дүрс 14: Маш сайн ойлголттой хэсгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн хүртээмж



Дээрх гурван хэсгийн ерөнхий шинжийг харвал, судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 61.6 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаар ойлголт сайн байгаа нь хүүхэд бүр насанд хүрэгчидтэй эрх тэгш хамтран шийдвэр гаргахыг хүсдэг, үүнийгээ зөв гэдгийг ухамсарласан байдаг. Мөн фокус бүлгийн ярилцлагын үр дүнгээс харахад хүүхдүүд хэдий энэ талаар мэдээлэл бага байсан ч ойлголтын хувьд том хүнтэй эрх тэгш хамтран шийдвэр гаргах ёстойгоо ойлгож байгаа нь харагдаж байсан юм.

#### Шигтгээ 2

*Хүүхдийн оролцооны эрх гэж та бүхний бодлоор юу вэ?*

*... Хүүхэд өөрөө өөрийгөө илэрхийлэхийг хүүхдийн оролцоо гэдэг байх. Нийгмийн хичээл дээр сонсож байсан юм байна...*

*... Хүүхэд ер нь эцэг эхтэйгээ илүү нээлттэй байнгын –харилцаатай оролцдог, сургуулийн түвшинд бол сонсогч маягаар оролцдог...*

*2012.11.06 /13 – 16 насны сурагчид. f4 Сонгинохайрхан дүүрэг/*


Буруу ойлголттой хэсгийн 56.3 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэлгүй гэж хариулсан бол маш сайн ойлголттой хэсгийн 61.2 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаар бага зэргийн мэдээлэл авч байсан гэж хариулсан нь хүүхдийн оролцох эрхийн талаар ойлголт нь хүүхдийн оролцох эрхийн мэдээллийн хүртээмжтэй шууд хамааралтай байгааг харуулж байна. Буруу ойлголттой хэсгийн 56.3 хувийг бага насны хүүхдүүд эзэлж байгаа нь бага насны хүүхдүүдийн хувьд томчуудад үзэл бодлоо илэрхийлэх тэдэнтэй хамтран шийдвэр гаргах тухай ойлголт хараахан төлөвшөөгүй байгааг харуулж байна. Бид хүүхдийн оролцооны эрхийн хэрэгжилтийг хангахын тулд хүүхдүүд өөрсдөө оролцоо гэдгийг юу гэж ойлгож байгаа болон хүүхдийн оролцох эрхийг хангахад энэ нь хэрхэн нөлөөлж болох талаар судлах нь чухал билээ.

#### ***2.4 Хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин /гэр бүл, сургууль, хороо/***

Хүүхдийн оролцооны түвшинг тодорхойлохын тулд бид хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог тохируулан асуулгыг бэлтгэх хэрэгтэй болсон. Энэ үүднээс Рожер Хартын оролцооны шатлалаар 12-оос дээш насныханд зориулан гэр бүл, сургууль, хороо гэсэн 3 түвшинд үнэлгээ хийсэн бол 8 – 11 насныханд оролцоо муу, оролцоо дунд болон оролцоо сайн гэсэн гурван үнэлгээг гэр бүл, сургууль, хороо гэсэн 3 түвшинд хийсэн болно. Энэ аргачлалын дагуу хүүхдийн оролцооны өнөөгийн түвшинг тодруулахад, хүүхэд сургууль, хороо гэхээсээ илүүтэй гэр бүлийн шийдвэр гаргалтад идэвхтэй оролцдог байна. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 21.6 хувь нь гэр бүлдээ сайн оролцоотой гэж хариулсан байна. Энэ үзүүлэлт нь сургуульдаа оролцоотой гэсэн хэсгээс даруй 9 хувиар илүү, хороотой харьцуулж үзэхэд даруй 17.3 хувиар илүү байгаа нь харагдаж байна. Хэдийгээр бид нийт судалгаанд оролцогсодын 45.3 хувь нь гэр бүлийн шийдвэр гаргах түвшинд оролцохгүй байна гэж харж болох ч сургууль болон хорооны түвшинтэй харьцуулбал оролцоо сайтай байгааг харж болно. (Дүрс 5, 7, 9)


Хорооны үйл ажиллагаан дахь оролцооны түвшин бусад хоёр талбартай харьцуулахад маш бага өөрөөр хэлбэл гэр бүлийн түвшинд оролцдоггүй гэсэн хэсгээс 56.4 хувиар их, сургуулийн түвшинд оролцдоггүй гэсэн хэсгээс 37.9 хувиар илүү байгаа нь тус бүрдээ хорооны шийдвэр гаргалтанд хүүхэд оролцохгүй байгааг харуулж байна.

**Дүрс 15: Хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин**



Хүүхдүүдийн оролцооны эрхийг хангахад хүүхдүүдэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг хүүхдийн оролцооны байгууллагын өнөөгийн үйл ажиллагаа тун чухал нөлөөтэй билээ. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд доорх хүүхдийн байгууллагуудын үйл ажиллагаанд хамрагддаг гэсэн үзүүлэлтүүд гарсан байна. Үүнийг дүрсээр харвал:

**Дүрс 16: Хүүхдийн оролцооны байгууллагад хамрагдалтын хувь**



Дэлхийн зөн ОУБ - ын үүсгэл санаачлагатай “Хүүхдийн зөн” байгууллагын үйл ажиллагаанд судалгаанд хамрагдсан хүүхдүүд харьцангуй идэвхтэй оролцдог ажээ. Үүний дараагаар сургуулийн сурагчдын зөвлөлийн үйл ажиллагаа орж байна. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 36.5 хувь нь сурагчдын зөвлөлийн үйл ажиллагаанд оролцдог гэсэн үзүүлэлттэй байна. Мөн сурагчдын холбоонд хүүхдүүдийн 26.3 хувь нь оролцдог гэсэн хариултыг өгсөн байна. Мөн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 0.9 хувь нь ангийн зөвлөл, Хүүхдийн төлөө газар, Залуу эмч клуб, Хөгжлийн клуб, “V star”, бүжгийн хамтлаг


зэрэг хүүхдийн байгууллага, клуб-т хамрагддаг ажээ. Мөн судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 45.3 хувь нь хүүхдийн чуулга, уулзалтад оролцож байжээ.

#### Хүснэгт 11: Хүүхдийн чуулга, уулзалтад хамрагдалтын хувь

| Та ямар нэгэн хүүхдийн чуулга, уулзалт хэлэлцүүлэг хуралд оролцож байсан уу? | Тоо | Хувь |
|--|-----|------|
| Тийм   | 191 | 45.3 |
| Үгүй   | 231 | 54.7 |

Гэр бүл, сургууль, хороо гэсэн гурван хэсгүүдийн оролцооны түвшинг нэгтгэж харвал оролцоо муу гэж хүүхдүүдийн 58.1 хувь нь үзсэн байна.

#### Дүрс 17: Хүүхдийн оролцооны өнөөгийн ерөнхий түвшин



Дээр дурьдсанчлан, бид судалгаандаа хүүхдийн оролцоог 12 – оос дээш насны хүүхдүүдэд Рожер Хартын шатлалыг ашиглан үнэлсэн билээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

#### Хүснэгт 12: Рожер Хартын шатлалаар хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин

| № | Рожер Хартын оролцооны түвшин  | Гэр бүл | Сургууль | Хороо |
|---|--|---------|----------|-------|
| 1 | Би оролцдоггүй   | 12.8%   | 22.0%    | 73.3% |
| 2 | Би асуудалд оролцдог гэхдээ надад мэдээлэл өгдөггүй, зүгээр л сонсдог                                    | 11.5%   | 11.1%    | 9.8%  |
| 3 | Миний саналыг асуудаг боловч хайхардаггүй  | 9.8%    | 7.8%     | 5.7%  |
| 4 | Би яаж оролцохоо мэддэг, гэхдээ тухайн асуудалд оролцох үгүйгээ би өөрөө шийддэг                         | 13.2%   | 21.6%    | 4.1%  |
| 5 | Би идэвхтэй байнга оролцдог боловч миний саналыг хэрхэн асуудалд тусгасан шийдвэр нь тодорхой бус үлддэг | 2.7%    | 11.8%    | 2.7%  |
| 6 | Би саналаа хэлж хамтран шийдвэр гаргадаг   | 29.7%   | 12.5%    | 1.0%  |
| 7 | Би өөрт тулгарсан асуудлаа өөрөө шийддэг   | 12.8%   | 8.4%     | 2.7%  |
| 8 | Би асуудлыг өөрөө гаргаж ирж хамтран шийдвэр гаргадаг.   | 7.4%    | 4.7%     | .7%   |



Хорооны түвшинд сайн, дунд, муу гэсэн 3 үнэлгээг нэгтгэхэд 89.6 хувь нь оролцоогүй гэж байсан бол Рожер Хартын шатлалаар 73.3 хувь нь огт оролцдоггүй гэсэн хариулт өгсөн байна. Ер нь хорооны түвшинд хүүхэд огт оролцдоггүй байна.

#### 2.4.1 Хүүхдийн оролцоонд тулгардаг бэрхшээл, түүний шалтгаанууд

Хүүхэд шийдвэр гаргах түвшинд оролцож чадахгүй байгаа гол шалтгаан нь оролцооны талаарх мэдээлэлгүй байгаа явдал юм. Энэ нь мэдээлэлгүй хүүхдүүдийн 44.1 хувь нь гэр бүлийн түвшинд ч шийдвэр гаргалтад оролцдоггүй гэсэн үзүүлэлтээс харагдаж байна. Хэдий хүүхдүүд шийдвэр гаргах түвшинд насанд хүрэгчидтэй ижил түвшинд оролцохыг хүсдэг ч тэдэнд мэдээлэл болон оролцох туршлага дутаж байна.

*Хүүхдүүд оролцох эрхтэй гэж сонсож байсан уу?*

*...Үгүй, бид нар өөрсдийн ойлголтоор л асуудалд оролцдог...*

*/Сонгино хайрхан дүүрэг. 14 – 17 нас. 2012.11.06 f5/*

*...Хүүхдийн өөрийгөө хөгжүүлэх үйл явцыг ойлгож байна. Гэхдээ оролцох эрхтэй гэж сонсож байгаагүй юм байна...*

*/Чингэлтэй дүүрэг. 19 – 21 нас. 2012.11.06 f6/*

Хүүхдүүд хэдий оролцох эрхийн талаар ойлголттой байсан ч тэднийг эргэн тойрны насанд хүрэгчид мөн шийдвэр гаргагч нарын биеэ авч яваа байдал нь зайгаа барихад хүргэдэг тухай хүүхдүүд дурдаж байсан юм. Тэднийг санал бодлоо илэрхийлэхэд нь загнах, буруутгах, дорд үзэх зэрэг хандлага нь хүүхдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулахад саад болж буй хүчин зүйлийн нэг болж байна.

*Хүүхдүүд оролцоход та нарын бодлоор юу саад болж байна вэ?*

*Оролцоод байхад урам унтраадаг том хүмүүс зөндөө байдаг...*

*Хүүхдүүд бидэнд томчуудтай харилцахад айдас байдаг...*

*/Сонгино хайрхан дүүрэг. 14 – 17 нас. 2012.11.06 f5/*

*Хүүхдүүдэд томчууд гэхээр нэлээн хол санагддаг. Асуудлаа эцэг эхээсээ өөр том хүнтэй хуваалцана, өөрийн үзэл бодлоо илэрхийлнэ гэдэг тодорхой айдастай байнга тулгарч байдаг.*

*/Чингэлтэй дүүрэг. 19 – 21 нас. 2012.11.06 f6/*

Мөн нийгмийн тогтсон хандлага хүүхдийн оролцоонд шууд нөлөөлж байна. Гэр бүлийн түвшинд хүүхдийг насны байдлаар харгалзан шийдвэр гаргалтанд оролцуулдаг, сургуулийн түвшинд зөвхөн идэвхитэй хэдхэн хүүхэд шийдвэр гаргалтад нөлөөлж оролцдог зэрэг нь эдгээр түвшинд хүүхдийн оролцоог ихээр бууруулж байна. Өөрөөр хэлбэл бид ахлах ангийн болон дунд ангийн сурагч, тэр тусмаа ангийн дарга болон сурагчдын зөвлөлийн хүүхдүүдийн саналыг илүү ач холбогдол өгөн сонсдог байдлаас үүдэн нийт хүүхдүүдийн оролцооны эрх хангагдаж чадахгүй байна.

Хүүхдийн оролцоог хангахад зорилтот бүлгийн хүүхдийн оролцох эрхийг хангах нь чухал ач холбогдолтой билээ. Гэвч эдгээр бүлгийн оролцоо муу, мэдээллийн түвшин доогуур байгаа нь, эдгээр хүүхдүүд сургуулийн болон гэр бүлийн орчиноос хөндийрсөн байдагтай холбоотой. Гэтэл хүүхдүүдэд нөлөөлөх, тэднийг оролцуулах ихэнхи ажлууд боловсролын газраар дамжин сургуулиудад хэрэгжиж байгаа нь тэдний үзэл бодлыг сонсох, тэднийг оролцуулах эрхийг хязгаарлагдмал болгож байна. Судалгаанд хамрагдсан хүчирхийлэлд

өртсөн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хорооны түвшинд огт оролцдоггүй. Гэр бүлийн түвшинд бүртгэлгүй хүүхдүүдийн 71.4 хувь нь, сургууль завсардсан хүүхдүүдийн 57.9 хувь нь өөрсдийн оролцоог муу гэж үнэлсэн байна.

## БҮЛЭГ 3. ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 3.1. Хүүхдийн оролцооны түвшин

Гэр бүл нь хүүхдийн анхдагч орчин учраас хүүхдийн хүмүүжлийн болон нийгэмшлийн анхдагч эх сурвалж болдог. Тиймээс гэр бүл бол хүүхдийн засаглалд оролцох эхний шат гэж нэрлэж болно. Хүүхэд гэр бүлийнхээ тодорхой асуудлуудад оролцож байгаа эсэх, эцэг эх, гэр бүлийхэнтэйгээ санал бодлоо хуваалцаж, тодорхой шийдвэр гаргалтад оролцож байгаа эсэх нь тухайн хүүхэд сургууль ба орон нутгийн түвшинд оролцох бэлтгэл, туршлага болох билээ. Хүүхдийн оролцоо энэ түвшинд ямар байгааг тодруулан авч үзье.

Нийт судалгаанд оролцсон хүүхдүүдийн гэр бүлийн оролцооны түвшинг “Хүүхэд гэр бүлийн шийдвэр гаргалтад хэрхэн оролцож байна вэ?” гэсэн асуултаар тодорхойлж Рожер Хартын 8 шатлалаар авч үзсэн.

Дүрс 18: Гэр бүл дэх хүүхдийн оролцооны түвшин /Рожер Хартын оролцооны шат /



Нийт судалгаанд оролцогсдын 45.3 хувь нь гэр бүлийн түвшинд “оролцоо дунд зэрэг” буюу хүүхэд өөрөө хэрхэн оролцохоо мэдэж байгаа, хүүхдийн саналыг гэр бүлийнхэн сонсдог боловч эцэст нь томчууд голчлон шийдвэр гаргадаг гэж хариулсан бол 33.2 хувь нь “оролцоо муу” буюу хүүхэд гэр бүлийнхээ тодорхой шийдвэрт оролцдоггүй,

гэр бүлийнхнийгээ зүгээр л сонсдог, саналаа хэлсэн ч гэр бүлийнхэн нь хайхардаггүй, 21.6 хувь нь гэр бүлдээ “оролцоо сайн” буюу хүүхэд өөрт тулгарсан асуудлыг өөрөө илэрхийлж, гэр бүлийхэнтэй зөвлөлдсөний үр дүнд шийдвэр гаргадаг гэж хариулсан байна. Эндээс харахад гэр бүлийн орчин хэдийгээр хүүхдэд хамгийн ойр бүлэг болохын хувьд сургууль хороо гэх мэт нийгмийн бусад оролцооны талбартай харьцуулбал оролцоо өндөр байгаа боловч гэр бүлийн шийдвэр гаргалтад хүүхдийн оролцоо тийм ч сайнгүй байгаа нь харагдаж байна.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 21.6 хувь нь буюу таван хүүхэд тутмын нэг нь гэр бүлийн түвшиндээ оролцоо нь сайн гэж үнэлэгдсэн нь гэр бүлийнхээ аливаа шийдвэр гаргалтад хүүхдүүд оролцдог, мөн тэдэнтэй эцэг эхчүүд зөвлөлддөг байна. Тийм ч учраас энэ бүлгийн хүүхдүүдийн хувьд дараагийн түвшинд буюу сургууль, хорооны түвшинд оролцож, өөрийн санал бодлоо нээлттэй илэрхийлэх боломжтой болох юм.

#### Шигтгээ 1

*Охин минь гэр бүлийн түвшинд оролцдог. Өөртэй нь холбоотой зүйл байтугай гэр бүлдээ хамаатай бусад асуудалд ч хамт сууж байгаад хэлэлцдэг. Манай гэр бүлийн хувьд хүүхдийн оролцоо бүрэн хангагдсан гэж хэлж болно.  
2012.11.08 /Эцэг эхийн төлөөлөл. р 5. Сонгино хайрхан дүүрэг /*

Гэр бүлдээ оролцоо сайн байгаа хүүхдүүдийн хувьд эцэг эхийн зүгээс хүүхдээ сонсдог, гэр бүлийн аливаа шийдвэрт оролцуулдаг байх нь чухал. Гэр бүлдээ “оролцоо сайн” хүүхдүүдийн хувьд насны онцлогоос шалтгаалан оролцоо нь өөр өөр хэлбэрээр илэрч байгаа бөгөөд арай илүү бие дааж эхэлж буй дунд насны хүүхдүүдийн хувьд гэр бүлийн аливаа шийдвэрт оролцох, санал бодлоо илэрхийлэх нь арай илүү байх хандлага байна.

#### Шигтгээ 2

*Том охиноосоо бол асуугаад санал бодлыг нь сонсдог. Харин бага хүүхдээсээ санал бодлыг нь асуулгүй өөрсдөө төлөвлөн шийдвэрлэдэг. Хувцас, хичээлийн хэрэгсэл зэргийг авахдаа хүртэл томоос нь асуугаад, бага хүүхдэдээ өөрсдөө сонголт хийгээд авдаг.  
2012.11.07 /Эцэг эхийн төлөөлөл. р 15. Чингэлтэй дүүрэг /*

Гэр бүлдээ “оролцоо дунд зэрэг” гэж үнэлэгдсэн хүүхдүүдийн хувьд 45.3 хувь буюу олонхийг эзэлж байна. Гэр бүлдээ дунд зэрэг оролцож байгаа хүүхдүүдийн хувьд гэр бүлийнхэнтэйгээ тодорхой асуудлын талаар ярьж зөвшилцдөг ч, хүүхэд өөрөө бие даан санал гаргаж, шийдвэрээ хамт гаргадаггүй, өөрөөр хэлбэл, гэр бүлийнхэн нь тодорхой асуудал дээр хүүхдийн саналыг сонссоны дараа өөрсдөө бие даан шийдвэр гаргаж байгаа тохиолдлыг ойлгож байгаа.

Зарим эцэг эхчүүд болон хүүхдүүд хүүхдийн оролцоо гэдгийггэр орноо цэвэрлэх, дүү нараа халамжлах, эцэг эхдээ туслах гэх мэт үүрэг гүйцэтгэж, ахуйн хүрээнд гэр бүлдээ туслах явдал гэж үзэх хандлага ажиглагдаж байна.

### Шигтгээ 3

*...Хашааныхаа хогийг цэвэрлэх, нохойны хоол өгөх, ус авах, мод хагалах, дүүгээ цэцэрлэгээс авах зэргээр оролцдог. Ямар нэгэн ажил давхацвал гэрийн ажлыг түрүүлж хийдэг. Энийг л гэр бүлдээ оролцох гэнэ байх.  
2012.11.07 /12-15 насны сурагчид.f1, Налайх дүүрэг/*

Зарим хүүхдийн хувьд гэр бүл нь хүүхдийн оролцоог дэмжихэд бэлэн, хүүхдийн оролцооны талаар мэдлэгтэй боловч хүүхэд өөрийн зан төлөв, хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан төдийлөн гэр бүлдээ өөрийн санал бодлыг илэрхийлдэггүй, хаалттай байх бөгөөд энэ нь тэднийг гэр бүлдээ оролцох оролцоо муу гэж дүгнэгдэхэд хүргэж байна. Гэвч дийлэнхи тохиолдолд хүүхдийг өөрийн санал бодлоо илэрхийлэх, хамтран зөвлөлдөж, гэр бүлийн шийдвэрт оролцоход саад болдог зүйл нь гэр бүлийнх нь хаалттай байдал буюу гэр бүл бол хүүхдийг зөвхөн удирдах, чиглүүлэх үүрэгтэй, хүүхэд зөвхөн сонсох ёстой гэсэн хандлага юм.


### Шигтгээ 4

*Гэр бүлийхэндээ хандахаар тийм ч нээлттэй хүлээж авдаггүй. Хааяа асуудал гараад эцэг эх мэдлээ гэхэд өөдөөс тайлбар тавилаа гэх зэргээр хаалттай хүлээж авдаг. Ер нь томчуудын зүгээс их хаалттай байдаг л даа. Хүүхдүүд бол өөрсдөө мэдээж өөрийнхөө санал бодлоо хэлэх хүслээр дүүрэн байдаг байх.  
2012.11.07 /12-15 насны сурагчид.f4, Сонгино хайрхан дүүрэг/*

Хүүхэд өөрөө саналаа илэрхийлж, гэр бүлийнхэнтэйгээ зөвшилцөхийг хүссэн ч гэр бүлийнхэн нь сонсдоггүй, үл хайхардаг орчинд хүүхэд оролцох боломжгүй болж байна.

Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 76.5 хувийг жирийн хүүхдүүд буюу өөрсдийн насан дээр сургуульд сурч буй хүүхдүүд бүрдүүлж байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй, сургууль завсардсан, хөдөлмөр эрхэлдэг, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн болон бүртгэлгүй хүүхэд гэх мэт зорилтот бүлгийн хүүхдүүд 23.5 хувийг эзэлж байгаа. Зорилтот бүлгийн хүүхдүүдийн гэр бүлийн түвшин дэх оролцоо ямар байгааг тодруулъя.

### Дүрс 19 Зорилтот бүлгийн хүүхдүүдийн гэр бүлийн оролцооны түвшин



Дээрх зургаас харахад гэр бүлдээ хамгийн бага оролцоотой нь бүртгэлгүй хүүхэд буюу хотод албан ёсны хаяггүй, хөдөө орон нутгийн бүртгэлтэй эсвэл бүр хаяггүй хүүхдүүд байна. Эдгээр хүүхдүүд бол эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдийнхээ бүртгэлийг хийлгэх боломжгүйгээс, хийлгэсэн ч байнгын тогтмол нэг хаяг дээрээ байхгүй зэргээс шалтгаалан албан ёсны засаг захиргааны нэгжид хамрагдаж чадахгүй байгаа гэр бүлийн хүүхдүүд юм. Бүртгэлгүй 3 хүүхэд тутмын 2 нь гэр бүлийн тодорхой шийдвэр гаргалтад оролцох, өөрт тулгарч буй асуудлыг илэрхийлэх, гэр бүлийхэнтэй хамтран зөвшилцөх боломж хамгийн бага буюу байхгүй байна.

Харин дээрх зорилтот бүлгийн хүүхдүүдээс хараа хяналтгүй хүүхдүүдийн гэр бүлийн түвшин дэх оролцоо бусад бүлэгтэй харьцуулахад арай дээр байна. Энэ нь хараа хяналтгүй хүүхдүүдийн гэр бүлийн онцлогтой холбоотой. Эцэг эх нь хүүхдэдээ төдийлөн анхаарал тавьж халамжилдаггүй тул хүүхдүүд ихэвчлэн бие даан орлого олж, зарим тохиолдолд гадуур ажил эрхэлж олсон мөнгөө дүү нар, өвчтэй ар гэрийнхэндээ зориулж хоол хүнс авах гэх мэт эцэг эх, асран хамгаалагчийн үүргийг давхар гүйцэтгэн, гэр бүлийн хүрэн дэх төлөвлөлт, төсөвлөлтийн талаарх шийдвэрийг бие даан гаргах тохиолдол байдаг. Гэвч энэ нь гэр бүлийн түвшинд хүүхдийн оролцоо их байгаа гэсэн үг биш, харин хүүхдүүд эцэг эхийн хайр халамжинд бус, өөрөө бие даан амь зуухаас аргагүй нөхцөл байдалд байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан сургуулийн сурагчид болон зорилтот бүлгийн хүүхдүүдийн гэр бүлийн оролцооны түвшинг харьцуулахад сургуулийн сурагчдын олонхи буюу 45.3 хувь нь “оролцоо дунд” гэж үзэж байгаа бол зорилтот бүлгийн олонхи буюу 48.5 хувь нь “оролцоо муу” буюу гэр бүл хүүхдийн санал бодлыг сонсохгүй түвшинд хүүхдүүд амьдарч байна. Зорилтот бүлгийн 2 хүүхэд тутмын 1 нь хүүхэд оролцох боломжгүй гэр бүлд амьдарч байгаа нь анхаарал татахуйц үр дүн юм. Үүнийг хүүхэд гэр бүлтэйгээ холбоо харилцаа сул, эцэг эхийн зүгээс хүүхдэдээ үзүүлэх халамж бага байдагтай холбон тайлбарлаж болно.

Гэр бүлд хүүхэд өөрөө нээлттэй оролцох эсэх нь гэр бүлийн хандлага, дотоод харилцаа, уламжлалт соёлоос шалтгаалах бөгөөд хүүхэд гэр бүлд нь сонсож, дэмждэг хүн байгаа тохиолдолд өөрийгөө илүү нээлттэй илэрхийлэх боломжтой болж, үүнээс шалтгаалан цаашид хүүхэд гэр бүлийн гишүүдтэйгээ зөвлөлдөж, шийдвэр гаргах, улмаар сургууль, хорооны түвшинд мөн адил оролцох боломж, идэвхтэй болдог. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдээс гэр бүлийн түвшинд хамгийн ойр байж, санал бодлыг сонсдог, дэмждэг хүн хэн байгааг тодруулахад дийлэнх нь эцэг, эхээ нэрлэжээ.

**Дүрс 20 Гэр бүл дэх хүүхдийн оролцоог дэмждэг субъект**



Үүнээс харахад хүүхдүүдийн хувьд эцэг эхчүүд нь хамгийн ойр дотно буюу зөвлөж, тусалж, дэмждэг, санал бодлыг нь сонсдог ажээ. Тодорхой асуудал тулгарвал хүүхдүүд дэмжиж тусалдаг хүндээ хандаж, тэд нь цааш гэр бүлд хүүхдийн санал бодлыг илэрхийлж, дэмжих гүүр болдог.

### **3.2 Гэр бүл дэх хүүхдийн оролцоонд тулгардаг бэрхшээл**

#### **3.2.1 Тулгардаг бэрхшээл**

Гэр бүлийн түвшинд хүүхэд хамааралтай тодорхой асуудалд хүүхэд санал бодлоо илэрхийлэх, зөвлөлдөх, хамтран шийдвэр гаргахад тулгарч буй бэрхшээл нь гэр бүлийнхэн, асран хамгаалагчид, хүүхэдтэй шууд хамааралтай. Гэр бүл, сургууль, хорооны аль аль түвшинд хүүхдийн оролцоог сайжруулахад дараах хүчин зүйлс нөлөөлж байна.

#### **1. Монголын нийгэм тогтсон хандлагатай холбоотой хүчин зүйл**

Хүүхэд том хүний яриан дундуур орж болохгүй, томчуудыг хүндэлж үгийг нь дагах хэрэгтэй гэсэн тогтсон хандлагаас шалтгаалан хүүхдүүд гэр бүлийн асуудалд оролцож санал бодлоо илэрхийлэх, зөвшилцөх, хамтран шийдвэр гаргахад бага оролцож байна.

## Шигтгээ 5

*Хүүхдүүд өөрсдөө их хаалттай мэт санагдаж байна. Энэ байдлыг засахын тулд томчууд бид өөрсдөө хүүхдүүдтэйгээ нээлттэй харилцаж, тэднийг илүү нээлттэй болгож өгөх нь зөв байх.*

*2012.11.07 /Эцэг эхийн төлөөлөл. р 15. Чингэлтэй дүүрэг /*

Гэр бүлийнхэн хүүхдийн дуу хоолойг сонсохгүй байгаа дээрх тогтсон хандлага нь гэр бүл дэх хүүхдийн шийдвэрийг гэр бүл өмнөөс нь гаргах, хүүхэд зөвхөн гэр бүлийнхний шийдвэрийг дагагч болж хувирахад хүргэж байна.

### *2. Олон нийт, гэр бүлтэй холбоотой хүчин зүйл*

Гэр бүлийнхэн нь хүүхдийг шийдвэр гаргах, оролцох чадваргүй гэж үзэх хандлага хүүхдийг өөрийн санал бодлоо илэрхийлэхэд нь саад болдог. Нэг талаас, гэр бүлийн хандлага хүүхдийг хаалттай болгоход нөлөөлж байгаа боловч эцэг эхчүүдийн өгсөн ярилцлагаас үзэхэд, хүүхдийн өөрийн оролцох идэвх болон хүүхдийн оролцох эрхийнхээ талаар мэдлэггүй байдал хүүхдийн гэр бүлийн түвшинд оролцох оролцоог сулруулах нэг хүчин зүйл болж байна.

Сүүлийн үед залуу гэр бүлүүд хүүхдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох гэх мэт бүхий л хэрэгцээг нь хангаж өгч чадаж байгаа ч ажил эрхэлдэг эцэг эхчүүд хүүхэдтэйгээ ярилцах, зөвлөлдөх цаг бага гаргадгаас хүүхдүүд гэр бүлийн түвшинд тодорхой шийдвэр гаргалтуудад оролцох боломжийг бууруулж байна.

## Шигтгээ 6

*Гэр бүлд оролцоход тулгарч буй бэрхшээл юу вэ?*

- *Аав, ээж завгүй. Долоо хоногт заримдаа 2 цаг л зав гаргаж чадах байх.*
- *Цаг завгүй, стресстэй*
- *Алдаа гаргахаар сонсолгүй шууд загнадаг*

*2012.11.07 /16-18 насны сурагчид. f2, Сонгино хайрхан дүүрэг/*

Гэр бүлийнхэн нь хүүхдэдээ тавих анхаарал бага байгаа тохиолдолд хүүхдийн эрх ашигт хамаарал бүхий шийдвэрийг гэр бүлийнхэн бие даан гаргах бөгөөд энэ нь хүүхдийн гэр бүл дэх шийдвэр гаргалтад оролцох, хамтран зөвлөлдөх боломжийг нь хаадаг.

## Шигтгээ 7

*Гэр бүлд хүүхдийн оролцоо тодорхой хэмжээгээр байдаг. Харин хамрах хүрээ нь томрох тусам хүүхдийн оролцох оролцоо нь багасдаг юм шиг санагддаг. Гэр бүлд хүүхдийн оролцоо их байхад, сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоо бага байдаг бол хорооны түвшин дэх хүүхдийн оролцоо бараг байхгүй болдог.*


*2012.11.06 /Эцэг эхийн төлөөлөл. р 12. Чингэлтэй дүүрэг /*

### *3. Хүүхдийн оролцооны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс*



Хүүхдийн хамгийн анхдагч орчин болох гэр бүлд хүүхдийн оролцоог хангахад хүүхдийн оролцооны талаарх мэдлэг, хүүхдийг оролцуулах арга хэлбэр, хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагуудын талаарх мэдлэг, ойлголт хамгийн чухал. Гэр бүлийнхнээс нь хүүхдэд тулгарч болох асуудлыг шийдвэрлэх, хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах, дэмжих чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаарх мэдээлэлтэй эсэхийг тодруулсан юм.

**Дүрс 21 Хүүхдийн байгууллагын талаарх эцэг эхийн мэдлэг**



Дээрх үзүүлэлтээс харахад эцэг эхчүүдийн олонх нь 55 хувь нь хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагыг мэдэхгүй гэж хариулсан бол 32 хувь нь хүүхдийг дэмждэг, оролцуулдаг гол байгууллага гэж нэрлэсэн, 9 хувь нь хүүхдийн эрхийг хамгаалдаг, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагыг нэрлэсэн байгаа бол 4 хувь нь төрийн байгууллагыг нэрлэжээ. Үүнээс дүгнэхэд эцэг эхчүүд хүүхдэдээ асуудал тулгарсан тохиолдолд хандах байгууллага, хүүхдээ хамгаалах, хөгжүүлэх талын мэдлэг мэдээлэл дутагдаж байгаа нь харагдаж байна. Эцэг эхчүүдийн гуравны нэг нь сургуулийг хүүхдийн оролцооны байгууллага гэж үзжээ. Тиймээс эцэг эхэд хүрч ажиллахын тулд сургуулиар дамжуулах нь илүү оновчтой, хүртээмжтэй байж болох юм. Эндээс үзвэл, хүүхдийн оролцоонд тулгарч буй асуудал нь дан ганц хүүхдээс бус түүний хүрээлэл болох гэр бүл, олон нийтийн мэдлэг мэдээлэл, хандлага, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамааралтай болох нь харагдаж байна.

### **3.3 Гэр бүл дэх хүүхдийн оролцоог сайжруулах арга зам**

Судалгаанд оролцсон хүүхдүүдээс гэр бүл нь хүүхдийг оролцуулах түвшинд ямар байхыг хүсч байгааг тодруулахад дараах үр дүн гарсан юм.

## Дүрс 22 Хүүхдийн гэр бүл дэх оролцоог сайжруулах арга зам /Хүүхдүүдийн тодорхойлсноор/



Хүүхдийн хүсэл гэдэг бол одоо байгаагаас ахисан хэрэгцээ байдаг. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн нэлээд хувь нь гэр бүлд нь оролцоо бага байгаа учраас оролцооны хамгийн эхний хэлбэр буюу өөрсдийг нь ядаж хүлээцтэй сонсдог байгаасай гэж хариулсан байгаа нь анхаарал татахуйц байна.

### Шигтгээ 8

*Хүүхдүүд томчуудаас нэлээн хөндий байдаг. Асуудлаа эцэг эхээс өөр том хүнтэй хуваалцана, өөрийн үзэл бодлоо илэрхийлнэ гэхээр тодорхой айдастай байнга тулгарч байдаг. Ийм болохоор энэ чиглэлээр илүү сургалт зохион байгуулах шаардлагатай. 2012.11.07 /19-21 насны сурагчид. 16, Сонгино хайрхан дүүрэг/*

Хүүхэд гэр бүлдээ сайн оролцоотой, санал бодлоо идэвхтэй солилцож байгаа тохиолдолд энэ нь хамгийн чухал суурь болох бөгөөд дараагийн шат болох орон нутгийн түвшинд хүүхэд оролцох сэдлийг төрүүлэх юм.

### Шигтгээ 9

*Насанд хүрээгүй учраас хүүхдүүд юу мэдэх вэ? гэж бодоод тэдний өмнөөс ихээхэн төлөвлөдөг юм шиг байгаа юм. Энэ хандлагаа өөрчлөн хүүхдүүдийг бага гэлтгүй санал бодлыг нь сонсож сурах нь зөв. Сургууль, хорооноос хүүхэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулж, тэдний санал бодлыг сонсох ажил өрнүүлбэл эцэг эхчүүд бүх талаар тусалж дэмжих байх. 2012.11.06 /Эцэг эхийн төлөөлөл. р 12. Чингэлтэй дүүрэг /*

Хүүхэд орон нутгийн шийдвэр гаргалтад оролцоход тулгарч буй бэрхшээлийг эцэг эхчүүдийн 42.9 хувь нь хүүхдийн оролцоог дэмжих бүтэц, зохион байгуулалт сул байгаатай холбож дүгнэсэн байна.

Дүрс 23 Хүүхдийн оролцоонд тулгарч буй бэрхшээл /Эцэг эхийн тодорхойлсноор/



Харин хүүхдийн хувьд эцэг эхийн зүгээс тэднийг оролцуулахад тулгарч буй асуудлыг дээрх байдлаар ангилж тодрхойлсон бөгөөд нийт эцэг эхчүүдийн зүгээс хүүхдийн оролцоог орон нутгийн шийдвэр гаргалтад оролцуулах арга замыг нь өөрсдийн хувьд тодорхойлуулсан бөгөөд энэ нь тулгарч буй бэрхшээлд суурилан түүнийг сайжруулах арга замууд болно. Иймд хүүхдийн оролцоог орон нутгийн түвшинд нэмэгдүүлэхийн тулд дээрх бэрхшээлүүдийг л арилгах хэрэгтэй.

Дүрс 24 Хүүхдийн оролцоог сайжруулах арга зам



Нийт судалгаанд хамрагдсан эцэг эхийн олонхи буюу 42.9 хувь нь хүүхдийн оролцоог дэмжих бүтэц зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай буюу хүүхдийн оролцооны чиглэлд дуу хоолойг сонсох арга механизм бүхий үйл ажиллагаа явуулж буй байгууллагыг дэмжих, урамшуулах тогтолцоог бий болгох нь нэн түрүүнд шаардлагатай гэж үзсэн байна.

Гэр бүлийн түвшинд хүүхдийг оролцуулахаас гадна хүүхэд өөрийн эрх ашигт хамаарал бүхий тодорхой асуудлуудад байр сууриа илэрхийлж, зөвшилцөж, хамтран шийдвэрээ гаргахыг нь дэмжихүйц нээлттэй, тодорхой бүтцийг бий болгох нь хамгийн чухал зүйл бөгөөд харин олон нийт, гэр бүлийн дунд хүүхдийн оролцооны талаар мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтийн дунд тогтсон хуучинсаг хандлагыг өөрчлөх, хүүхдүүдэд өөрсдөд нь орон нутгийн шийдвэр гаргалтад хэрхэн оролцох, ямар ач холбогдолтой, ямар арга замаар оролцох боломжтой гэх мэт мэдээллийг хүүхдэд танин мэдүүлж, ухуулга нөөлөөллийн ажил хийх нь орон нутгийн шийдвэр гаргалт дахь хүүхдийн оролцооны өнөөгийн байдлыг сайжруулах, оролцооны шатлалыг ахиулахад чухал юм.

## БҮЛЭГ 4. СУРГУУЛЬ ДАХЬ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 4.1. Хүүхдийн оролцооны түвшин

Сургууль бол хүүхдийг нийгэмшүүлэх, хөгжүүлэх, сургах зорилго бүхий боловсролын байгууллага бөгөөд хүүхдүүдийн хувьд гэр бүлийн дараах хоёр дахь чухал орчин юм. Тиймээс хүүхдийн оролцоо сургуулийн түвшинд өндөр байх шаардлагатай бөгөөд сургуулийн удирдлагын зүгээс ч гэсэн хүүхдийг оролцох эрхээр нь хангаж ажиллахыг эрмэлзэх ёстой.


Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сургуулийн түвшин дэх оролцоог тодорхойлохын тулд Рожер Хартын онолын дагуу сургууль дахь оролцооны түвшинг тодорхой бодомжуудаар дамжуулан үнэлсэн бөгөөд энэхүү үнэлгээгээр 51.7 хувь нь оролцоо муу, 35.8 хувь нь оролцоо дунд зэрэг, 12.6 хувь нь оролцоо сайн байгаа нь тогтоогджээ.

Дүрс 25 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоо



Судалгаанд хамрагдсан хүүхдийг 8-11 нас болон 12-18 насны гэж бүлэглэсэн бөгөөд насны онцлогоос харахад бага ангийн буюу 8-11 насныхны оролцоо муу байгаа бол, дунд болон ахлах ангийнхан буюу 12-18 насныхны оролцоо харьцангуй сайн байгаа нь харагдаж байна.

Дүрс 26 Сургууль дахь хүүхдийн оролцооны түвшин / насны ангиллаар /




Хүүхдийг сургуулийн түвшинд ямар шатанд оролцож байгааг тодорхойлохын тулд оролцооны шат болгонд тохирсон бодомжуудаар дамжуулан үнэлсэн бөгөөд “оролцоо муу” гэж үнэлэгдсэн хүүхдийн хувьд сургуулийн түвшинд ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагддаггүй, “сонсогч”-ийн байр сууринаас оролцдог, саналыг нь асуудаг боловч хайхардаггүй гэх мэт хэлбэрийг багтаасан бөгөөд энэ хэсгийнхэн сургуулийн түвшинд олонхийг эзэлж байгаа нь анхаарал татахуйц харагдаж байна. Ялангуяа 8-11 насныхны хувьд оролцоо бүр бага байна.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 35.8 хувь нь сургуулийн түвшинд “оролцоо нь дунд” хүүхдүүд бөгөөд оролцооны талаар тодорхой ойлголттой. Тэд сургуулийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцдог ч тэдний саналыг шийдвэрт хэрхэн тусгаж байгаа нь тодорхой бус үлддэг ажээ. Дунд болон ахлах ангийнхны оролцоо бага насны бүлгээ бодвол харьцангуй их байна.

Сургуулийн үйл ажиллагааны гол зорилтот бүлэг нь сурагчид байдаг тул үйл ажиллагаа бүр нь хүүхдийн сайн сайхны төлөө хэрэгжиж байдаг. Тиймээс сургуульд хүүхдийн оролцоо хамгийн чухал түлхэгч хүчин зүйл байх ёстой бөгөөд тиймээс ч бид сургуулийн түвшин, түүн дотроо төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилтийн хяналтад хүүхдийн оролцоо байгаа эсэхийг тодруулах нь хамгийн чухал ажил болох юм. Үүний тулд сургуулийн удирдлагаас мэдээлэл авсан.

Дүрс 27 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоо / сургуулийн удирдлагын тодорхойлсоноор /



Сургуулийн удирдлагын төлөөллөөс авсан ярилцлагаас үзвэл үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийг оролцуулж байгаа гэж дийлэнх нь хариулжээ. Харин сургуулийн үйл ажиллагааны төсөвлөлтөд хүүхдийг оролцуулдаг гэж 27,3 хувь нь үзжээ.

Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцооны нөхцөл байдлыг зураглахын тулд хүүхдүүд сурч буй сургуулийнхаа ямар үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллаж байгааг тодруулж, судалгаанд хамрагдсан сургуулиудын үйл ажиллагааны төлөвлөгөөнд баримт бичгийн судалгаа хийсэн юм.

Сургуулиуд ажиллагааны төлөвлөгөөний үндсэн зориултуудаа хүүхдийн эрх ашгийг хангахад чиглэсэн ажлыг тусгасан байв. Гэвч сургуулиудын хувьд төлөвлөгөө боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар албан журам, зүйл заалт байхгүй байсан бөгөөд энэ нь сургуулийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах албан ёсны бүтэц зохион байгуулалт байхгүй байгаатай холбоотой. Сурагчдыг оролцуулах үйл явц нь тэдний санал хүсэлтийн хайрцгаар ирүүлсэн санал болон багш нараар дамжуулан хүргэсэн санал гэх мэт албан бус хэлбэрээр төлөвлөгөөнд тусгагддаг.

**Шигтгээ 10**

*Манай сургууль 14 хоногоор үйл ажиллагаагаа төлөвлөдөг. Төлөвлөгөөт ажлын нэг хэсэгт “Хүүхэд хөгжил” гэсэн хэсэг заавал байдаг. Тэр хэсэгтээ л хүүхэдтэй холбоотой бүх ажлуудаа төлөвлөж ажилладаг даа...*

*...Мөн хүүхдүүдийн өөрсдийнх нь хүсэл сонирхол дээр тулгуурлан аливаа арга хэмжээг зохион байгуулдаг. 3 хайрцгаар санал асуулга өрнүүлдэг. Тэр 3 хайрцгийн түлхүүр зөвхөн захиралд байдаг. Тэндээс гарсан асуудлыг захирал шийддэг.*

*2012.11.08 / Сургуулийн захирлын төлөөлөл. s1. Налайх дүүрэг /*

Судалгаанд хамрагдсан нийт сургуулиудын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын 45.3 хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлууд буюу хүүхдийн оролцох эрхтэй холбоотой, сургуулийн тохижилт засварын үйлчилгээ болон хүүхдийн хамгаалал, халамж дэмжлэгтэй холбоотой ажлууд багтаж байна. Харин 11.8 хувь нь хүүхдийн оролцооны ажлууд буюу

сурагчдын зөвлөгөөн, хурал, хэлэлцүүлэг, өдөрлөг болон сурагчдын өөрийн удирдлагын байгууллагыг дэмжиж байна.

Үүнээс харахад хүүхдийн оролцоог дэмжих ажлууд тодорхой хэмжээнд төлөвлөгдөж, хэрэгжих боломж байна. Тиймээс ч сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд сурагчдын саналыг асууж, хүүхэдтэй хамтран зөвлөлддөг, зарим тохиолдолд хамтран шийдвэр гаргаж байгаа үйл ажиллагаа бусад арга хэмжээнээс өндөр үзүүлэлттэй байгаа юм.

#### Шигтгээ 11

*Бид сурагчдынхаа дунд “Дэгдээхий” хайрцгийг аялуулан цугларсан санал бодолд нь тулгуурлан төлөвлөгөө гаргадаг. Мөн дарга нараараа дамжуулан анги хамт олны саналыг авдаг. Ингэж ирсэн санал нь төлөвлөгөө болоод, төсөв нь батлагдаад ажил хэрэг болдог. Эргээд ч хяналт болдог. Жишээ нь: ямар нэгэн нөхцөл байдлаас болоод нэг ангийн хүүхдүүдийн санал бодол ажил хэрэг болоогүй байна гэж бодоход ангийн дарга нараар дамжин, аль эсвэл хайрцгаар дамжин дахин санал болон орж ирдэг. Хүүхдүүд их хяналттай байдаг. Тэрний санаачилсан ажил хийгдчихээд яагаад миний санаачилсан ажил хийгдэхгүй байгаа юм бол гээд л асуугаад ороод ирдэг. Тийм учраас бид аль болох тэр асуудлыг шийдвэрлэхийг зорьдог.*  
*2012.11.06 / Сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл. s8. Чингэлтэй дүүрэг /*

Үүнээс харахад сурагчдад сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд оролцох боломж илүү их байна.

Сургуулийн төсөвлөлт дэх хүүхдийн оролцоог тодруулахын тулд хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа хэрхэн төсөвлөгддөгийг авч үзье.

Баримт бичгийн судалгаанаас харахад сургуулийн түвшинд хүүхдийн оролцоог хангахад тулгарч буй бас нэг бэрхшээл нь сурагчдад зарцуулах, тэднийг хөгжүүлэхэд чиглэгдсэн төсөвлөлтийн асуудал юм. Улсын сургуулиудын хувьд тэдэнд төсөвлөдөг зардалд хүүхдэд чиглэсэн хүүхдийг хөгжүүлэх, оролцуулах гэх мэт хүүхдэд зориулсан үйл ажиллагааны зардлыг төлөвлөөгүй нь харагдаж байв.

Төсөвлөсөн зардлын задаргаанаас харахад зөвхөн хүүхэдтэй холбоотой зардлууд болох ном хэвлэл авах, үдийн цай, биеийн тамир, уралдаан тэмцээн, шагнал урамшууллын гэх мэт зардлууд гардаг ажээ Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд нийт төсөвлөсөн зардлын 7.24 хувь нь хүүхэдтэй холбоотой байж болох дээрх зардлуудын журмаар зарцуулагддаг байна.

Нийт сургуулиуд сургуулийн төсөвлөлтийг батлахдаа хүүхдийг оролцуулсан талаарх заалт байгаа эсэхийг судлахад судалгаанд хамрагдсан сургуулийн 33 хувь нь хүүхдийг төсөвлөлтийн үйл явцад оролцуулаагүй, үлдсэн 67 хувь нь хүүхдийг оролцуулсан эсэх талаарх тодорхой заалт байхгүй буюу тодорхойгүй байна.

#### Шигтгээ 12

*Сургуулийн түвшинд төсөв санхүүжилт дээр хүүхэд оролцох боломжгүй. Бид хаалттайгаар хэлэлцдэг. Одоогоор хүүхдийг оролцуулах боломжгүй байна. Цаашдаа оролцуулдаг болно гэж бодож байна.*  
*2012.11.08 / Сургуулийн захирлын төлөөлөл. s4. Налайх дүүрэг /*




Дээрх судалгаанаас харахад сургууль бүрийн онцлогоос хамаарч олонх сургуулиуд хаалттай хэлэлцэж төсвөө батладаг. Тиймээс ч төсвийн төлөвлөгөөнд сурагчид оролцох боломж нь хаалттай болж үлддэг бөгөөд энэ талаар ч сурагчид төдийлөн мэддэггүй, мэдсэн ч сургууль дээр оролцуулах боломж, зохион байгуулалт бүрдээгүй байгаа юм.

#### 4.2 Сургууль дах хүүхдийн оролцооны арга хэлбэр

Хүүхдүүдийн хувьд сургуулийн үйл ажиллагаанд оролцох, ялангуяа тэмцээн уралдаан гэх мэт үйл ажиллагаанд оролцож байгаа нь оролцооны хэлбэр боловч сурагчид сургуулийн түвшинд өөрсдийн санал бодлоо илэрхийлэн, сургуулийн багш нартай санал солилцох, зөвлөлдөх, хамтран шийдвэр гаргах гэх мэт үйл явцад хүүхэд ямар хэлбэрээр оролцож байгааг тодруулан харъя.

Дүрс 28 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцооны түвшин




Сургуулийн түвшинд сургуулийн удирдлага болон ажиллагсдын зүгээс сурагчдын санал бодлыг сонсох, тэдэнтэй шууд бус хэлбэрээр биш ч нийт сурагчдын санал бодлыг бүгдийг сонсохын тулд хэрэглэдэг аргаас хамгийн түгээмэл нь сурагчдын өөрөө удирдах байгууллагаар дамжуулан оролцуулах арга бөгөөд нийт сургуулиудын 52.9 хувь нь энэ аргаар дамжуулан сурагчдыг оролцуулж байна гэж үзсэн. Мөн сурагчдаа оролцуулж байгаа нэг хэлбэр нь санал хүсэлтийн хайрцгаар дамжуулан сурагчдыг оролцуулах арга бөгөөд нийт сургуулийн оролцооны арга хэлбэрийн 32.3 хувийг энэхүү арга эзэлнэ.

Санал хүсэлтийн хайрцаг нь хүүхэд зөвхөн санал хүсэлтээ илэрхийлэх арга бөгөөд ямар хариу арга хэмжээ явагдаж байгаа нь тухайн хүүхдэд үл харагдах байдалтай буюу зөвлөлдөх, хамтран ярилцаж шийдвэр гаргах гэх мэт боломжийг олгодоггүй сул талтай. Гэхдээ санал хүсэлтийн хайрцагт хүүхэд өөрөө асуудлаа тодорхойлж, түүнийгээ илэрхийлж санал хүсэлт илгээх нь Рожер Хартын оролцооны 5 дахь шат буюу сургуулийн удирдлагын зүгээс ямар нэгэн үйл ажиллагааг зохион байгуулж, шийдвэрлэдэг ч томчууд хүүхдийн санаа бодлыг нухацтай авч үздэг шат юм. Тиймээс санал хүсэлтийн хайрцагт хүүхэд их хандах тусам хүүхдийн оролцоо, сэдэл их байгаа гэсэн үг юм.

Сургуулийн түвшинд хүүхдийг дэмжин ажилладаг, тодорхой асуудал тулгарвал шууд ханддаг, асуудлыг нь шийдэж чадахуйц хамгийн итгэлтэй ажилтнуудыг хүүхдүүдээр тодорхойлуулахад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 24.9 хувь нь сургуулийн удирдлага, 20.4 хувь нь ангийн багш гэж тус тус нэрлэсэн байна.

**Дүрс 29 Сургуулийн орчинд дэмждэг субъект**




Хүүхдүүдийн 10.4 хувь нь сургуулийн түвшинд тулгарсан асуудал, тодорхой саналын тухай эцэг эхдээ хандана гэж хариулсан байгаа нь тухайн хүүхдүүдэд сургууль дээр шууд хандахад санал бодлыг сонсож, тусалж дэмжих хүн байхгүй байгаагаас ингэж хариулсан байж болзошгүй.

### **4.3 Сургууль дахь хүүхдийн оролцоонд тулгардаг бэрхшээл**

Сургуулийн түвшинд хүүхдийн оролцоог хангах, хүүхдийг сонсох, хүүхэдтэй хамт асуудлынх нь талаар зөвлөлдөх, хамтран шийдвэр гаргах гэх мэт оролцооны бүхий л шатанд тулгарч буй бэрхшээлийг сургуулийн удирдлагын зүгээс тодорхойлуулав. Ингэхэд сургуулийн удирдлагуудын 33 хувь нь бэрхшээл байхгүй гэж хариулсан бөгөөд, харин 22.2 хувь нь хүүхдийн оролцоог дэмжих техник хэрэгсэл, байр, хангамж, нөөц дутмаг байдгийг дурдсан.

### Дүрс 30 Сургуулийн түвшинд хүүхдийн оролцоог хангахад тулгарч буй бэрхшээл



Мөн эцэг эх нь хүүхдээ дэмжиж оролцуулдаггүй, хүүхдийн оролцоог дэмжих бүтэц зохион байгуулалт тодорхой бус, хүүхдүүдийн өөрсдийн идэвх сул мөн төсөв санхүүгийн хүрэлцээ муу гэх мэт асуудлууд нь адил хэмжээгээр хүүхдийн оролцоог хангахад саад учруулж байна гэж тодорхойлсон байна.

#### Шигтгээ 10

- Манай сургуульд хурал хийх, цуглах анги танхим байдаггүй шүү дээ. Тэглээ ч оролцъё гэхээр сайн мэддэггүй.
- Бид нар өөрсдөө бас заримд нь идэвх байдаггүйгээс л ордоггүй байх.
- Бид нар дугуйлан секц гээд л яваад хамаг өдөр дуусчихдаг.
- Оролцъё гэхээр сайн мэддэггүй шүү дээ. Бид нар юу хийх, яагаад чухал гэдгийг мэдэхгүй.

2012.11.07 /16-18 насны сурагчид. f2, Сонгино хайрхан дүүрэг/

Сургуулийн түвшинд хүүхдийн эрх ашигт хамаарал бүхий асуудалд хүүхдийг шат бүрт оролцуулах нь чухал бөгөөд хүүхдийг оролцуулахад тулгарч буй бэрхшээл нь :

Нэгдүгээрт: Сургуулийн орчноос шалтгаалсан хүчин зүйл. Хүүхдийн оролцооны талаарх мэдлэг мэдээлэл сургуулийн ажилчид болон сурагчдад бага учир төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилтийн хяналт дахь оролцоо сул, түүнд оролцох сэдэл бага, айж эмээдэг, ичиж санаа зовдог, оролцох үйл ажиллагаанд зарцуулах цаг зав хомс,

Хоёрдугаарт: Гэр бүлээс шалтгаалсан буюу эцэг эх нь хүүхдийн оролцооны талаарх мэдлэггүй, хүүхдээ оролцуулахыг дэмждэггүй, идэвхтэй бус, хүүхдийн оролцооны болоод хүүхдийг дэмжих байгууллагын талаарх мэдлэг сул, туршлага байхгүй,

Гуравдугаарт: хүүхдийн оролцоог дэмжих, санал бодлыг сонсох хурдан шуурхай зөвлөлдөх, шийдвэрлэх бүтэц зохион байгуулалт, дэмжих субъект тодорхой бус, хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааны төсөвлөлт буюу үйл ажиллагаанд зориулагдах зардал тодорхой бус ба бага, хүүхэд болон гэр бүл дэх оролцооны талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажил хийгдэхгүй байгаа гэх мэт хүүхдийн гэр бүл болон сургуулийн түвшинд тулгардаг асуудлуудыг нэрлэж болох юм.

#### 4.4 Сургуулийн түвшинд хүүхдийн оролцоог сайжруулах арга зам

Сургуулийн түвшинд хүүхдэд тулгарч буй сааж бэрхшээлийг арилгахын тулд цаашид хийх шаардлагатай, сайжруулах арга замыг сургуулийн түвшинд сургуулийн удирдлагууд дараах байдлаар тодорхойлж байна.

Дүрс 31 Сургуулийн түвшин дэх хүүхдийн оролцоог сайжруулах арга зам



Судалгаанд хамрагдсан сургуулиудын 31 хувь нь төр, ТББ болон ОУБ-тай хамтран ажиллах нь хүүхдийн оролцоог бэхжүүлэх цаашид сайжруулахад чухал нөлөөтэй юм гэж үзсэн байна. Мөн хурал, уулзалт, аяны үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хүүхдийн санал бодлыг сонсох, харилцан зөвлөлдөх, хамтран шийдвэрлэх нь хүүхдийн оролцоог сайжруулах арга зам юм. Хүүхдээс авсан фокус ярилцлагаас үзэхэд хүүхдүүд сургуулийн орчинд багш нар болон сургуулийн удирдлага хүүхдүүдийг нээлттэй сонсдог байгаасай гэж хүсдэг бөгөөд, дан ганц тэмцээн уралдаан зохиохоос гадна хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажлуудад хүүхдүүд саналаа хэлэх, хамтдаа зөвлөлдөх, хамтран шийдвэр гаргах зэргээр оролцохыг хүсдэг нь харагдсан.

Тиймээс энэхүү сэдлийг хүүхдийн оролцоо болгохын тулд хүүхдийн оролцоог дэмжих, зохион байгуулж ажиллах тогтсон үүрэг бүхий багш, ажилтныг ажиллуулж, тэдгээрийн чадавхийг хөгжүүлэх, туршлага солилцох гэх мэтээр чадавхижуулах шаардлагатай байгаа юм. Мөн хүүхдийн оролцооны байгууллага, хүүхдийн оролцоонд чиглэсэн арга хэмжээг дэмжин техник хэрэгсэл, тогтмол байрлах өрөө гэх мэт нөөц бололцоогоор хангах, хүүхдийн оролцооны байгууллагууд болон хүүхдийг нээлттэй сонсох, хүүхэдтэй зөвлөлдөх, хамтран шийдвэрлэх гэх мэт арга хэмжээг өргөн хүрээтэй тогтмол арга хэмжээ зохион байгуулах нь чухал байна.

## **БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ЗАСАГЛАЛ ДАХЬ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Судалгаандаа бид засаглалд оролцох гэсэн ойлголтыг үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө, хэрэгжилтэд хяналт тавих гэсэн гурван үйл явцад тулгуурлан ойлгож байна. Хүүхдүүд өөрт хамааралтай асуудлаар засаглалд оролцох нь иргэний нийгмийн тулгуур үндэс гэж хэлж болно.

### ***5.1 Хорооны шийдвэр гаргах түвшин дэх хүүхдийн оролцоо***


Орон нутагт засаглалын түвшинд хүүхэд өөрийн оролцоог бий болгох хамгийн боломжит хувилбар нь өөрийн амьдарч буй засаг захиргааны анхан шатны нэгж<sup>2</sup> болох хороонд өөрийн биеэр очиж санал хүсэлтээ шууд хүргэдэг, хороонд өөрийг нь төлөөлөх төлөөллийг бий болгох, тэдэнд санал бодлоо хүргэдэг тодорхой аргатай байх, эргээд төлөөллөөрөө дамжуулан хянадаг байх гэсэн аргууд байж болох юм. Хорооны түвшинд хүүхдийн оролцоо өнөөдөр ямар байгааг нарийвчлан гаргаж ирэх нь тун чухал асуудал юм.

Хорооны түвшинд хүүхдийн оролцоо бусад түвшинг бодвол муу байгааг хүүхдийн оролцооны түвшин дэд бүлэгт дурдсан билээ. Үүн дотроо хороонд огт оролцдоггүй хэсэг нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 73.3 хувийг эзэлж байгаа нь тун муу үзүүлэлт юм. Энэ нь гэр бүлийн огт оролцдоггүй гэсэн үзүүлэлтээс 60.5 хувиар илүү, харин сургуулийн түвшинд огт оролцдоггүй хэсгээс 51.3 хувиар илүү байгаа нь засаглалд хүүхдийн оролцоо ерөнхийдөө муу байгааг харуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл, хорооны үйл ажиллагаанд огт оролцдоггүй, хандалт хийдэггүй энэ тохиолдолд хүүхдүүд өөрийн санал бодлыг засаглалын хорооны дээд нэгжүүд болох дүүрэг болон нийслэлийн түвшинд бүр ч хүргэдэггүй байж болох талтай. Үүнийг Рожер Хартын оролцооны шатлал болон сайн, дунд, муу гэсэн үзүүлэлтээр харуулбал дараах байдалтай байна.

---

<sup>2</sup> МУ - ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 3.1 болон 3.4 –т зааснаар.

**Дүрс 32: Рожер Хартын шатлалаар болон ерөний үзүүлэлтээр хүүхдийн оролцооны өнөөгийн байдал /12 – 18 насны хүүхдүүд/**



Хорооны үйл ажиллагаанд огт оролцдоггүй гэж 12 – 18 насны хүүхдүүдийн 73.3 хувь нь үзсэн бол “Би асуудлыг өөрөө гаргаж ирж хамтран шийдвэр гаргадаг” гэж ердөө 2 хүүхэд буюу 0.7 хувь нь үзсэн байна.

Хорооны шийдвэр гаргах түвшинд зорилтот бүлгийнхэн огт оролцохгүй байна. Хорооны түвшинд зорилтот бүлгийн 98 хүүхэд хамрагдсанаас 2 хувь нь буюу 2 хүүхэд оролцоо сайн гэж дүгнэсэн байна.

**Хүснэгт 13: Зорилтот бүлгийн хүүхдүүдийн хорооны түвшин дэх оролцоо**

| Зорилтот бүлгийн хороон үйл ажиллагаан дахь оролцоо |      |        | Оролцооны түвшин |              |              | Нийт |
|---|------|--------|------------------|--------------|--------------|------|
|   |      |        | Оролцоо муу      | Оролцоо дунд | Оролцоо сайн |      |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд                         | тоо  | 16     | 0                | 0            | 16           |      |
|   | хувь | 100.0% | .0%              | .0%          | 100.0%       |      |
| Бүртгэлгүй хүүхэд                                   | тоо  | 12     | 1                | 1            | 14           |      |
|   | хувь | 85.7%  | 7.1%             | 7.1%         | 100.0%       |      |

|                          |            |      |        |      |      |        |
|--------------------------|------------|------|--------|------|------|--------|
| Хүчирхийлэлд<br>хүүхэд   | өртсөн     | тоо  | 16     | 0    | 0    | 16     |
|                          |            | хувь | 100.0% | .0%  | .0%  | 100.0% |
| Хөдөлмөр эрхэлдэг хүүхэд |            | тоо  | 17     | 1    | 0    | 18     |
|                          |            | хувь | 94.4%  | 5.6% | .0%  | 100.0% |
| Сургууль<br>хүүхэд       | завсардсан | тоо  | 18     | 0    | 1    | 19     |
|                          |            | хувь | 94.7%  | .0%  | 5.3% | 100.0% |
| Хараа хяналтгүй хүүхэд   |            | тоо  | 15     | 1    | 0    | 16     |
|                          |            | хувь | 93.8%  | 6.3% | .0%  | 100.0% |
| ЕБС                      |            | тоо  | 284    | 23   | 16   | 323    |
|                          |            | хувь | 87.9%  | 7.1% | 5.0% | 100.0% |
| <b>Нийт</b>              |            | тоо  | 378    | 26   | 18   | 422    |
|                          |            | хувь | 89.6%  | 6.2% | 4.3% | 100.0% |

Хүснэгтээс харахад хөгжлийн бэрхшээлтэй болон хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн хувьд оролцоо муу гэж бүгд үзсэн бол бүртгэлгүй хүүхдүүдээс хорооны үйл ажиллагааг сайн гэж үнэлсэн хэсэг байгаа нь энэ бүлгийн хувьд өөр газарт байдаг боловч өөрийн бичиг баримтан дээрх хаягтай газраараа ямар нэгэн байдлаар үйлчлүүлдэг болохыг харуулж байна. Бусад зорилтот бүлгийн хувьд оролцооны түвшин муу гэж 90–с дээш хувь нь үзсэн байна. Зорилтот бүлгийн хувьд оролцоо бүхий л түвшинд ердийн хүүхдүүдээс доогуур үзүүлэлттэй байна.


#### *5.1.1 Хорооны түвшинд хүүхдийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудлууд*

Хорооны түвшинд хүүхдийн оролцоо муу буюу, огт оролцдоггүй хувь 73.3 хувь байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм. Энэ тохиолдолд хорооны төлөвлөлт, төсөвлөлт болон хэрэгжилтийн хяналтад хүүхдийн оролцоог мэргэжилтнүүд юу гэж ойлгож байгаа болон хүүхдүүдийн зүгээс оролцоход ямар бэрхшээл тулгарч байгааг тодорхойлох нь чухал билээ. Бид нийт 3 дүүргийн, 6 хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, иргэдийн хурлын төлөөлөгчидтэй ганцаарчилсан ярилцлага хийж, хорооны төлөвлөгөө, тайланд дүн шинжилгээ хийж, тухайн орон нутгийн 4 сургуулийн сурагчид, оршин суугчид, зорилтот бүлгийн хүүхдүүдийг фокус судалгаанд хамруулж судлахыг зорьсон.

- 1. Хүүхдүүдэд хорооны түвшинд оролцох мэдлэг болон хорооны үйл ажиллагааны талаарх мэдээлэл дутмаг байна.*

Орчин тойронтой холбоотой асуудал гарахад нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 22.5 хувь нь хорооны ЗДТГазарт хандана гэж хариулсан бол, 19 хувь нь хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ болон ТББ-д хандана гэж хариулсан байна. Мөн хорооны цагдаагийн хэсэгт болон гэрийнхэндээ хандана гэж тус бүр 16 хувь нь хариулсан байна. Эдгээр үзүүлэлтийг дүрсээр харуулбал:

### Дүрс 33: Хүүхдийн санал бодлыг сонсох субъект



Хорооны түвшинд хэрвээ хандахаар бол хэнд хандах талаар тандалт асуулгад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 40.2 хувь нь хороонд хандахгүй, мэдэхгүй гэж хариулсан бол 25.6 хувь нь хорооны засаг даргад хандана гэжээ. Үүний дараагаар хорооны нийгмийн ажилтанд хандана гэж 10.9 хувь нь хариулсан байна. Энэ үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

#### Хүснэгт 14: Хорооны түвшинд хүүхдийн оролцоог дэмжих субъект

| <b>Хороонд хэн чамд дэмжлэг үзүүлнэ гэж бодож байна вэ?</b> |       |
|---|-------|
| Хорооны засаг дарга   | 25.6% |
| Нийгмийн ажилтан  | 10.9% |
| Хорооны зохион байгуулагч                                   | 9.2%  |
| Хороонд хандахгүй, мэдэхгүй                                 | 40.2% |
| Бусад   | 14.1% |

Хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, иргэдийн нийтийн хурлын төлөөлөгч нар хүүхдийн оролцооны талаар ямар үзэл бодолтой байгаа нь хүүхдийн оролцоог бий болгоход чухал билээ. Хорооны түвшинд хүүхдүүд оролцоход өөрсдөө оролцох эрхтэй гэдгээ мэдэхгүй мөн засаг захиргааны байгууллага зөвхөн томчуудад үйлчилдэг газар гэсэн ойлголттой байдаг тухай хорооны засаг дарга нар онцолж байсан юм.

#### Шигтгээ 3

*...Энэ хорооны хөгжилд, хорооны дэвшилд хүүхдийн санаа их чухал байдаг. Гэтэл хүүхэд санаагаа илэрхийлэх гэтэл би хороонд очиж болохгүй гэсэн айдас байдаг...*

*Чингэлтэй дүүрэг. Засаг дарга. Со1*

*...Хүүхдүүд тэр болгон өөрсдийгөө хороонд очиж үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй гэж боддоггүй,*



*хороо гэхээр тэднээс хол хөндий зөвхөн томчууд л очдог, томчуудын асуудал шийддэг газар гэж ойлгодог...*

*Сонгино хайрхан дүүрэг. Засаг дарга. Со7*

Хүүхдүүдийн хувьд насны ангилал ялгаагүйгээр мөн л хороонд ямар үйл ажиллагаа явагддаг, тэдний санал бодлыг хэн сонсох талаар ямар ч мэдээлэлгүй байгаа нь фокус бүлгийн ярилцлагаас харагдаж байсан юм.

#### **Шигтгээ 4**

*...Хороо хог цэвэрлүүлэх, вакцин хийлгэх, саад барих зэрэг ажилд хүүхдүүдийг оролцуулдаг. Мөн хүүхдийн баяраар арга хэмжээ зохион байгуулдаг байх...*

*/Налайх дүүрэг. 16 – 18 нас. 2012.11.07. f2/*

*...Иргэний үнэмлэхээ авах гэж нэг очсон. Тэгээд баахан газар зааж өгөөд л. Нэгэн дээр нь очсон чинь наадах чинь болоогүй байна тийшээ яв гээд л. Ер нь тэгээд л иргэний үнэмлэхээ авдаг газар юм биш үү...*

*/Сонгино хайрхан дүүрэг. 14 – 17 нас. 2012.11.06 f5/*

*...Аав ээж хороонд очиход л хамт явж байсан юм байна. Тэрнээс сайн мэдэхгүй...*


*/Сонгино хайрхан дүүрэг. 13 – 16 нас. 2012.11.06. f4/*

- 2. Хорооны түвшинд хүүхдийг засаглалд оролцуулах хууль эрх зүйн болон журмын зохицуулалт байхгүй байна.*

Хүүхэд хорооны шийдвэр гаргалтад оролцож чадаж байна уу, үйл ажиллагаагаа төлөвлөхдөө тэдний санал бодлыг асуудаг болов уу? Хорооны засаг дарга, иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид болон нийгмийн ажилтануудын ярилцлагаас дараах үр дүн гарсан байна. Тухайлбал, төсөв дээр бид ярих боломжгүй байдаг<sup>3</sup>, дүүргээс төсвийг шийддэг гэж дийлэнх нь хариулсан бол төлөвлөгөөнд зарим нэг байдлаар оролцуулдаг гэж мэргэжилтнүүдийн 29.4 хувь нь, хяналтад ямар нэгэн байдлаар оролцуулдаг гэж 17.6 хувь нь үзсэн байна. Үүнийг доорх дүрсээр харуулбал:

<sup>3</sup> МУ - ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 6. 1 – т зааснаар.

**Дүрс 34: Хүүхдийг хорооны төсөв, төлөвлөгөө, хяналтад оролцуулдаг эсэх /хорооны мэргэжилтэн/**



Хороонд өнөөгийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд албан ёсоор төсөвлөлт байхгүй, төсвийн задаргаа нарийвчлан гаргадаггүй болохыг хорооны мэргэжилтнүүд илэрхийлж байсан. Төлөвлөгөөнд хүүхдийг оролцуулдаг гэж хариулсан хэсэг нь танил болон мэргэжилтэнтэй ойр байдаг хүүхдүүдийн санал бодлыг тусгахыг төлөвлөгөө болон хяналтад оролцуулж байна гэж ойлгож байгаа болохоос биш ямар нэгэн байдлаар хүүхдүүдийн төлөөллийг оролцуулан санал бодлыг төлөвлөгөөндөө тусгасан, хүүхдийн оролцоотой хяналт тавьдаг хороо өнөөдөртөө байхгүй байна.

**Шигтгээ 5**

*...Сургуулийн нийгмийн ажилтан болон хүүхдүүд хааяа хэлж байсан саналуудыг ямар нэгэн байдлаар тусгахыг боддог...*

*Чингэлтэй дүүрэг. Засаг дарга. Со4*

*... Манай ... байранд амьдардаг П гэдэг аавтайгаа амьдардаг охин их хөөрхөн, гэрэлтүүлгийн талаар санаа хэлж байсан. Бид тэр дор нь хийж өгсөн...*

*Сонгино хайрхан дүүрэг. Засаг дарга. Со10*

3. *Хорооны мэргэжилтнүүд хүүхдийн оролцох эрхийн талаар ойлголт дутмаг, ач холбогдлыг ойлгохгүй байна.*

Хорооны мэргэжилтнүүд хүүхдийн оролцох эрхийн талаар ойлголт дутмаг, үнэн зөв ойлголттой мэргэжилтэн тун ховор байгаа нь ярилцлагын явцад ажиглагдаж байв. Хүүхдийг оролцуулах гэдэг ойлголтыг уламжлалт тэмцээн уралдаан, хүүхдийн баярт оролцуулах гэсэн явцуу уламжлалт ойлголтоор хязгаарлаж, хүүхдийн санал бодлыг тусгах, хэрэгжүүлэх талаар ойлголт муу байв.

## Шигтгээ 6

Та орон нутгийн хүүхдийн оролцооны талаар ямар ойлголттой байдаг вэ?  
Хүүхдийг вакцин, тарианд хамруулахаас эхэлнэ. Хороо өрхийн эмнэлэгтэй хамтран хүүхдүүдийг вакцинд хамруулахаар ажиллаж байна. Хүүхдийн оролцоо зохих хэмжээгээр явагдаж байна.

Чингэлтэй. Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгч. Со6

Хорооны зүгээс хүүхдийн оролцооны чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Жишээ нь. Зургийн уралдаан, зохион бичлэгийн уралдаан зарлаж хүүхдийг оролцуулдаг.


Сонгино хайрхан. Нийгмийн ажилтан. Со8

Сургуулийн нийгмийн ажилтантай хамтарч цэвэрлэгээ хийлгэх, цэвэрлэгээ хийж байгаа хүмүүст хүүхдүүд аарц чанаж ирээд хооллож ундалдаг.

Сонгино хайрхан. Засаг дарга. Со10

Хүүхдүүд өөрсдөө хорооны төсөвлөлт, төлөвлөгөө, үйл ажиллагааны шийдвэрт хяналт тавьдаг уу гэсэн асуултад фокус бүлгийн ярилцлагаар доорх байдлаар хариулсан байна.

**Дүрс 35: Хүүхдийг хорооны төсөв, төлөвлөгөө, хяналтад оролцуулдаг эсэх /фокус бүлгийн ярилцлагаас/**



Хорооны төсөв, төлөвлөгөөнд оролцохгүй байгаа шалтгаанаа хүүхдүүд зөвхөн баримт бичиг авдаг, мод тарих үйл ажиллагаа зэргийг зохион байгуулдаг газар гэж ойлгодог тухайгаа фокус бүлгийн ярилцлага дээр дурдаж байсан юм. Тиймээс хорооны үйл ажиллагаа иргэд тэр тусмаа хүүхдүүдээс хол төлөвлөгдөж байна.

## Шигтгээ 7

...Хороо бол 16 нас хүрээд баримт бичиг авдаг газар гэж боддог...

2012.11.06 /14 -17 нас. Сонгино хайрхан дүүрэг. f5/

... Хороонд бага байхдаа оролцож байгаагүй одоо ч идэвхтэй оролцдоггүй...

2012.11.06 /18 – 21 нас. Чингэлтэй дүүрэг. f6/

Хорооны үйл ажиллагаанд тухайн нутаг дэвсгэрт байгаа иргэн бүр оролцох хэрэгтэй гэдгийг засаг дарга нар хэдийгээр ойлгож байсан ч, хүүхдийг иргэн гэж үзэхгүй байгаа нь ярилцлагаас харагдаж байв. Хэдий насанд хүрсэн ч хүүхэд насны туршлагаасаа хуваалцсан 19 – 21 насны иргэд хороо гэдэг ойлголтод мөн л идэвхгүй хандаж байгаа нь кейс судалгааны явцаас харагдаж байсан юм. Тэдний үзэж байгаагаар хороонд хүүхдүүдийг дэмжих болон үзэл бодлыг нь сонсох ямар нэгэн тогтолцоо, мэргэжилтэн байхгүй гэж ихэнх нь хариулсан байна.

## Шигтгээ 8

*Хороонд хүүхдийн төлөө ажиллах хүн байхгүй. Хүнд хүрч ажиллаж чадахгүй байна.*

*Кейс 1. Сонгино хайрхан дүүрэг*

*Хороо, дүүргийн түвшинд оролцох боломж хомс.*

*Кейс 6. Чингэлтэй дүүрэг.*

*Хүүхэд насандаа оролцдоггүй байсан. Яагаад гэвэл насанд хүрээгүй хүний санал бодлыг авч хэлэлцдэггүй.*


*Кейс 12. Налайх дүүрэг*

### 5.1.2 Төлөвлөлт дэх хүүхдийн оролцоо

*Төлөвлөгөө:* Хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, бүхий л үйл ажиллагаандаа хүүхдийн эрхийг хангахыг боддог гэж хариулсан мэргэжилтнүүдийн хувьд тэгж хэлэх үндэслэл нэг талаар байгаа юм. Тухайлбал, хорооны түвшинд гарч байгаа үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд хүүхдийн эрхийг хангах чиглэлд эрүүл мэндийн, боловсролын, тохижилтын зэрэг ажлуудыг тусгадаг. Гэхдээ хүүхэд өөрт хамааралтай асуудлаар санал бодлоо хэнд хандаж илэрхийлэхээ сайн мэдэхгүй байсан. Хорооны түвшинд хийж байгаа хүүхдийн чиглэлдэх үйл ажиллагааг баримт бичгийн судалгаагаар тодруулбал ихэнхдээ сургалт, судалгаа, тохижилт гэсэн ажлууд байгаа юм. Эдгээр ажилд хүүхдийн санал бодлыг тусгасан хороо байхгүй. Гэхдээ дүүрэгтэйгээ хийдэг үр дүнгийн гэрээнд зарим ажил хийхийг тусгасан байна.

Судалгаанд хамрагдсан хороодын 2011, 2012 оны төлөвлөгөөнд тусгасан ажлуудын 10.4 хувийг хүүхдэд хандсан дурьдсан ажил эзэлж байна. Үүнд хүүхдийг үйл ажиллагаанд нь оролцуулах чиглэлээр, хүүхдүүдийн дунд зохион байгуулах тэмцээн уралдаан, тамхины эсрэг аян зэрэг үйл ажиллагааг хамруулан ойлгож байгаа бөгөөд хүүхдийн санал бодлыг сонсох хурал цуглаан, уулзалт биш юм. Эдгээр ажлын 6 хувь нь хүүхдийн тохижилтын ажил буюу сургууль болон цэцэрлэгийн тохижилт байгаа бол 25 хувь нь боловсрол соёлын ажил буюу хүүхдэд чиглэсэн сургалт зохион байгуулах болон судалгааны чиглэлийн ажлыг хамруулан ойлгосон бол төрийн болон ТББ, ОУБайгууллагуудын халамжийн чиглэлд хамрагдсан байна. Эдгээр үзүүлэлтийг дүрсээр харуулбал:

**Дүрс 36: Хорооны төлөвлөгөөнд хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төрлүүд /баримт бичгийн судалгаанаас/**



Нийт 6 хорооны 2011 болон 2012 оны төлөвлөгөөний 7 баримт бичигт хийсэн дүн шинжилгээгээр хорооны төлөвлөгөө дараах байдалтай байна.

**Хүснэгт 15: Хорооны төлөвлөгөөнд хийсэн дүн шинжилгээ**

| № | Төлөвлөгөөний баримт бичгийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд  | Тийм | Үгүй | Тодорхойгүй |
|---|--|------|------|-------------|
| 1 | Байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилтод хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажил төлөвлөгдсөн эсэх;                        | 100% | 0    | 0           |
| 2 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа төлөвлөгдсөн эсэх;                  | 100% | 0    | 0           |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлыг нотолгоонд суурилж төлөвлөсөн эсэх;         | 0    | 0    | 100%        |
| 4 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан эсэх;          | 16%  | 84%  | 0           |
| 5 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэдэн хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа байсан бэ?           | 12%  | 88%  | 0           |
| 6 | Байгууллагын хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны хувь | 14%  | 86%  | 0           |
| 7 | Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх бусад ажлууд  | 86%  | 14%  | 0           |

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан гэх 16 хувь нь Налайх дүүргийн 1 – р хорооны 2012 оны


үйл ажиллагааны төлөвлөгөөнд иргэдээс санал асуулга авах болон явуулын санал хүсэлтийн хайрцаг явуулна зэргээр тусгасан байна.

Зарим хорооны мэргэжилтний хэлж байгаагаар, хэдийгээр ийм механизм байхгүй ч өөрийн хэмжээнд хүүхдийг оролцуулах санаачлага гарган, хорооны нутаг дэвсгэрт байдаг сургуулиудад “Засаг дарга сонсож байна” зэрэг санал хүсэлтийн хайрцаг явуулдаг тухайгаа ярьж байсан нь энэ төрлийн оролцооны хэлбэр бий болж эхэлснийг харуулж байна.

### 5.1.3 Хэрэгжилтийн хяналт дахь хүүхдийн оролцоо

**Тайлан:** Мөн 2011 оны жилийн эцсийн тайланд хийсэн дүн шинжилгээгээр хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаа дараах байдалтай байна. Нийт тайланд тусгагдсан үйл ажиллагааны 15.48 хувь нь хүүхдийн чиглэсэн үйл ажиллагаа байна. Эдгээр хүүхдэд чиглэсэн ажлын 19.25 хувь нь хүүхдийг ямар нэгэн үйл ажиллагаанд оролцуулсан /хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээнд оролцуулах гэх мэт. Налайх дүүрэг 3 – р хороо/ ажил юм.

#### Дүрс 37: Хорооны 2011 оны хорооны үйл ажиллагааны тайланд тусгагдсан хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төрөл/баримт бичгийн судалгаанаас/



Дүрсээс харахад, хорооны хүүхдэд хандсан үйл ажиллагааны ихэнх хувийг хүүхдэд хандсан халамж, хамгааллын үйл ажиллагаа эзэлж байгаа бол сургууль болон цагдаагийн газартай хамтран зохион байгуулдаг аян, сургалт зэрэг үйл ажиллагаа үлдсэн 40 хувийг эзэлж байна.

Эдгээр үзүүлэлтийг 3 дүүргийн 4 хорооны 5 тайланд хийсэн баримт бичгийн дүн шинжилгээгээр харвал дараах байдалтай байна.

#### Хүснэгт 16: Хорооны тайланд хийсэн дүн шинжилгээ

| № | Үйл ажиллагааны биелэлт, тайланг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд | Тийм | Үгүй | Тодорхойгүй |
|---|---|------|------|-------------|
|---|---|------|------|-------------|

|   |  |       |       |     |
|---|--|-------|-------|-----|
| 1 | Байгууллагын үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан эсэх;                              | 0     | 100%  | 0   |
| 2 | Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны биелэлт байсан эсэх;                                   | 40%   | 0     | 60% |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаанд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэгдсэн ажлын хувь | 19.2% | 81.8% | 0   |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны биелэлт байсан эсэх;                          | 40%   | 60%   | 0   |

Бичиг баримтын судалгааны үр дүнд хороо нь үйл ажиллагааг төлөвлөхдөө ямар нотолгоо ашигладаг, иргэдийн санал бодлыг сонсохдоо саналын хайрцаг, явуулын өрөө<sup>4</sup> /иргэдийн саналыг асуух үйл ажиллагаа зохион байгуулсан/, хурал цуглаан зохион байгуулах зэрэгт хүүхэд оролцож байгаа эсэхийг харах боломж байхгүй байна.

Бүх баримт бичигт хийсэн дүн шинжилгээгээр хороо хүүхдийн асуудлаар дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулдаг нь харагдаж байна.

- ЕБСургуулиудад тамхины эсрэг болон мансууруулах бодисын хэрэглээг багасгах зорилготой аян, сургалт зохион байгуулах
- Хорооны нутаг дэвсгэрт байгаа өрхийн эмнэлэг, ЕБС, цэцэрлэгүүдийн тохижилтын ажил, орчны цэвэрлэгээ
- Хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлд төрөөс болон ТББ, ОУБ-аас өгдөг халамж, хүүхдэд олгодог тэтгэмжүүд
- Номын сан бий болгох, шатрын дугуйлан ажиллуулах зэрэг чөлөөт цагаа өнгөрүүлэх газар байгуулах
- Сурагчдаар цагдаагийн газар болон бусад байгууллагаас гаргасан санаачлагаар эргүүл хийлгэх
- Сургууль, цэцэрлэг завсардсан хүүхдийн судалгаа гаргах
- Хараа хяналтгүй<sup>5</sup> хүүхдүүдийн судалгаа гаргах
- Гэмт хэрэгт өртөж болзошгүй хүүхдийн судалгаа гаргах
- Олон улсын хүүхдийн баяраар хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх, бэлэг тараах
- Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлд хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах
- Чөлөөт цагаа өнгөрүүлэх хүүхдийн тоглоомын талбай барих, тохижуулах ажлууд
- Бүх нийтийн мод тарих өдөрт хүүхдүүдийг хамруулах.

<sup>4</sup> Налайх дүүргийн 1 – р хорооны 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 4.7

<sup>5</sup> Чингэлтэй дүүргийн 6 –р хорооны 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 6.7 –д “Тэнэмэл иргэд болон хүүхэд” гэж туссан байна.

## 5.2 Дүүргийн түвшин дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал

Дүүргийн түвшинд хүүхдийн оролцоог хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, улсын хэмжээнд гарч буй дүрэм, журам, тогтоол хөтөлбөрийг доод шатны байгууллагад хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хэрэгжилтийг бүтэц зохион байгуулалтын хувьд уялдаагаар хангах, байгууллага хооронд холбон зуучлах гэх зэрэгт хэрхэн тусгасныг авч үзлээ. Учир нь дүүрэг бол хүүхдийг шууд оролцуулж ажиллахаас илүүтэйгээр хүүхэдтэй ажиллах суурь нөхцөл, мэргэжил арга зүйн зөвлөгөө, бүтэц зохион байгуулалтыг хангах тал дээр ажилладаг байгууллага юм.

### 5.2.1 Төлөвлөлт дэх хүүхдийн оролцоо

Баримт бичгийн судалгаанаас үзэхэд дүүргийн түвшинд үйл ажиллагааг төлөвлөхдөө хүүхдийн санал бодлыг тусгах, оролцоог хангах талаар дурдсан зүйлс байхгүй байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, дүүрэгт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх үйл ажиллагааны шийдвэр гаргалтад хүүхдийг оролцуулах албан тодорхойлолт, бүтэц зохион байгуулалтын талаар дурдсан баримт бичиг байхгүй байна.

Бид судалгаанд хамрагдсан дүүргийн 2011, 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд агуулгын шинжилгээ хийсэн бөгөөд нийт үйл ажиллагааны ердөө 11.3 хувь нь л хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөхүйц ажил байв. Хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажил гэдэгт бид хүүхдийн оролцоог хангахтай холбоотой, хүүхдийн орчны тохижилт, боловсрол соёлын арга хэмжээ, хүүхэд хамгаалал ба халамжийн асуудлуудыг хамруулж үзсэн болно. Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлын 12.1 хувийг хүүхдийн оролцооны ажлууд буюу зөвлөгөөн, чуулган, хэлэлцүүлэг, өдөрлөг, сурагчдын өөрийн удирдлагын байгууллагыг дэмжих ажлууд эзэлж байна. Мөн уг ажлын 50 хувийг хүүхдийн боловсрол соёлын ажлууд, 21.5 хувийг сургууль, цэцэрлэг, хүүхдийн эмнэлэг гэх мэт хүүхдийн байгууллагын тохижилттой холбоотой ажлууд, 16.3 хувийг хүүхэд хамгаалал ба халамжийн ажлууд эзэлж байна.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад дүүрэг хүүхдийн сургуулийн орчинд буюу тэдний боловсрол соёлын асуудалд түлхүү анхаарч байна. Дүүргийн түвшинд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны баримт бичигт хүүхдэд чиглэсэн арга хэмжээ гэсэн задаргаа байхгүй байгаа нь энэ чиглэлд бодитой ямар ажлууд хийгдэж байгаатай танилцахад хүндрэл бий болгож байгаа бөгөөд дүүргүүдийн гаргаж буй тайлангуудад тодорхой ойлгомжтой задаргаа хийх шаардлагатай байна.

#### Шигтгээ 11

*Сургуулийн зөвлөл болон “Хүүхэд хөгжлийн төв”-өөр дамжуулж л хүүхдийн санаа бодлыг сонсох боломжтой. Мөн дүүргийн Засаг даргын дэргэдэх хүүхдийн зөвлөлөөр дамжуулан сонсдог. Дүүргийн хүүхдийн чуулга уулзалтыг 3 жилд нэг удаа хийдэг бөгөөд уг чуулга уулзалтаар хүүхдийг оролцуулж, санал бодлыг нь сонсдог. Чуулга уулзалтаас гарсан үр дүнг протокол болгож засаг даргад хүлээлгэж өгч гарсан санаанууд дээр үйл ажиллагаа төлөвлөгддөг.*

*2012.11.08 /Хүүхэд залуучууд хариуцсан мэргэжилтэн, Налайх дүүрэг/*



Дүүргийн түвшинд үйл ажиллагааг төлөвлөхдөө дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтод тулгуурлах бөгөөд, харин нийгэм, эдийн засгийн зорилтыг төлөвлөхийн тулд дүүрэг бүрт буй хороо болон сургуулиудаас үйл ажиллагааны төлөвлөгөө, санал зөвлөмжийг авч ажилладаг.

Хүүхдүүдээс авсан санал асуулгын хүрээнд хүүхдийн орчинд асуудал тулгарвал хэнд хандах, хэн тусалж чадна гэж бодож буй г нь асуухад хүүхдүүдийн 13.7 хувь нь дүүргийн ЗДТГ-т хандана гэж хариулжээ. Энэ нь хүүхдүүд дүүргийн түвшинд санал бодлоо илэрхийлэх, зөвлөлдөх гэх мэтээр оролцох сэдэл байгааг харуулж байгаа бөгөөд хүүхдүүдтэй ажиллах давуу тал болно. Тиймээс цаашид энэ сэдэл дээр тулгуурлаж мэдлэгээр хангаж, оролцуулах арга замыг нь чиглүүлэх хэрэгтэй юм.

Бүтцийн хувьд дүүрэг болгонд хүүхэд залуучууд хариуцсан хэлтэс байх бөгөөд уг хэлтэс нь тус дүүрэгт хүүхдэд хандсан үйл ажиллагааг төлөвлөх, төрийн байгууллага, ТББ, ОУБ-ын үйл ажиллагааны уялдааг зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтийг хянах үүрэгтэйгээр оролцож байдаг. Дүүргийн түвшинд хүүхдийг оролцуулдаг идэвхтэй бүтэц дутагдалтай байгаа учраас дүүргийн түвшинд хүүхдийг оролцуулахын тулд оролцооны шат бүрт, хороо болон сургуулийн түвшинд идэвхтэй оролцуулж, санал бодлыг нь дамжуулан, төлөөлүүлэн оролцуулах нь зүйтэй.

#### 5.2.2 Төсөвлөлт дэх хүүхдийн оролцоо

Хүүхдүүд дүүргийн үйл ажиллагааны хүрээнд хүүхдийн эрх ашигт хамаарал бүхий асуудалд оролцож, түүнд зарцуулагдах төсвийг төлөвлөх, тайлагнахад саналаа тусгах нь зүйтэй боловч одоогоор дүүргийн хэмжээнд төсөвлөлтийг батлахад хүүхдийг оролцуулах талаар тодорхой дүрэм журам, зохион байгуулалт байхгүй байгаа нь баримт бичгийн судалгаанаас харагдаж байна. Мөн улсын хэмжээнд мөрддөг “Төсвийн тухай хууль”-ийн 5.1.4-т төсвийн ил тод байдлыг хангасан байх, 6.5.1-д төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх тухай заасан байдаг ч дүүргийн хэмжээнд гаргадаг зардалд хүүхдийн эрх ашигтай холбоо бүхий зардлын задаргаа нь ойлгомжгүй буюу тодорхойгүй байгаа нь энэ төсөвтэй танилцах, нээлттэй ашиглах боломжийг бүрэн хааж байна.

Мөн хүүхдүүдийн хувьд дүүргийн хэмжээнд өөрийн эрх ашигт холбоотой үйл ажиллагааны төсөвлөлтөд оролцох боломж байдгийг мэдэхгүй, хуулийн заалт болон үйл ажиллагааны хүрээнд дүүргийн түвшинд хүүхдийг төсөвлөлтөд оруулах талаар зохион байгуулалт бүтэц байхгүй, хүүхдийн оролцох эрхийн талаар шат шатны шийдвэр гаргагчдад мэдлэг, мэдээлэл байхгүй байна.

*...Дүүргийн төсөвлөлтөд миний бие ч нөлөөлөх, оролцох боломж бараг байдаггүй. Тийм бүтцийн тогтолцоо байхгүй байхад хүүхэд яаж оролцох вэ.*

*2012.11.08 /Боловсролын хэлтсийн мэргэжилтэн, Сонгино хайрхан дүүрэг/*

Судалгааны явцад дүүргийн төсөвлөлтөд хүүхдийг оролцуулах, хүүхдийн санал бодлыг тусгах талаар албан ёсны заалт, мэдэгдэл байхгүй нь батлагдлаа. Тиймээс хүүхдийг шат шатны төсөвлөлт болон түүний шийдвэр гаргалтад оруулахын тулд хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтыг хүүхдүүд, олон нийт, сургууль, хороо, дүүргийн хэмжээнд

сурталчлах, мэдээлэх, хүүхдийг оролцуулах бүтэц, зохион байгуулах, хариуцах эздийг тодорхойлох, тодорхой эрх зүй, дүрэм журмын хүрээнд хүүхдийг оролцуулах зүйл заалтуудыг тодруулах ажлууд хийх шаардлагатай юм.

Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны дийлэнх нь улсын төсөв болон олон улсын байгууллагаас санхүүждэг бөгөөд дүүргүүд улсын төсвөөс нийгэм эдийн засгийн зорилтын дагуу санхүүжилтээ авдаг. Улсын төсвөөс санхүүжилт авч буй өөр нэгэн төрөл нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлыг зохион байгуулахад зарцуулагдах хүүхдийн төлөө сан юм. Хүүхдийн төлөө сан нь хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулинд заасны дагуу 2005 онд Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн дэргэд байгуулагдсан. Уг сан нь байгуулагдсан үеэс эхлэн төсвийн хувьд санхүүжилт дутмаг, тодорхой төлөвлөгдсөн зардлууд нь хасагдаж байсан ч 2009 онд 25.5 сая төгрөг, 2010 онд 221 сая төгрөгийг тус тус хуваарилж авч байсан. Хүүхдийн төлөө сангийн 2010 оны тайлангаас үзэхэд, тухайн сангийн зарцуулалт нь хүүхдийн урлаг, соёл, эрүүл мэнд, халамж үйлчилгээний ажлуудад төлөвлөгдсөн бөгөөд харин хүүхдийн оролцох эрхийг хангахад нөлөөлөхүйц ажил төлөвлөгдөөгүй байгаа юм. Тиймээс хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа нь төрийн байгууллагын хувьд дүүргийн нийгмийн хэлтэс болон Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газраар дамжин санхүүжигдэж байна. Гэхдээ дүүргийн төсвийн задаргаанд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлууд нь хүүхдэд чиглэсэн арга хэмжээний төсөвлөлт гэсэн дэлгэрэнгүй, ойлгомжтой хэлбэрээр байдаггүй.

### 5.2.3 Хэрэгжилтийн хяналт дахь хүүхдийн оролцоо

Дүүргийн түвшинд хүүхдийн эрх ашигт холбоо бүхий ажлуудад хүүхэд өөрөө хяналт тавьж оролцох нь сул байдаг. Учир нь хүүхэд өөрөө төлөвлөлт болон төсөвлөлтийн явцад оролцоо нь бага, оролцох мэдлэг мэдээлэл байхгүйгээс хэрэгжилтийн явцад оролцох боломжгүй байгаа юм. Дан ганц хүүхэд ч бус дүүргийн түвшинд хүүхдийн чиглэлд ажиллаж буй мэргэжилтнүүдийн хувьд ч хүүхдийг оролцуулах талаар тодорхой ойлголтууд байхгүй байгаа юм. Дүүргийн зүгээс хүүхдийн чуулганаар л дамжуулан хүүхдүүдэд үйл ажиллагааг тайлагнах боломж олддог байна.

#### Шигтгээ 9

*...Оны эхэнд сургуулийн оролцооны байгууллагаас санал авдаг. Уулзалт, чуулганаар дамжуулан саналыг авч оролцуулж байна.*

*...Хүүхдийн чуулга уулзалтаар хийгдсэн ажлаа тайлагнах үед хүүхэд саналаа хэлэх бүрэн боломж байдаг.*

*Хүүхэд залуучууд хариуцсан мэргэжилтэн, Налайх дүүрэг*

Дүүрэг болгоны хувьд тайлагнах үйл явц нь өөр өөр байх бөгөөд зарим дүүргийн хувьд зөвхөн албан байгууллагуудад үйл ажиллагаагаа тайлагнадаг нь хүүхдүүд оролцох, санал бодлоо илэрхийлэх, үйл ажиллагааг нь үнэлэх боломжийг хаадаг байна.

#### Шигтгээ 10

*...Зохион байгуулалттайгаар цаг тохирч хүүхэд хөгжлийн төвөөрөө дамжуулан хүүхдүүдээ цуглууж, саналыг нь сонсдог байсан. Ингэхдээ ахлах ангийнхантай уулзах, хөвгүүдтэй, сурагчдын зөвлөлийнхөнтэй гэх мэтчилэн уулзаж байсан. Манайх 2011 оныг “Хүүхэд хөгжлийн жил” болгож бүх байгууллагыг хүүхдийн зөвлөлтэй болгох шаардлага тавьж, хүүхдийн төлөө юу хийж хэрэгжүүлснээр нь ажлыг дүгнэсэн. Манай дүүргийн бүх байгууллага хүүхдийн зөвлөлтэй.  
2012.11.08 /Засаг дарга, Багануур дүүрэг/*

Цөөн тохиолдолд төрийн байгууллагууд өөрсдөө санаачлага гарган хүүхдээр үйл ажиллагаагаа хянуулах, тэдэнд тайлагнах, үнэлүүлэх арга хэмжээг зохион байгуулж байгаа ч энэ нь хүүхдийн хөгжлийн дэмжих жил эсвэл аяны хүрээнд явагддаг учир тогтмолжиж, албан ёсны хэлбэрт шилжиж чадахгүй байна.

#### Шигтгээ 11

*...Дүүрэг, нийслэлийн түвшинд төсөвлөлт, төлөвлөлт, хяналтад хүүхдийн оролцоог хангах боломж байхгүй. Зарим газрууд тийм алхам хийдэг, тухайн сургуулийн захирал удирдлага хүүхдийн асуудлыг ойлгодог байх юм бол тэр ажил болдог. Огт байхгүй биш ч байгаа нь маш хангалтгүй байна. Доороо сайн ойлгосон ч дээд шатны шийдвэр гаргагчид ойлгохгүй байх хэцүү. Орон нутагт ч ялгаагүй. Орон нутагт шуурхай гэж хүүхдүүд хуралддаг ч тэр бүрт хүүхэд ороод асуудал шийднэ гэж байхгүй.  
“Хүүхэд залуучуудын хөдөлгөөн” хариуцсан ажилтан, МУЗН*

Дүүргийн түвшинд үйл ажиллагааг тайлагнах үйл явцад хүүхэд өөрөө аль эсвэл хүүхдийн төлөөллийн байгууллагыг оролцуулж, тэднээр үйл ажиллагаагаа үнэлүүлэх албан ёсны тогтолцоо байхгүй байгаа нь энэ шатанд хүүхдийн оролцоог хангаж чадахгүй байгааг харуулж өгч байна. Хүүхэд буюу хүүхдийн төлөөллийн байгууллагуудад тэдний эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааг хянах, үнэлж дүгнэх тухай тодорхой эрх үүрэг, бүтэц зохион байгуулалт байхгүй байгаа учраас төрийн байгууллагуудын хувьд хэрэгжилтийн хяналт дахь хүүхдийн оролцоо дутмаг байна.

Хэрэгжилтийг хянах шатанд хүүхдийн оролцоо дутмаг буюу зарим дүүргийн хувьд байхгүй байгаа учраас дээрх шинэ ололт дэвшил, оролдлогуудыг дэмжих, тогтворжуулахын тулд төрийн болон төрийн бус байгууллага, санал санаалчлагыг гаргаж буй аж ахуй нэгжүүд хоорондоо хамтран ажиллах, байнгын тогтмолжсон уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж үйл ажиллагаагаа уялдуулах нь чухал юм.


### 5.3. Нийслэлийн түвшин дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал

Нийслэлийн удирдлагын түвшинд хүүхдийн оролцооны байдлыг тодорхойлохын тулд доорх агуулгын хүрээнд мэдээлэл цуглуулсан.

1. Нийслэлийн шийдвэр гаргах түвшний удирдах ажилтан, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтын түвшин
2. Нийслэлийн түвшний үйл ажиллагааны төлөвлөлтөд хүүхдийн оролцооны байдал
3. Нийслэлийн түвшний төсөвлөлт дэх хүүхдийн оролцооны байдал
4. Нийслэлийн түвшний үйл ажиллагааны хэрэгжилтэд хүүхдийн оролцооны байдал зэрэг болно.

Нийслэлийн шийдвэр гаргах байгууллагуудын төлөөллийн ойлголтыг судлахад хоорондоо харилцан адилгүй, ойлголтын зөрүүтэй байв. Энэ түвшинд судалгаанд оролцсон 8 хүний 6 нь нийслэлийн засаг захиргааны байгууллагын төлөөлөл, 2 нь нийслэлийн хүүхдийн асуудал хариуцах чиг үүрэг бүхий байгууллагын төлөөлөл байсан. Эдгээрийн 75 хувь(6) нь засаг захиргааны удирдах ажилтнууд байсан бөгөөд тэдгээр нь хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт бага буюу хүүхдийн оролцоог зөвхөн соёл боловсролын үйл ажиллагаагаар төлөөлүүлж ойлгодог, хүүхдийн засаглал дахь оролцооны талаарх ойлголт мэдлэг нь дутмаг байна. Харин нийслэлийн хүүхдийн асуудал хариуцсан чиг үүрэг бүхий байгууллагын төлөөлөл нь ойлголт, мэдлэгийн түвшин дунд зэрэг(12.5 хувь) ба сайн(12.5 хувь) байв. Ойлголт мэдлэг нь дунд зэрэг ба сайн түвшинд хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, өөрт хамааралтай асуудалд оролцох эрхийн агуулга, арга хэлбэрийн талаар мэддэг төлөөллүүдийг орууллаа.

**Дүрс 38: Нийслэлийн шийдвэр гаргагчдын хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтын түвшин, хувиар**



Дээрхээс харвал нийслэлийн засаг захиргааны удирдах түвшнийхний ойлголт мэдлэг бага, харин хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын төлөөллийн ойлголт мэдлэг дундаас дээш түвшинд байна.

Баримт бичгийн судалгааны үр дүнгээс харахад 2011 оны НЗДТГ-ын Нийгэм, эдийн засгийн зорилтод хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр тухайлсан дараах зорилт оржээ.

- 2.5.7. Нийслэл, дүүргийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд хүүхэд оролцох боломжийг нэмэгдүүлэх

Гэхдээ хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр ажилласан биелэлт тодорхойгүй, үнэлэх боломж бага байлаа.

Нийслэлийн засаг захиргааны нэгжүүд, хүүхдийн чиглэлээр ажиллаж буй байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилтэд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлыг тусгасан байдлыг тодруулах үүднээс судалгааны хүрээнд сонгож авсан зорилтот нийслэлийн 4 байгууллага, 3 дүүрэг, 6 хороо, 4 сургуулийн сүүлийн 2 жилийн 59 үйл ажиллагааны ба төсвийн төлөвлөгөө, тайлан, 2 тогтоол, шийдвэрийн эмхтгэлийн баримтад агуулгын шинжилгээ хийсэн. Үүний 19 нь нийслэлийн түвшний баримт бичиг байв. Энэ шинжилгээг хийхдээ хүүхдийн шууд оролцоог хүүхдийн эрх ашигт нийцсэн гэсэн шалгуураар илүү нарийвчлан авч үзэв. Үүнд:

Төлөвлөгөөний баримт бичигт:

1. Байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилтод хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажил төлөвлөгдсөн эсэх;
2. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа төлөвлөгдсөн эсэх;
3. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлыг нотолгоонд суурилж төлөвлөсөн эсэх;
4. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан эсэх;
5. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэдэн хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа байгаа;
6. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа байсан бол хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа байсан эсэх зэрэг болно.

Төсвийн баримт бичигт:

1. Байгууллагын төсвийн төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны зардал төлөвлөгдсөн эсэх;
2. Байгууллагын төсвийн төлөвлөгөөг хүүхдийн саналыг авч төлөвлөсөн эсэх;
3. “Хүүхдийн” гэсэн тодотголтой зардал байгаа эсэх;
4. “Хүүхдийн” гэсэн тодотголтой зардал байхгүй бол ойролцоо нэрээр томъёологдсон зардлууд байгаа эсэх;

5. Байгууллагын нийт төсөвт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх үйл ажиллагааны зардал туссан байх магадлал бүхий зардлын хувь;

Тайланд:

1. Байгууллагын үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан эсэх;
2. Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны биелэлт байсан эсэх;
3. Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны биелэлт байсан эсэх зэрэг болно.

### 5.3.1 Төлөвлөлт дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал


Баримт бичгүүдэд хүүхдийн талаар бодлогын баримт бичиг ороогүй болно. Дүн шинжилгээнээс үзэхэд, хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажлыг байгууллагын зорилт, үйл ажиллагаанд тусгасан баримт бичиг хангалттай байгаа ч, уг баримт бичиг боловсруулахын өмнө хүүхдийн санал бодлыг авч судалсан баримт бичиг огт байхгүй байна. Нарийвчилсан үр дүнг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав.

**Хүснэгт 17: Нийслэлийн түвшний төлөвлөлтийн үзүүлэлт, хувиар**

| № | Төлөвлөгөөний баримт бичгийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд  | Тийм  | Үгүй  | Тодорхойгүй |
|---|--|-------|-------|-------------|
| 1 | Байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилтод хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажил төлөвлөгдсөн эсэх;                        | 83.3% | 16.7% | 0           |
| 2 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа төлөвлөгдсөн эсэх;                  | 83.3% | 16.7% | 0           |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлыг нотолгоонд суурилж төлөвлөсөн эсэх;         | 0     | 0     | 100%        |
| 4 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурьдсан эсэх;         | 0     | 100%  | 0           |
| 5 | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэдэн хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа байсан бэ?           | 26%   | 74%   | 0           |
| 6 | Байгууллагын хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны хувь | 5.2%  | 94.8% | 0           |
| 7 | Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх бусад ажлууд  | 94.8% | 5.2%  | 0           |

Дээрх хүснэгтээс харахад нийт байгууллагуудын хувьд төлөвлөгөөний баримт бичигт хүүхдийн байгууллагын саналыг тусгаж, тэдний оролцоотой төлөвлөлт хийдэггүй нь батлагдаж байна. Түүнчлэн төлөвлөлтийн баримт бичигт хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлыг нотолгоонд суурилж төлөвлөдөг эсэх нь тодорхойгүй байв. Нийт төлөвлөгдсөн хүүхдийн эрх ашигт нөлөөлөх үйл ажиллагааг дор үзүүлбэл:

### Дүрс 39: Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны төрлүүд, хувиар



Нийт төлөвлөлтийн баримт бичгийн 26% нь хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажил байгаа ч маш цөөн буюу дээрхийн 5.2% нь л хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажлууд байна. Үлдсэн 94.8% нь хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, соёл, хүүхдийн халамж, хамгааллын асуудлууд юм.

Төлөвлөлтийн баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

- 1. Баримт бичигтээ хүүхдийн санал бодол, оролцоог хангаж төлөвлөлт хийх талаар огт дурдаагүй.** Энэ бүлэгт багтаж буй баримт бичгүүд нь байгууллагын үндсэн зорилт, үйл ажиллагааны төлөвлөлтөд хүүхдийн аливаа саналыг сонсож төлөвлөлтийг хийнэ гэж тусгаагүй.
- 2. Баримт бичигт хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажил тусгадаг боловч тэдгээрийн тал хувь нь л хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажил тусгажээ.** Энэ бүлэгт багтаж буй 6 баримт бичгийн 3 нь хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажил төлөвлөсөн байсан. Эдгээр баримт бичиг нь НЗДТГ-ын харьяа хүүхдийн гэр бүл хөгжлийн газрын төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд мөн НЗДТГ-ын нийгэм эдийн засгийн зорилт юм. Ажлын чиг үүргийн хувьд хариуцвал зохих байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтөд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэгдсэн ажил туссан байна.
- 3. Баримт бичигт хүүхдийн оролцох эрхэд чиглэсэн ажил огт тусгадаггүй.** НИТХ, Нийслэлийн боловсролын газар нь хүүхдийн оролцох эрхийг хангах ажлыг төлөвлөлтдөө оруулаагүй байгаа юм. Энэ нь нийт 3 баримт бичиг болно.

## Шигтгээ 12:

...Шууд ардчилал, төлөөллийн ардчилал зэрэгцэн оршиж улс орон ардчилсан замаар замнадаг, иргэний нийгэм бүрэлддэг учиртай. Үүнийг л хийх гээд бид нар эхлүүлж оролдож байна. Хамгийн гол нь наад асуудал чинь их хол байна, 40-50 жилийн дараагийн юмыг та нар ярьж байна. Өнөөдөр монголд засаглалд хүүхдийн оролцоо байтугай насанд хүрсэн хүмүүсийн оролцоо байхгүй байна. Монголд хүүхдийг дандаа түлхэж дарж, том хүний ярианд оролцлоо, юугаараа оролцдог юм гэдэг. Үндэсний соёлд нь байдаг юмуу, хүмүүс нь ийм байх ёстой гэж хүмүүжиж төлөвшсөн ийм орон. Тэгэхээр энд хүүхдийн оролцоо ярих нь хэцүү. Ядаж гэрт бүлд нь хүүхдийн эрхийг хамгаалах тухай, хүүхдийг хүн гэж хүндэтгэж үзэх тухай тийм соёлыг нэвтрүүлэх, дараагийн том асуудал бол хүүхдийг сургууль дээр яаж эрхээ эдлэх талаар ярих ёстой. Шуудхан хэлэхэд Монголд байдаг сургуулиуд хүүхдийг харгисладаг, дарангуйлдаг газар. Сургууль дээр багш л гэхээрээ зөв, хүүхэд дандаа буруу байдаг...

2012.11.08/НИТХ ажлын алба, 12

### 5.3.2 Төсөвлөлт дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал

Нийт байгууллагуудын хувьд төсвийн баримт бичгийг бусдад нээлттэй үзүүлэх, судалгаанд оролцуулахад бэрхшээлтэй байдаг нь судалгааны явцад батлагдсан бөгөөд байгууллага бүрт тус бүр 2-4 удаагийн хандалт хийж, албан захидлын дагуу хүсэлт тавьж танилцсан болно.

Нийслэлийн түвшинд авбал зохих зорилтот 7 төсвийн баримт бичигт агуулгын шинжилгээ хийлээ. Судалгаанаас үзвэл, төсвийн баримт бичигт “хүүхдийн” гэсэн тодотгол ба холбогдолтой зардал нь тодорхойгүй, хүүхдийн саналыг авч төлөвлөдөггүй байна. Дэлгэрэнгүйг хүснэгт 2-аас үзнэ үү.



**Хүснэгт 18: Нийслэлийн түвшний төсөвлөлтийн үзүүлэлт, хувиар**

| № | Төсвийн баримт бичгийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд   | Тийм  | Үгүй  | Тодорхойгүй |
|---|---|-------|-------|-------------|
| 1 | Байгууллагын төсвийн төлөвлөгөөнд “Хүүхдийн” тодотголтой үйл ажиллагааны зардал төлөвлөгдсөн баримт бичгийн хувь  | 28.6% | 0     | 71.4%       |
| 2 | Байгууллагын төсвийн төлөвлөгөөг хүүхдийн саналыг авч төлөвлөсөн эсэх;  | 0     | 0     | 100%        |
| 3 | “Хүүхдийн” гэсэн тодотголтой зардал байхгүй баримт бичгүүдэд магадлал бүхий нэрээр томъёологдсон зардлууд байгаа эсэх;  | 40%   | 40%   | 20%         |
| 4 | Байгууллагын нийт төсөвт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх үйл ажиллагааны зардал туссан байх магадлал бүхий зардлын дундаж хувь (төвлөрсөн үйл ажиллагааны, нэг удаагийн тусламж, барилга байгууламжийн засвар тохижилт гэх мэт ерөнхий нэрээр нэрлэгдсэн зардлууд оров) | 20.3% | -     | -           |
| 5 | Байгууллагын нийт төсөвт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх үйл ажиллагааны магадлал бүхий зардал туссан ба тусаагүй баримт бичгийн хувь   | 57.2% | 28.5% | 14.3%       |

Дээрхээс үзвэл, “Хүүхдийн” тодотголтой зардал төлөвлөгдсөн баримт бичиг 28.6 хувь байгаа нь нийт 7 баримт бичгийн зөвхөн 2 баримт бичигт туссан дүн болно. Энэ 2 баримт бичигт хүүхэд, залуучуудын цогцолбор барих буюу хүүхдийн орчны тохижилтын чиглэлээр хийгдэх тус бүр нэг л ажил байсан нь нийслэлийн бусад зардлуудтай харьцуулахад маш бага байгааг харуулж байна. Харин хүүхдийн оролцох эрхийг хангахад зориулагдан төсөвлөгдсөн төсөв огт байхгүй ч өөр нэрээр томъёологдсон дараах зардлуудад туссан байх магадлалтай байна. Энэ нь ганцаарчилсан ярилцлага болон зарим байгууллагын санхүү хариуцсан мэргэжилтнээс ирсэн мэдээллээр баталгаажсан болно. Үүнд:

- Төвлөрсөн үйл ажиллагааны зардал
- Нэг удаагийн тусламж
- Барилга, байгууламжийн засвар тохижилт
- Сургалт, семинарын зардал
- Уралдаан, тэмцээн
- Хурал зөвлөгөөн
- Ном авах гэх мэт.

Эдгээр зардлуудад хүүхдийн эрх ашигт нөлөөлөх үйл ажиллагаа ороогүй байж ч магадгүй, тодорхойгүй байгаа нь тухайн байгууллагын төсвийн төлөвлөлтөд хүүхдийн эрх ашигт нөлөөлөх асуудал төдийлөн ач холбогдол багатай, эсвэл төсвийн төдөвлөгөөг бэлтгэдэг шаталсан бүтцэд энэ асуудлаар төсөвлөлт байдаггүйтэй холбоотой байж болох юм. Жишээлбэл хүүхдийн эрх ашгийг нийслэлийн хэмжээнд шууд хариуцдаг НХГБХГ-ын төсөвт “Хүүхдийн” тодотголтой зардал байдаггүй, төсөв ч ирдэггүй байна. Ерөнхийдөө төсвийн төлөвлөгөөнд хүүхдэд зориулагдсан зардал тодорхой бус байна.

### Шигтгээ 13

*...Хүүхдийн болон төрийн байгууллагын төсөв бага байдаг. Үндэсний хөтөлбөрөөс гардаг, зарим нь хандив, гадны байгууллагаас хийгддэг. Төсвийг бол тааж төлөвлөдөг. Тодорхой байдаггүй учраас ийм зүйл болдог. Хүүхэд хамгааллыг хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэх төслөөс 60 орчим сая төгрөгийг манай байгууллагад төсөвлөж өгсөн. Хугацаа тодорхой тавигдсан ч гэсэн төсөв нь тодорхой бэлэн байдаг биш. Ямар ч байсан ийм нэг ажил хийгдэнэ гэсэн байдлаар байдаг. Төсөв нь ямар нэгэн байдлаар шийдэгдэх байх гээд л ажил явдаг. Хүүхдийн байгууллага төсвийн хувьд хэцүү байдаг.*

*2012.11.13/НХГБХГ мэргэжилтний ярилцлагаас, 18*

*...НХГБХГ-т хүүхдийн холбогдолтой төсөв ирдэггүй, зөвхөн байгууллагын зардал ирдэг, янз бүрийн хөтөлбөрөөс л бид хүүхдүүддээ зарцуулдаг. Харин энэ онд түүхэндээ байгаагүй их төсөвтэй байсан. Шадар сайдын багц, хүүхэд хамгаалал ба ХБХ-ийн дэд хөтөлбөрөөс нэлээд хэдэн сая төгрөг орж ирсэн...*

*2012.12.13/НХГБХГ-ын мэргэжилтнээс утсаар мэдээлэл тодруулав*

Ганцаарчилсан ярилцлага болон нийслэлийн түвшний төсвийн баримт бичгээс харахад магадлал бүхий зардлын төсөв 2011 онд 9.4 хувь, 2012 онд 22 хувь байна. Хэдий ийм байгаа боловч энэ нь зөвхөн сургууль, цэцэрлэг барих, тэдгээрийн орчныг сайжруулах, тохижилт хийх зардлууд юм. Хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн тухайлсан ажлын зардал байгаагүй болно.

### Шигтгээ 14

*...Жнь: Хан-уул дүүрэг 90000 хүн амтай, тэнд засаг даргын тамгын газарт ажиллаж байгаа хүнийх нь бүтэц орон тоо нь СХД-тэй адилхан. Тэгсэн хэрнээ бид нар энд 260000 хүнд үйлчилж байгаа. Үйлчилдэг хүрээ нь энэ, гэтэл тэнд 90000-100000 хүн л байна.1,5-6 дахин их хүн амд ижилхэн бүтэц , орон тоогоор төрийн үйлчилгээ юмаа хүргэх гээд байна. Тэгэхээр энэ хоёрын хооронд ялгаа гарна, сааралт юмуу сарнилт зайлшгүй гарна. Төрийн албан хаагчдад ирэх ачаалал нь нэмэгдэнэ, төрийн албан хаагч маань иргэд рүү гээ хүрч ажиллах нь багасах нь аргагүй. Тэгэхээр улсын төсвийг хэлэлцэхдээ хүн амынх нь тоонд харьцуулж төсөв хуваарилалт хийдэг байх нь оновчтой юм.*

*2012.11.8/НИТХ-ын төлөөлөгч, 15*

#### 5.3.3 Хэрэгжилт дэх хүүхдийн оролцооны өнөөгийн байдал

Шийдвэр гаргах үйл ажиллагааны хэрэгжилтэд байгууллагын үйл ажиллагааны тайлан эсвэл биелэлтийг авч үзэж байна. Мөн түүнчлэн нийслэлийн түвшний ганцаарчилсан ярилцлагуудаар судалгааны үр дүнг баталгаажуулсан болно.

Нийт 4 баримт бичигт агуулгын шинжилгээ хийсэн бөгөөд ихэнх баримт бичигт хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдаагүй байв. Мөн дийлэнх байгууллага тухайн жилд дэвшүүлсэн хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн зорилт, үйл ажиллагааг биелүүлэхээр ажилласан байна. Дэлгэрэнгүйг хүснэгт 4-өөс харна уу.

### Хүснэгт 19: Үйл ажиллагааны биелэлт, тайланг үнэлэх шалгуур үзүүлэлт, хувиар

| № | Үйл ажиллагааны биелэлт, тайланг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд  | Тийм  | Үгүй  | Тодорхойгүй |
|---|--|-------|-------|-------------|
| 1 | Байгууллагын үйл ажиллагааны тайланг боловсруулахдаа хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан эсэх;                              | 25%   | 75%   | 0           |
| 2 | Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны биелэлт байсан эсэх;                                   | 100%  | 0     | 0           |
| 3 | Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэгдсэн ажлын хувь | 10.4% | 89.6% | 0           |
| 4 | Байгууллагын үйл ажиллагааны тайланд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны биелэлт байсан эсэх;                          | 75%   | 0     | 25%         |

Хүүхдийн санал бодол, оролцоог хангах талаар дурдсан ганцхан тохиолдол байсан. Энэ нь НЗД-ын 2011 оны “Нийгэм, эдийн засгийн зорилттын биелэлт”-ийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил хамгаалал зорилтын 2.5.7<sup>6</sup>-ийн хүрээнд 2009 оны хүүхдийн зуслангийн хөтөлбөрийг 500 хүүхдийн санал бодлыг авч түүнд тулгуурлан боловсруулсан бөгөөд 2009-2011 оны зуслангийн хөтөлбөрт тусган ажиллаж байна.

Тайлангийн баримт бичигт туссан нийт үйл ажиллагааны хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны дундаж 40.96 хувь байна. Харин төлөвлөснөө биелүүлсэн хувь дунджаар 57.92 хувь байна. Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны дэлгэрэнгүй задаргааг дараах хүснэгтээс харна уу.

### Хүснэгт 20: Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагааны төлөвлөлт ба биелэлт, хувиар

| Хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх үйл ажиллагаа                  | Төлөвлөсөн дундаж хувь | Тайланд туссан дундаж хувь | Зөрүү   |
|---|------------------------|----------------------------|---------|
| Хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэгдсэн ажил                | 5.12%                  | 10.37%                     | +5.25%  |
| Хүүхдийн сургууль, цэцэрлэг болон орчны засвар, тохижилтын ажил | 25.63%                 | 30%                        | +4.37%  |
| Хүүхдийн боловсрол, соёлын ажил                                 | 29.56%                 | 52.37%                     | +22.81  |
| Хүүхдийн эрүүл мэндийн ажил                                     | 0.4%                   | 3.15%                      | +2.75   |
| Хүүхдийн халамж, хамгааллын ажил                                | 12.85%                 | 38.7%                      | +25.85% |
| Хүүхдийн холбогдолтой судалгаа, дүн мэдээ, тайлангийн ажил      | 9.65%                  | 32.7%                      | +23.05% |


<sup>6</sup> 2.5.7 дахь зорилт нь “Нийслэл дүүргүүдийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцох боломжийг нэмэгдүүлнэ” гэсэн байна.

Хүснэгтээс харвал хүүхдийн сургууль, цэцэрлэг болон орчны засвар, тохижилтын ажил төлөвлөгөөнд багагүй хувийг (25.63%) эзэлж байгаа ч тайланд тусахдаа маш бага буюу ердөө дунджаар 4 хувийг л эзэлсэн байна. Эндээс дүгнэхэд хэдийгээр төлөвлөлтөд дээрх хүүхдийн бүхий л чиглэлийн ажлууд харилцан адилгүй хувьтай байсан ч тайланд нийт төлөвлөсөн ажлууд-ын хэрэгжилт өсч туссан байна. Нийт байгууллагуудын хувьд хүүхдийн боловсрол, соёлын ажил болон хүүхдийн халамж, хамгааллын ажил, хүүхдийн холбогдолтой судалгаа, дүн мэдээ, тайлан гаргах ажил нь төлөвлөснөөс илүү хэрэгжсэн харагдаж байна.

#### *НИТХ-ын сүүлийн хоёр жилийн тогтоол шийдвэрийн эмхтгэл*

НИТХ нь иргэдийн өөрөө удирдах ёсны байгууллага учраас нийслэлийн засаг даргын мөрийн хөтөлбөр, зорилтод хяналт тавьж, хамтран төсөв баталдаг ч өөрийн гэсэн төсөв, төлөвлөгөө, тайлан бус нийслэлийн хэмжээний үйл ажиллагааны тогтоол, шийдвэрийг баталдаг гол байгууллага юм.

#### **Дүрс 40: НИТХ-ын тогтоол, шийдвэрт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх шийдвэр гарсан хувь**



Дүрсээс харахад нийт гарсан шийдвэрийн цөөн хувь нь хүүхдэд шууд нөлөөлөх ажлын тухай, түүнийг хэрэгжүүлэх тухай тогтоол шийдвэр байсан бөгөөд дийлэнх нь хүүхдийн асуудлаас бусад шийдвэрүүд эзэлж байлаа.

#### *Нийслэлд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн мэдээлэл*

Нийслэлийн хэмжээнд “Хууль эрх зүй, төрийн захиргаа”, “Байгаль орчин, дэд бүтэц”, “Эрүүл мэнд, нийгэм, соёл боловсрол”, “Хүнс хөдөө аж ахуйн” гэсэн 4 салбарын

нийт 31 хөтөлбөр нийслэлд хэрэгжиж байна. 2012 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн байдал 48 хувьтай, хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацааны хэрэгжилт нийт дүнгээрээ 77.1 хувийн биелэлттэй байна<sup>7</sup>. Эдгээр хөтөлбөрөөс хүүхэд үр ашгийг нь шууд хүртэх боломжтой дараах 4 хөтөлбөр, 1 дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

1. Хүн худалдах, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр (2006-2014)
2. Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр(2007-2015)
3. Боловсрол үндэсний хөтөлбөр (2010-2021)
4. Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2006-2015)
5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оролцоог дэмжих дэд.

Эдгээр үндэсний хөтөлбөрүүдэд хүүхдийн оролцоог хангахад чиглэсэн үйл ажиллагаа үйлчилгээ огт байхгүй бөгөөд хөтөлбөрийн төлөвлөлтөд санал нь тусах ба хэрэгжилтэд хяналт тавих боломж тодорхойгүй хэрэгжсээр байна.

*i. Нийслэлийн түвшинд хүүхдийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудлууд*

Ганцаарчилсан ярилцлагын дүнгээс харахад судалгаанд оролцогчид төрийн болон төрийн бус байгууллагад ажилладгаас үл хамааран хүүхдийн оролцоо огт байхгүйг баталж хэлсэн юм.

#### Шигтгээ 15

*Та бүхэн үйл ажиллагааныхаа төсөвлөлт, төлөвлөлт, хэрэгжилтэд хүүхэд оролцуулдаг уу?*

*... 3Д-ын тамгын газар иргэдийн санал авахад хүүхдийн оролцоо бараг байхгүй .Улаанбаатар сонсож байна гэж утсаар мэдээлэл авч байна, өргөдөл гомдол цаасан хэлбэрээр, цахим хэлбэрээр авч байна. Хүүхдүүдийг ер нь багш нараар нь дамжуулж сонсож байна. Саяхан хүүхдүүдээ сонсьё гэдэг аян явуулаад хүүхдүүдийг сонсож байна л даа. Засгийн газар үүнийг тогтмол жил болгон явуулах нь зөв юм байна.*

*...Бусад засаг дарга нарыг би мэдэхгүй юм. Дүүргүүдийн засаг дарга нарыг төлөөлж хариулж болохгүй. Дүүрэг болгон өөр. Бид нар ажлаа аваад 3 сарын хугацаанд тийм зүйл болоогүй.*

2012.11.08/НИТХ,НЗДТГ, I1

Мөн судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 4% нь оршин суугаа газар тоглоомын талбайд зөвшөөрөлгүй байшин, барилга баригдвал нийслэлийн засаг даргад хандана гэсэн байсан. Энэ нь хүүхдүүд шийдвэрлэхэд хэцүү асуудлаар хэнд хандах, засаглалын шаталсан түвшний хаанаас эхэлж, ямар мэргэжилтэнд хандах талаар мэдээлэл, мэдлэг бага байгааг харуулж байна.

<sup>7</sup> Нийслэлд хэрэгжиж байгаа Үндэсний хөтөлбөрийн эхний хагас жилийн хэрэгжилт, 2012 он

Судалгаанд оролцогч удирдах түвшний ажилтнууд, ОУБ болон ТББ-ын төлөөлөл нь дараах асуудлыг засаглалд хүүхдийн оролцох эрх хангагдаж чадахгүй тулгамдсан асуудлууд гэж нэрлэж байв. Үүнд:

- Хүүхдийн талаарх буруу тогтсон хандлага
- Шийдвэр гаргах түвшний удирдлагын хүүхдэд хандах хандлага
- Төрийн байгууллагын албан тушаалын томилгоо, хариуцсан мэргэжилтнүүдийн албан тушаал солигдоход ажлын залгамж чанар алдагддаг. Ихэнх удирдлага сонгуультай холбоотойгоор солигдож тогтворгүй байдаг.
- Хөрөнгө мөнгө
- Төрийн байгууллагын ажлын ачаалал
- Төрийн байгууллагуудын салбар хоорондын уялдаагүй, мэдээлэлгүй байгаа байдал
- Хүүхэд оролцуулах журам, дагаж мөрдөх ямар нэг зохицуулалт байдаггүй.
- Хөрөнгө оруулалт тархай бутархай
- Төрийн хүүхдийн чиглэлийн бүтэц зохион байгуулалт хангалттай ажилладаггүй.

#### Шигтгээ 5

*...Ер нь томчууд хүүхдийг тоглоом шиг үздэг. Гоёл чимэглэлийн хэрэгсэл шиг харж хандаад байгаа юм. Одоо хүртэл ажиглагдаж байгаа. Нэг том дарга ирэхэд гудамжинд зогсоогоод алга ташуулдаг хэрэгсэл, урд нь дуулуулдаг гаргадаг хэрэгсэл хэрэглэгдэхүүн байдлаар хараад яг асуудал хэлэлцэхдээ ЗА БАЙЖ БАЙ гээд томчууд өөрсдөө тойрч суугаад хүүхдийн асуудлаа шийдээд байдаг. Түвшин бүрийн шийдвэр гаргагчдын мэдлэг ойлголт хандлага өөр өөр байгаа. Тэднийг эхлээд өөрчлөх хэрэгтэй. Сайдаас нь эхлээд дээрээсээ хийвэл зүгээр байна. Мөн манай яамдууд болон салбар хоорондын уялдаагүй ажиллаж байгаа байдал чөдөр болдог.*

2012.11.15/ТББ-ын төлөөлөл, 112

Эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нийтлэг арга замыг судалгаанд оролцогч төрийн байгууллага болон ОУБ, ТББ-уудын төлөөлөл дараах байдлаар тодорхойлов.

1. Төрийн байгууллагын удирдах болон хүүхдийн асуудлыг хариуцсан ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх;
2. Дээрх ажилтнуудын ажлын чиг үүрэг, үр дүнгийн гэрээнд хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажлыг тодорхой оруулах;
3. Нийслэлийн засаг захиргааны байгууллагуудад хүүхэд өөртөө холбоотой асуудлаар оролцох журам, аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх

гэсэн үндсэн 3 шийдвэрлэх арга замыг санал болгосон. Үүнээс харвал төрийн болон төрийн бус байгууллагын аль ч төлөөлөл хүүхдийг өөртөө хамааралтай асуудлаар оролцох тал дээр адил байр суурьтай байгаа нь цаашид энэ ажлыг өргөжүүлэх боломжтойг харуулж байна.

#### Шигтгээ 16:

*...ЯХИС том туршлагатай байгууллага, энэ судалгааг үндэсний хэмжээнд бүх түвшинд явуулаад шинэчлэлийн ЗГ-т хүүхдийн асуудлаа шинэчилье гээд судалгааны үр дүн, зөвлөмжийг өгчихвөл сайн байна. Энэ ЗГ байгуулагдаад бужигнаж байгаа ч энэ жил биш юмаа гэхэд ядаж дараагийн жилийн үйл ажиллагаанд нь оруулахаар ажиллаад алхамууд хийчихвэл энэ судалгааны үр дүнг олон хүн хүртэх байхаа. Олон түвшинд нь хэлэлцүүлж нөлөөлвөл сайн байна гэсэн саналтай байна. Энэ бол хэдхэн байгууллагын хүүхдүүдээ оруулах гээд байгаа асуудал биш хүүхдийг эрхээ эдлэх боломж олгох, зөв хүн төлөвшүүлэх тухай асуудал. Мөн хүүхдийн байгууллагын нэр хүндийг өсгөх бодлогоор дэмжих хэрэгтэй. Хүүхэд бол чухал, мөн тэдний эрх ашгийг хамгаалдаг байгууллага нь чухал гэдгийг зөвлөмждөө, цаашидаа ч анхаарах хэрэгтэй.*

*2012.11.15/ТББ-ын төлөөлөл, I12*

Судалгааны явцад хүүхдийн оролцох эрхийн талаарх судалгаа Монгол улсад хийгдэж байгаагүй нь батлагдсан бөгөөд ТББ, ОУБ-ын төлөөлөл энэ судалгааны үр дүнг олон түвшинд хэлэлцүүлж, үр дүнг танилцуулах нь ач холбогдолтой, өөрсдийн хувь нэмрийг оруулах боломжтой, нээлттэй гэдгийг илэрхийлж байсан.

## Дүгнэлт

“Орон нутгийн шийдвэр гаргалтад хүүхдийн оролцоо” сэдэвт суурь судалгаанаас дараах дүгнэлт гарч байна.

- ❖ Хүүхдүүдийн оролцооны талаарх мэдээлэл хомс байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 56.9 хувь нь хүүхдийн оролцооны талаар бага зэргийн мэдээллийг нийгмийн ухааны хичээлээр дамжуулан авч байсан бол 28 хувь нь энэ талаар огт мэдэхгүй гэж хариулжээ. Мэдээлэл муутай хүүхдүүдийн ихэнх нь бага насныхан болон зорилтот бүлгийн хүүхдүүд байна. Иймд эдгээр бүлгийнхэнд чиглэсэн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- ❖ Хүүхдүүд насанд хүрэгчидтэй хамтран шийдвэр гаргах хүсэлтэй байна. Судалгаанд хамрагдсан ЕБС–ийн сурагчдын 64.7 хувь нь томчуудтай хамтран зөвлөлдөх, шийдвэр гаргахыг хүүхдийн оролцох эрх гэж тодорхойлсон. Мөн зорилтот бүлгийн хүүхдүүд хэдий хүнд нөхцөлд амьдардаг ч тэдний 52.9 хувь нь томчуудтай хамтран шийдвэр гаргах хүсэлтэй байдаг ажээ. Бага насны хүүхдүүдийн дунд “хүүхдүүд томчуудын асуудалд оролцох ёсгүй” гэсэн ойлголт давамгайлах хандлагатай байна. Хүүхдүүд насанд хүрэгчидтэй хамтран шийдвэр гаргах хүсэлтэй байдаг нь хүүхдийн оролцооны эрхийг хангахад чухал нөлөөтөй. Хүүхдүүд оролцох эрхээ хэрхэн эдлэх талаар тодорхой мэдлэгтэй болж чадвал тэд өөрсдийн эрх ашигт нөлөөлөх шийдвэрт дуу хоолойгоо хүргэх бүрэн боломжтой юм.
- ❖ Шийдвэр гаргах түвшинд хүүхдийн оролцооны түвшин бага байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 58.1 хувь нь шийдвэр гаргах түвшин дэх өөрсдийн оролцоог муу гэж үнэлжээ. Хүүхдэд шууд чиглэсэн анхан шатны нэгж байгууллага байхгүй, оролцох эрхийн талаар мэдээлэл дутмаг зэрэг нь шийдвэр гаргах түвшин дэх оролцоо хангалтгүй байхад нөлөөлж байна. Зорилтот бүлэг болон бага насны хүүхдүүдийн оролцооны түвшин бүр ч доогуур үзүүлэлттэй байна. Иймд орон нутгийн анхан шатны нэгж болох хороогоор дамжуулан хүүхдийн оролцоог тэр дундаа зорилтот бүлгийн хүүхдийн оролцоог дэмжих шаардлага тулгарч байна.
- ❖ Гэр бүл, олон нийтийн дунд хүүхдийн оролцооны талаарх мэдлэг бага, тогтсон хандлага давамгайлж байна. Эцэг эхчүүд, гэр бүлийн хүрээнд тогтсон “хүүхэд томчуудын ярианд оролцох ёсгүй” гэсэн тогтсон хандлага хүүхдийг гэр бүлийн түвшинд зөвхөн сонсогчийн үүрэгтэй оролцоход ихээхэн нөлөөлж байгаа нь ажиглагдсан. Үүнээс үүдэн хүүхэд нийгмийн анхдагч орчиндоо оролцох эрхээ эдэлж чадахгүйд хүрч байгаа тул орон нутгийн засаглалд оролцох хандлага ч доогуур байна. Иймд гэр бүл болон олон нийтэд чиглэсэн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг сайн түгээх шаардлагатай байна.
- ❖ Гэр бүлийн шийдвэр гаргах түвшинд бага насны болон зорилтот бүлгийн хүүхдийн оролцоо бага байна. Зорилтот бүлгийн хүүхдүүдийн 48.5 хувь нь гэр бүлийн шийдвэр гаргалтад оролцохгүй байна. Эцэг эх нь тэдний санал бодлыг сонсдоггүй, тэдэнд хамаатай шийдвэрт хүүхдийг оролцуулахгүй байх хандлага жирийн сургуулийн сурагчдаас илүү байна. Зорилтот бүлэг болон бага насны хүүхдүүдэд



үзэл бодлоо илэрхийлэх, санал бодлоо хуваалцах дэмжлэг байхгүй нь тэдний шийдвэр гаргах түвшин дэх оролцоог бууруулж байна.

- ❖ Сургуулийн түвшинд үйл ажиллагааны төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилтийн хяналтад хүүхдийн оролцоо бараг байхгүй байна. Сургуулийн үйл ажиллагаа, хүүхдэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөлтөд хүүхэд өөрөө болон төлөөллийн байгууллагаар дамжуулан оролцох боломж байдаг ч, түүний төсөвлөлт болон хэрэгжилтийг хянах, үйл ажиллагааг үнэлж дүгнэх, санал бодлоо илэрхийлэх боломж хаалттай буюу зөвхөн багш, удирдлагын түвшинд зохион байгуулагддагаас шалтгаалан эдгээр түвшинд хүүхдийн оролцоо бага байна.
- ❖ Сургуулийн орчинд хүүхдийн оролцоог дэмжих шүүд бүтэц, зохион байгуулалт дутмаг байна. Судалгаанд хамрагдсан сургуулиуд дээр хангалттай тооны хүүхдийн оролцооны байгууллага бий болсон байна. Гэвч ихэнх тохиолдолд хариуцан ажиллах, хүүхдийн оролцоогоор мэргэшсэн багш байхгүй, хүүхдийн оролцооны байгууллагуудыг ажиллах нөхцөлөөр хангадаг бүтэц зохион байгуулалт, сургуулийн нөөц, хүүхдээ чадваржуулах тогтолцоо дутмаг байгаагаас сургууль дээрх хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа тасалдаж, хязгаарлагдмал хүрээнд хэрэгжиж байна.
- ❖ Дүүргийн түвшинд хүүхдийн оролцоог хангасан ажлууд дутмаг байна. Судалгаанд хамрагдсан дүүргүүдийн 2011, 2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийсэн баримч бичгийн судалгааны дүнд хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажлууд 11.3 хувийг эзэлж байгаа бөгөөд уг ажлын 12.1 хувийг хүүхдийн оролцооны ажлууд эзэлж байна. Харин дүүргийн төсөвлөлт болон хэрэгжилтийн хяналтад хүүхдийг оролцуулах талаар тодорхой дүрэм, журам байхгүй мөн хүүхдийн оролцоог хангасан ажлуудад зориулагдсан төсвийн задаргаа байхгүй байгаа нь зарцуулалтыг үнэлэхэд тодорхойгүй байдлыг бий болгож байна.
- ❖ Шийдвэр гаргах түвшинд удирдлагуудын хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт харилцан адилгүй байна. Хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт НХГБХГ, ХТҮГ, ОУБ, ТББ-ын түвшинд эерэг зөв байгаа ч, орон нутгийн шийдвэр гаргах түвшний удирдлагуудын энэ талаарх ойлголт муу байна. Тэд хүүхдийн оролцоог зөвхөн соёл, боловсролын асуудлаар хязгаарлан ойлгож байв. Энэ нь хүүхдийг шийдвэр гаргах түвшинд оролцуулах мэдлэггүй, тогтсон арга барилгүйтэй холбоотой байна.
- ❖ Хорооны үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо байхгүй байна. Хорооны түвшинд жилийн төлөвлөгөөнд нь хүүхдийн асуудал нийт ажлын 10.4 хувийг эзэлж байгаа ч эдгээр ажилд хүүхдийн санаа бодол тусгагдсан эсэх нь баримт бичиг дээр тодорхойгүй байгаа бөгөөд нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 89.6 хувь нь хорооны түвшинд огт оролцдоггүй, 82.2 хувь нь хорооны төлөвлөгөөнд өөрийн санал бодлоо тусгадаггүй, 91.1 хувь нь хэрэгжилтийн биелэлтэд огт оролцдоггүй гэж үзжээ. Хүүхдэд хандсан үйл ажиллагаа ажил үүрэгт нь туссан нийгмийн

ажилтнууд болон хорооны засаг дарга нарын хүүхдийг оролцуулах ойлголт нь ихэнхдээ хүүхдийн баярын арга хэмжээ, тэмцээн уралдаанд хамруулах зэргээр хязгаарлагдаж байгаа нь хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээлэл, мэдлэг дутмаг байгааг харуулж байна.


- ❖ Хорооны үйл ажиллагааны талаарх хүүхдүүдэд чиглэсэн мэдээлэл алга байна. Хорооны үйл ажиллагааны талаарх ойлголт хүүхдүүдэд байхгүй байгаа нь фокус бүлгийн судалгаагаар тогтоогдсон бөгөөд хүүхдүүд хороог томчуудад үйлчилдэг газар, бичиг баримт хөөцөлддөг газар гэж үзэхээс өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх газар гэж үзэхгүй байгаа нь харагдаж байв. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 40.2 хувь нь хороонд хандахгүй, хорооны үйл ажиллагааг огт мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ.
- ❖ Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхдийн эрх ашигтай холбоотой аливаа төлөвлөлтөд хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлж, нийгмийн амьдралд оролцох эрхээ эдлэх боломж муу байна. Учир нь нийслэлийн төсөвлөлт, төлөвлөлт, хэрэгжилтийн баримт бичигт хүүхдийг оролцуулж, саналыг нь тусгах талаар огт дурдаагүй. Энэ нь хүүхдийг хэрхэн оролцуулах талаарх шийдвэр гаргагч удирдлагын мэдлэг бага, нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай ажлын жагсаалтад хүүхдийн оролцох эрхийг хангах ажил орохгүй байгаатай холбоотой байж болох юм. Төлөвлөлтийг хийхдээ хүүхдийн чиглэлээр ажилладаг байгууллага, мэргэжилтнүүдийн судалгаа мэдээлэлд үндэслэж төлөвлөж байгаа нь энэ түвшинд чиглэсэн нөлөөллийн ажил хийх боломжтойг харуулж байна.
- ❖ Аливаа төлөвлөлтийг нотолгоонд суурилдаг эсэх нь төлөвлөлтийн баримт бичгээс нь харагдахгүй, тодорхойгүй байна. Хороо, дүүрэг, нийслэлийн аль ч түвшний жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд ямар нотолгоонд суурилж байгаа нь тодорхойгүй байна.
- ❖ Нийслэл болон дүүргийн түвшний төлөвлөлтөд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажил маш бага хувийг эзлэж байна. Дүүргүүдийн хувьд үйл ажиллагааны төлөвлөгөөний дөнгөж 1 хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажлууд байгаа бөгөөд эдгээр төлөвлөгдсөн ажлынх нь 22.2 хувь нь хүүхдийн чуулга уулзалт, хурал зөвлөгөөний ажил байгаа бөгөөд хүүхдийн оролцоонд шууд чиглэсэн ажил байхгүй байна. Харин нийслэлийн хувьд нийт ажлын 28.6 хувь нь хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх ажил байгаа ч, үүний 5.2 хувь нь л хүүхдийн оролцох эрхийг хангах зарим ажил байгаа юм. Төлөвлөсөн ажлын ихэнх нь хүүхдийн орчны тохижилт, соёл, боловсрол, халамж хамгааллын ажлууд байгаа бөгөөд энэ чиглэлд л төсөв зарцуулагдаж байна. Цаашид хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажлын эзлэх жинг 15 хувьд хүргэх шаардлагатай.
- ❖ Нийслэлийн түвшинд 2 байгууллага хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр ажил төлөвлөөгүй байв. Энэ нь удирдлагын болон хариуцсан мэргэжилтний ажлын

чиг үүрэгт нь хүүхдийн оролцоог хангах талаар шууд тусаагүй, хэт ерөнхий тодорхойлсон байдагтай холбоотой юм. Цаашид нийслэлийн түвшинд хүүхдийн асуудлаар холбогдох байгууллагуудын хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажлын чиг үүргийг тодорхой болгож, байгууллагын журам, дүрэм, ажлын биелэлтийг дүгнэх нэг үзүүлэлт болгох нь зүйтэй. Энэ нь шийдвэр гаргах түвшинд хүүхэд оролцох суурь нөхцөл болно.

- ❖ Нийслэлийн түвшинд төсөвлөлт хийхэд хүүхдийн шууд оролцоо байхгүй төдийгүй тэдгээрийн төлөөлөл, хариуцсан мэргэжилтэн ч оролцох зохицуулалт механизм бүрдээгүй байна. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн асуудал хариуцдаг байгууллагад “Хүүхдийн” гэсэн тодотголтой төсөв байдаггүй бөгөөд холбогдох мэргэжилтнүүд хүүхдэд чиглэсэн үндэсний бусад хөтөлбөр, нэмэлт санхүүжилтээр л төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.
- ❖ Орон нутгийн төсөвт “хүүхдийн” гэсэн тодотголтой зардал туссан эсэхийг мэдэх, үнэлэх боломжгүй байна. Учир нь ихэнх байгууллагын төсөвтэй холбоотой баримт бичигт нийтлэг ерөнхий нэршилтэйгээр зардлууд орсон нь “Хүүхдийн” тодотголтой төсөв байгаа эсэхийг хэлэх боломжгүйд хүргэж байна. Энэ нь төсвийн ил тод байдлын тухай хууль, төрийн захиргааны байгууллагын удирдлага санхүүжилтийн хуульд заагдсан ил тод нээлттэй, олон нийт хэлэлцэж, саналаа тусгах боломжтой байх гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.
- ❖ Нийслэлийн төсөвт хүүхдийн оролцох эрхийг хангах ажилд төсөвлөгдсөн зардал огт байхгүй байна. Нийслэлийн төсвийн нийт баримт бичгийн 28.6 хувь нь хүүхдийн эрх ашгийг хангахад чиглэсэн ажил төлөвлөсөн байна. Энэ нь төсвийн нийт 7 баримт бичгийн 2 нь хүүхдийн эрх ашигтай холбоотой зардал тусгасныг илэрхийлсэн болно. Төсөвлөгдсөн цөөн ажил нь зөвхөн хүүхдийн орчны тохижилтод зориулагджээ. Цаашид хүүхдийн эрхийн конвенцид заагдсан үндсэн эрхийг хангахад чиглэсэн ажлуудад тодорхой төсөв зарцуулдаг байх, түүнийг хүүхдүүд болон тэдний эцэг эх, төлөөллийн байгууллага, олон нийт хянах, санал оруулах боломжтой болгоход анхаарах шаардлагатай байна.
- ❖ Нийт хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажлын хэрэгжилт харьцангуй сайн байсан. Хэрэгжилтийн баримт бичгээс харвал анх төлөвлөсөн ажлыг 2-25 хувь хүртэлх хувиар давуулж биелүүлсэн нь нийслэлийн түвшинд хүүхдийн эрх ашигт нөлөөлөх ажил төлөвлөсөн хүрээндээ амжилттай хэрэгждэг гэж дүгнэж болохоор байна. Хэрэв хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр хийгдэх ажил албан ёсны төлөвлөлтөд орж, шийдвэр гаргагчид, удирдлагын зүгээс дэмжлэг хүлээж чадвал хэрэгжих бүрэн боломжтой байна.
- ❖ Нийслэлийн ИТХ-аас сүүлийн жилд гаргасан тогтоол, шийдвэрийн 6.17 хувь нь л хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх шийдвэр байв. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчид нөөц боломжийнхоо хүрээнд асуудлыг шийдвэрлэж байгаа ч, тэдний хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлбэл гаргаж буй шийдвэр нь хүүхдийн бусад үндсэн эрхийг хангахад чиглэж, хэрэгжих боломжтой гэж үзэж байна.
- ❖ Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдэд хүүхдийн оролцох эрхийг хангах ажил тусгагдаагүй байна. Нийт хөтөлбөрийн 16.1 хувь нь хүүхдэд

чиглэсэн хөтөлбөрүүд байгаа ч, тэдгээр нь хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажил тусгаагүй бөгөөд хэрэгжилтийн биелэлтэд хүүхэд хяналт тавих талаар огт дурдаагүй байна. Иймд цаашид хүүхдэд хамааралтай аливаа хөтөлбөрт хүүхэд оролцож саналаа хэлж, төсөв болон биелэлтэд нь хяналт тавих боломжийг бүрдүүлэхэд анхаарч, тухайлсан журам, хэрэгжилтийг үнэлэх шалгуур боловсруулах хэрэгтэй юм. Энэ нь орон нутгийн хөгжилд төдийгүй хүүхдийн оролцох эрхийн өнөөгийн байдалд ихээхэн ахиц гаргана гэж үзэж байна.

Оролцогч талуудын хүүхдийн оролцооны эрхийн талаарх мэдлэг, ойлголтын түвшин болон төсөвлөлтийн дүрслэл зураг / орон нутгийн засаглалын түвшингээр/



**Зураглал тайлбар:**

Мэдлэг, ойлголтын түвшинг 1-5 оноогоор үнэлсэн. Хангалттай-5 Сайн -4 Дунд -3 Муу -2 Хангалтгүй-1

Хүүхдийн оролцооны үйл ажиллагааны төсөвлөлтийг “+” болон “-” дүрсээр илэрхийлсэн. “+”- төсөвтэй “-” төсөвгүй

\*ХИС-Хүүхдийг ивээх сан \* НҮБХС- Нэгдсэн үндэсний байгууллагын \*Хүүхдийн сан \*СХ-Сурагчдын холбоо

\*МУЗН-Монголын улаан загалмайн нийгэмлэг \*ЗХ-Залгамжлагч холбоо

\*БХАН-Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг

## **Санал зөвлөмж**

### **Хаяг тогтоох төв болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын түвшинд**

- ❖ Зорилтот бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн хүүхдийн оролцох эрхийн талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах шаардлагатай. Уг бүлгийн хүүхдүүд сургууль завсардсан, гэр бүлийн орчиноос хөндийрсөн байдаг тул тэдэнд чиглэсэн үйлчилгээг хүргэдэг хаяг тогтоох төв болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ болон ОУБ – тай хамтран хүүхдийн оролцох эрхийн талаар сургалт зохион байгуулах нь чухал шаардлагатай.

### **Гэр бүлийн түвшинд**

- ❖ Сургуулийн сурагчдад эцэг эхийн хурлаар дамжуулан “Хүүхдийн оролцоо”-ы цуврал сургалтыг зохион байгуулж, эцэг эхийг мэдээллээр хангах зүйтэй.
- ❖ Бага болон дунд ангийн хүүхдүүдэд “ Иргэний боловсрол”-ын хичээлийн хөтөлбөрт Хүүхдийн Эрхийн Конвенцийн 12-р заалтыг тусгай хичээлийн сэдэв болгон оруулах шаардлагатай байна.
- ❖ Гэр бүлийн тухай хуулийн 5-р бүлгийн 25, 26-р зүйлд хүүхдийн оролцох эрх, түүнд гэр бүлийн хүлээх үүргийг тусгуулж, хүүхдийн оролцоог хуулиар баталгаажуулах шаардлагатай.

### **Сургуулийн түвшинд**

- ❖ Сургууль бүрт хүүхдийн оролцооны байгууллагын техник, тоног төхөөрөмж бүхий тогтмол өрөө, танхимтай болгож, сурагчдын оролцооны байгууллага болон сурагчдын саналын дагуу үйл ажиллагааны зардлыг баталж, сургуулийн төсөвт тусгай зардал болгон оруулах шаардлагатай.
- ❖ Сургуулиудын багш удирдлага, хүүхдийн оролцооны байгууллага болон сурагчдын төлөөллийн дунд орон нутгийн шийдвэр гаргах түвшинд оролцуулах аргад сургах, чадавхижуулах сургалтыг улиралд нэг удаа дүүрэг тус бүрт нэгдсэн байдлаар зохиох ажлыг дүүргийн хүүхэд залуучууд хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах, мөн зардлыг дүүргийн төсөвт суулгуулах нь хэрэгцээтэй байна.
- ❖ Хүүхдийн эрх ашигт холбоо бүхий асуудалд хүүхдийн саналыг сонсдог, зөвлөлддөг, хамтран шийдвэр гаргадаг нэгдсэн чуулганыг улирал бүр зохион байгуулж, түүний үр дүнг олон нийтэд мэдээлэх, шийдвэр гаргагч нарт уламжлах ажлыг дүүргийн хүүхэд залуучуудад хариуцсан мэргэжилтний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байна.

### **Хорооны түвшинд**

- ❖ Хороонд хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн бий болгож, хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр тодорхой үүргийг ажлын чиг үүрэгт нь тусгаж өгөх. Хорооны түвшинд хүүхдийн оролцох эрхийг хангахад тулгамдаж буй бэрхшээл нь

юуны өмнө хорооны засаг дарга болон нийгмийн ажилтан зэрэг албан тушаалтнуудын чиг үүрэгт хүүхдийг шууд хариуцан ажиллахаар тусгагдсан зүйл, заалт байхгүй мөн хэдий нэмж тусгасан ч ажлын ачааллын хувьд хүүхэдтэй ажиллах нөөц хомс байна.

- ❖ Хороонд ажиллаж байгаа хүүхдийн өөрөө удирдах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тодорхой тусгаж өгөх. Зарим хороонд хэдийгээр хүүхдийн өөрөө удирдах зөвлөл ажиллаж байгаа ч өөрийн гэсэн ажлын өрөө болон үйл ажиллагааны тогтмол зардал байхгүй тул үйл ажиллагаа нь албан бус, сайн дурын шинжтэй болоод байна. Иймд зөвлөлийн үйл ажиллагааг тогтвортой үйл ажиллагааг хангах үүднээс хорооны жилийн төлөвлөгөөнд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг тодорхой тусгах.
- ❖ Хорооны мэргэжилтэнүүдийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хандлагыг эерэг болгох. Хүүхдийн оролцоонд тулгарч буй нэг бэрхшээл нь хорооны мэргэжилтэнүүдтэй харилцах айдас юм. Иймд хүүхдийн оролцоог дэмжих, эерэг хандлагатай болгох үүднээс хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах.
- ❖ Хорооны иргэний тэнхимд хүүхдийн өөрөө удирдах зөвлөл сард нэг удаа хүүхдийг хамруулсан хэлэлцүүлэг зохион байгуулдаг байх. Шинэчлэгдсэн засгийн газрын зүгээс иргэний тэнхимд хүүхдүүд өөрсдөө хэлэлцүүлэг зохион байгуулдаг байх шаардлагатай. Ингэснээр хүүхдийн санал бодол бодит ажил болон хэрэгжих боломтой. Энэ хэлэлцүүлгээс гарсан саналыг хорооны иргэдийн хурлын тэргүүлэгч удирдлагад танилцуулан, эргээд хүүхдүүдэд үр дүнгийн талаар мэдээлдэг байх шаардлагатай. Энэ үйл явцыг хорооны төлөвлөгөөнд тусгах нь бодит ажил болно.
- ❖ Хорооны түвшинд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх шийдвэр гаргач нарын ажлын цагийн хуваарьт хүүхдийг хүлээн авдаг өдөр, цагийг бий болгох, саналыг хүлээн авах нээлттэй утастай байх.
- ❖ Хорооны үйл ажиллагааны чиглэл, бүтэц мөн үйлчилгээний төрлийн талаар хүүхдүүдэд зориулсан танилцуулга бий болгох. Хүүхэд хорооны талаар ямар нэгэн мэдээлэлгүй байгаа нь тэднийг оролцоход хүндрэл учруулж байна. Иймд байнгын танилцуулгыг бий болгож, хүүхдүүдэд тараах, таниулах үйл ажиллагааг зохион байгуулах

### **Дүүргийн түвшинд**

- ❖ Дүүргийн түвшинд хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх шийдвэр гаргагч нарын ажлын цагийн хуваарьт хүүхдийг хүлээн авдаг өдөр, цагийг бий болгох, саналыг хүлээн авах нээлттэй утас, вэб сайт, санал хүсэлтийн хуудсыг тогтмолжуулах, түүний зардлыг дүүргийн төсвөөс гаргах
- ❖ “Дүүргийн хүүхдийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны төсвийг хүүхдийг оролцооны байгууллага болон зөвлөлөөр тодорхойлуулж, зардлыг дүүргийн төсөвт батлуулж, хүүхэд залуучуудын хэлтсээс тогтмол үйл ажиллагааг хянах, чиглүүлэх үүргийг ажлын чиг үүрэгт тусгах
- ❖ Дүүргийн түвшинд олон нийтэд мэдээлэл түгээх үүрэг бүхий мэдээллийн сүлжээг санал авах утас, мэдээлийн самбар, сонин, вэб сайтаар дамжуулан хүүхдийн оролцоог сурталчилах, дүүргийн засаг даргын вэб сайтад “Хүүхэд” буланг

байршуулж, тогтмол мэдээллийг шинэчлэх үүргийг дүүргийн хүүхдийн зөвлөл болон дүүргийн хүүхэд, залуучууд хариуцсан мэргэжилтнүүдийн ажлын чиг үүрэгт суулгах

### **Нийслэлийн түвшинд**

- ❖ Нийслэлийн засаг захиргааны удирдах ажилтнуудад хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах нь зүйтэй. Нэн тэргүүнд орон нутаг, нийгмийн шинж байдал нь өөр түвшний хүүхдүүдтэй хамтарсан форум зохион байгуулж, түүндээ дээрх удирдах ажилтнуудыг оролцуулах шаардлагатай байна.
- ❖ Нийслэлийн засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв, үр дүнгийн гэрээнд НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенцын 12-р заалтыг тодорхой үйл ажиллагаа болгож тусгах хэрэгтэй байна.
- ❖ НИТХ-д хүүхдийн эрх ашгийг хамгаалах хороо байгуулах нь зүйтэй. Энэ нь харьяа орон нутгийн салбар бүрт адил байх нь зүйтэй.
- ❖ Хороо, дүүрэг, нийслэлийн түвшин бүрийн “Иргэний танхим”-д хүүхдийн эрх ашигтай холбоотой мэдээ, мэдээлэл бүхий хэсэг бий болгох, мөн түүнчлэн энэ танхимд хүүхэд өөрт холбоотой асуудлаар санал бодлоо хэлж, оролцох боломжийг бүрдүүлсэн журмыг холбогдох төрийн байгууллагууд, мэргэжлийн зөвлөхүүдтэй хамтран боловсруулах шаардлагатай байна.
- ❖ Хороо, дүүрэг, нийслэлийн түвшин бүрийн “Иргэний танхим”-ын жилийн хэлэлцэх сэдэвт хүүхдийн эрх ашигтай холбоотой асуудлаар хүүхдүүд болон хүүхдийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын төлөөлөл хамгийн багадаа 4 удаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах хэрэгтэй.



## **ХАВСРАЛТ 1: СУДАЛГААНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЖАГСААЛТ, БАЙРШЛААР**

### **Нийслэл болон олон улсын байгууллагын түвшин дэх оролцогч талууд**

1. Баавгай. Н, ХТҮГ-ын Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар
2. Баатархүү. Ц, Нийслэлийн Засаг даргын хүн
3. Баттүвшин. Б, НИТХ-ын Ажлын албаны Иргэний Оролцооны хэлтсийн дарга
4. Дагва. Р, НИТХ-ын төлөөлөгч, СХД-ийн засаг даргын орлогч
5. Мөнхзаяа.н, Нийслэлийн Боловсролын Газрын Албан бус боловсрол, сурагчдын хөгжил боловсрол хариуцсан мэргэжилтэн
6. Наранбаатар. Л, НИТХ, Нийслэлийн иргэдийн хурлын төлөөлөгч
7. Ц. Сандаг-Очир, НИТХ-ын төлөөлөгч, Багануур дүүргийн засаг дарга
8. Сэргэлэн.н, НИТХ-ын Ажлын албаны Нийгмийн бодлогын ажилтан
9. Шийлэгпүрэв.Ж, Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын, хэлтсийн дарга

### **Дүүргийн түвшин дэх оролцогч талууд**

10. Д. Тунгалаг, Налайх дүүргийн хүүхэд, залуучууд хариуцсан мэргэжилтэн
11. Б. Наранбаяр, Налайх дүүргийн “Хүүхэд хөгжлийн төв”-ийн дарга
12. Ч. Батбаатар, Налайх дүүргийн боловсролын хэлтсийн мэргэжилтэн
13. Ө. Түмэндэлгэр, Сонгинохайрхан дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс
14. Гэрэлцэцэг.н, Сонгинохайрхан дүүргийн боловсролыг хэлтэс
15. Галбадрах.н, Чингэлтэй дүүргийн боловсролын хэлтэс
16. Дашренчин.н, Чингэлтэй дүүргийн нийгмийн хөгжлийн хэлтэс

### **Төрийн бус болон олон улсын байгууллагууд**

17. Баасанжав.Ж, БХИН-ийн Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжлийн хөтөлбөрийн захирал
18. Мандал.У, НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхдэд ээлтэй орон нутаг багийн ахлагч
19. Мөнхсайхан.н, Дэлхийн Зөн ОУБ-ын Хүүхдийн оролцоо хариуцсан мэргэжилтэн
20. Сарантуяа.О, Залгамжлагч Холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал
21. Сэлэнгэ. Монголын сурагчдын холбооны тэргүүн
22. Ууганбаяр.Д, МУЗН-ийн Хүүхэд залуучуудын хөдөлгөөний ерөнхий зохицуулагч

### **Хорооны түвшин дэх оролцогч талууд**

23. Б. Х. Батаа, Налайх дүүрэг, 3-р хорооны зохион байгуулагч
24. Ц.Пүрэвдулам, Налайх дүүрэг, 3-р хорооны нийгмийн ажилтан
25. С.Нэргүй, Налайх дүүрэг, 3-р хорооны Иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгч
26. Х. Баярсайхан, Налайх дүүрэг, 1-р хорооны засаг дарга
27. Болдбаатар.н, Налайх дүүрэг, 1-р хорооны нийгмийн ажилтан
28. С. Нямжав, Чингэлтэй дүүрэг, 13-р хорооны засаг дарга
29. Б.Ижилмаа, Чингэлтэй дүүрэг, 13-р хорооны нийгмийн ажилтан
30. Ц. Рэнцэндорж, Чингэлтэй дүүрэг, 13-р хорооны Иргэний Нийтийн Хурлын тэргүүлэгч
31. Ч.Болормаа, Чингэлтэй дүүрэг, 6-р хорооны засаг дарга
32. Ж.Мөнхбаяр, Чингэлтэй дүүрэг, 6-р хорооны нийгмийн ажилтан

33. С.Сэдэд, Чингэлтэй дүүрэг, 6-р хорооны Иргэн Нийтийн Хурлын төлөөлөгч
34. Э.Сарантуяа, Сонгинохайрхан дүүрэг, 8-р хорооны засаг дарга
35. Ч.Ундрах, Сонгинохайрхан дүүрэг, 8-р хорооны нийгмийн ажилтан
36. Нармандах.н, Сонгинохайрхан дүүрэг, 8-р хорооны Иргэдийн Нийтийн Хурлын Төлөөлөгч
37. Х.Эрдэнэтуяа, Сонгинохайрхан дүүрэг, 14-р хорооны засаг дарга
38. С. Мөнхтөр, Сонгинохайрхан дүүрэг, 14-р хорооны нийгмийн ажилтан
39. Т.Амардэлгэр, Сонгинохайрхан дүүрэг, 14-р хорооны иргэдийн нийтийн хурлын төлөөлөгч

#### **Сургуулийн түвшин дэх оролцогч талууд**

40. Баяржаргал.н, Сонгинохайрхан дүүрэг, 79-р сургуулийн захирал
41. Бямбаа.н, Чингэлтэй дүүрэг, 49-р сургуулийн захирал
42. Бурмаа.н, Чингэлтэй дүүрэг, 49-р сургуулийн нийгмийн ажилтан
43. Бааст.н, Чингэлтэй дүүрэг, 5-р сургуулийн захирал
44. Булганчимэг.н, Чингэлтэй дүүрэг, 5-р сургуулийн нийгмийн ажилтан
45. Батцэцэг.н, Налайх дүүрэг, Голомт цогцолбор сургуулийн захирал
46. А. Ардак, Налайх дүүрэг, Голомт цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан
47. Нансалмаа.н, Налайх дүүрэг, Эрдмийн оргил цогцолбор сургуулийн захирал
48. С.Ганбат, Налайх дүүрэг, Эрдмийн оргил цогцолбор сургуулийн нийгмийн ажилтан
49. Ургац.н, Сонгинохайрхан дүүрэг, 67-р сургуулийн нийгмийн ажилтан
50. Р.Дүгэрсүрэн, Сонгинохайрхан дүүрэг, 105-р сургуулийн захирал
51. Б.Энхтуул, Сонгинохайрхан дүүрэг, 105-р сургуулийн нийгмийн ажилтан
52. Д. Цэрэнчимэд, Сонгинохайрхан дүүрэг, Ирээдүй цогцолбор 2-р ахлах сургуулийн нийгмийн ажилтан

#### **Судалгаанд оролцогч эцэг эхчүүд**

53. Бат-Эрдэнэ.н, Сонгинохайрхан дүүрэг
54. Ганчимэг.н, Чингэлтэй дүүрэг
55. Даваадулам.н, Налайх дүүрэг
56. Эрдэнэсүвд.н, Налайх дүүрэг
57. Энхзул.н, Налайх дүүрэг
58. Мария.н, Налайх дүүрэг
59. Оюунсайхан.н, Налайх дүүрэг
60. Өлзийжаргал.н, Чингэлтэй дүүрэг
61. Цэцэгмаа.н, Налайх дүүрэг
62. Мягмарсүрэн.н, Налайх дүүрэг
63. Сосормаа.н, Налайх дүүрэг
64. Ундрал.н, Сонгинохайрхан дүүрэг
65. Уянга.н, Чингэлтэй дүүрэг
66. Эрдэнчимэг.н, Сонгинохайрхан дүүрэг
67. Даариймаа.н, Сонгинохайрхан дүүрэг
68. Уранчимэг.н, Чингэлтэй дүүрэг

69. Дордов.н, Чингэлтэй дүүрэг
70. Оюун-Эрдэнэ, Чингэлтэй дүүрэг
71. Пүрэвдорж.н, Сонгинохайрхан дүүрэг
72. Сосорбарам.н, Чингэлтэй дүүрэг
73. Сувд.н, Сонгинохайрхан дүүрэг
74. Сэлэнгэ.н, Чингэлтэй дүүрэг
75. Энэрэл.н, Сонгинохайрхан дүүрэг